

АГУУЛГА

- Г. Далайжамц, Д. Чимэддулам
Зохистой аюулгүй хоол хүнсээр жигд, хүртээмжтэй хангагдах эрхийн тухайд /төгсгөл/ 3
- П. Оюунчимэг
Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон шийтгэгдсэн хохирогчийн эрхийн асуудалд 13
- Н. Отгончимэг
Нутгийн удирдлагын байгууллагын шийдвэр ба бизнес эрхлэгчдийн эрх ашиг 19
- Б. Батзориг
Эрүүгийн хэргийг нотлох ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг дээдлэх зарчмыг хангахад анхаарах асуудалд 25
- Б. Оюутболд
Хүний эрх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь таслан сэргийлэх арга хэмжээ 29
- Манфрэд Новак
Ярилцлага 33
- ХЭҮК-оос эрдэмтэн судлаачдын дунд зарласан “Монголын зан заншил соёлын хүчин зүйлс эмэгтэйчүүдийн эрхэд нөлөөлж байгаа нь” сэдэвт илтгэлийн уралдаанд 1-р байр эзэлсэн илтгэл 38
- ХЭҮК-оос насанд хүрэгчдийн дунд зарласан “Үндэстний цөөнхийн эрхийн асуудал Монголд” сэдэвт эссений уралдаанд 1-р байр эзэлсэн эссе 46
- ХЭҮК-оос 8-10 дугаар ангийн сурагчдын дунд зарласан “Миний мэдэх үндэстний цөөнх” сэдэвт зохион бичлэгийн уралдааны 1-р байр эзэлсэн зохион бичлэг 49
- Орон нутгийн хүний эрхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нараас ирүүлсэн товч мэдээлэл /Архангай, Говь-Алтай, Төв аймаг/ 51
- Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, 2005 он 55
- “ХЭҮК ба Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт Бага хуралд оролцогчдоос Монгол улсын Засгийн газарт хандаж гаргасан шаардлага 92
- “Хүний эрхийг хангах, хамгаалахад орон нутгийн байгууллагуудын үүрэг” сэдэвт сургалтад оролцсон (Баян-Өлгий, Ховд, Увс) оролцогчдын уриалга 93

CONTENT

- G. Dalaijamts, D. Chimeddulam
Right to an adequate food /continue/ 3
- P. Oyunchimeg
Rights of illegally arrested, detained and punished 13
- N. Otgonchimeg
Business and decisions by local authorities 19
- B. Batzorig
Ensuring human rights and freedoms in the criminal procedure 25
- B. Oyutbold
Human rights and preventive measures 29
- Manfred Nowak
Interview 33
- **Best composition on “Womens rights and Mongolian cultural issues” announced by NHRC among researchers** 38
- **Best composition on “Minority rights” announced by NHRC among adults** 46
- **Best essay on “National minority” announced by NHRC among secondary school students** 49
- **Brief report by Local Human Rights Experts** 51
- **Report on human rights and freedoms in Mongolia by NHRC, 2005** 55
- **Requirement to the Mongolian Government released by the participants from NHRC and Human rights NGO’s Conference** 92
- **Appeal by participants from Bayan-Ulgii, Khovd and Uvs aimags in the workshop “Responcibilities of local authorities in protection and provision of human rights”** 93

ЗОХИСТОЙ АЮУЛГҮЙ ХООЛ ХҮНСЭЭР ЖИГД, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАНГАГДАХ ЭРХИЙН ТУХАЙД

/ТӨГСГӨЛ/

Г.Далайжамц, ХЭҮК-ын гишүүн
Д. Чимэддулам, ЭМШУИС-ын НЭМС-ийн багш

3.2. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын өнөөгийн төлөв¹

Чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор хувийн үйлдвэрүүд олноор бий болж, мэргэжлийн бус хүмүүс хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэн явуулах болсноор хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн дунд нийтлэг зөрчил, дутагдал илэрч байна. Тухайлбал:

Мөрдөгдөж буй хууль эрхийн акт, дүрэм журмыг үйлдвэрлэгч, борлуулагчид жигд мөрдөхгүй байгаагаас чанарын шаардлага хангахгүй хүнс үйлдвэрлэх, тээвэрлэлт, хадгалалтын үед муутгаж хүний эрүүл мэнд, үлэмж хохирол учруулах явдал гарсаар байна.

Хүнсний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага сул, учирсан хариуцлагыг тооцох механизм төгөлдөр болж чадаагүй байна.

Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зарим нэгжүүд зөвхөн орлого хөөцөлдөх явдлыг урьтал болгож хадгалалтын хугацаа богинотой, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн шаардлага хангаагүй зориулалтын бус агуулах, төхөөрөмжид хадгалж, тээвэрлэн, худалдаалж байгаа нь хүн амын дунд хоол хүнсний хордлого, харшил гарах нөхцөлийг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулж болзошгүй байна.

◆ Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал.

Хүнсний бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүд өмнөх онуудтай харьцуулахад ерөнхийдөө өссөн байгаа нь хүн амын хүнсний аюулгүй байдал алдагдаж, улмаар хоол хүнсээр дамжих өвчлөл ихсэхэд шууд нөлөөлж байна.

2004 онд УМХГ-ын хүнсний хяналт, шинжилгээнд 97451 дээжинд 238073 үзүүлэлт шинжлэгдсэний 16455 буюу 17%, хүнсний түүхий эдийн 463 дээжийн 182 буюу 39% нь тус тус бохирдолтой гарсан байна. Үүнийг өмнөх онуудтай харьцуулахад химийн бохирдол 2002 оныхоос 2 дахин, хор судлалын шинжилгээгээр бохирдолтой дээжийн хувь 2000 оныхоос 0.2%-аар, 2002 оныхоос 0.8%-аар, нянгийн бохирдол 2000 оныхоос 0.2-аар, 2002 оныхоос 8%-аар, хүнд металлын бохирдол 2000 оныхоос 0.5-аар тус тус өссөн байна.²

Хүнсний бүтээгдэхүүний хор судлалын шинжилгээгээр ихэвчлэн элэгний хорт хавдрын гол шалтгаан болдог хөгц мөөгөнцрийн хорыг тодорхойлдог бөгөөд энэ

¹ Үргэлжлэл. Уг сэтгүүлийн өмнөх дугаарт эхний хэсэг нь хэвлэгдсэн болно


² УМХГ-ын Хүнсний хяналтын 2004 оны тайлангаас

үзүүлэлт сүүлийн жилд ихсэх хандлагатай байгаа нь хорт хавдрын ихсэхэд нөлөөлж болох талтай.

Нэгдсэн төв лабораторийн хөгц мөөгөнцрийн шинжилгээнд 1040 дээж хамрагдсаны 6.8% нь хөгц мөөгөнцрийн бохирдолтой гарсны дотор цай, кофе, какао, үр тариа, улаан буудайн дээж хамгийн их бохирдолтой гарчээ. Хорт хавдар үүсгэх, үр хөврөл гэмтээх, удамшилд аюул учруулах өвчин үүсгэдэг 150 гаруй хөгц мөөгөнцөр байдгаас өнөөгийн байдлаар лабораторийн шинжилгээгээр зөвхөн 13 төрлийн хөгцийг хоол хүнснээс илрүүлж чадаж байна.

УМХГ-ын мэдээгээр 2004 онд хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй 7578 ширхэг, 2091060.1 л, 671620.2 кг хүнсний бүтээгдэхүүнийг хүн амын хүнсний хэрэгцээнээс хасч устгах арга хэмжээ авчээ. Үүнийг өмнөх жилүүдийн устгасан хүнсний бүтээгдэхүүнийг мөнгөн дүнгээр илэрхийлбэл 1997 онд 19.5 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хүн амын хүнсний хэрэгцээнээс хасч устгаж байсан бол 2003 онд 231.5 сая төгрөг болж даруй 11.9 дахин өссөн байна. (Зураг1)

Зураг 1. Хүнсний хэрэгцээнээс хасч устгасан хүнсний бүтээгдэхүүн, төгрөгөөр



◆ **Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийн чанар, аюулгүй байдал.**

Манай орны малд бруцеллёз, боом, сүрьеэ зэрэг өвчний өвчлөл өндөр байна.

Хүн амын хоол хүнсний зүйлд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зонхилж байгаа нөхцөлд мал, амьтны мах, сүүгээр дамжин хүний эрүүл мэндэд хожмын нөхөгдөшгүй уршиг учруулдаг хор нөлөө бүхий антибиотик, даавар, хөгцний зүйл, түүний хорын түвшинг стандартаар зохицуулж тодорхойлох асуудал манайд хийгдэхгүй байна.

Худалдан борлуулж байгаа нийт махны 25% нь мал эмнэлгийн шинжилгээнд хамрагдаагүй, мах худалдан борлуулах зах, худалдааны цэг, салбаруудын 40 орчим хувь нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ил задгай хог, шороо тоостой бохир орчинд, хөргөлтийн тоног төхөөрөмжгүй, худалдан борлуулагчид нь зориулалтын хувцас хэрэглэлгүйгээр худалдаалж байна.

Мал, амьтны гаралтай мах, сүү, өндөг зэрэг түүхий эдүүдийг мал-эмнэлгийн үзлэг шинжилгээнд тэр бүр бүрэн хамруулж чадахгүй байгаа бөгөөд үзлэг шинжилгээг иж бүрэн хийж чадахгүй зөвхөн мэдрэхүйн эрхтнээр үнэлгээ өгч дүгнэлт гаргаж байгаа дутагдал ажиглагдаж байна.

Гар дээрээс зарагдаж байгаа сүү нь хувиараа мал аж ахуй эрхэлж буй хувь хүмүүсийн гэрийн нөхцөлд сааж, бэлтгэсэн сүү байдаг бөгөөд тэдний зарим нь сүүний тосыг нь машиндах буюу хөөрүүлж аваад, үлдсэн шингэн сүүг ус, түүхий

гурил зэргийг хольж арвижуулан, өтгөрүүлж зардаг байна. Мөн зах,лангуун дээр худалдаалагдаж буй ихэнх ааруул, хуруудыг мөн шар усыг гүйцэт аваагүй аарц нэртэй цагаанд түүхий гурил хольсон байдаг аж. Судлаачдын үзэж буйгаар түүхий гурил нь сүүний сахартай холилдохоороо сахарын этилийн спирт үүсэх процесс улам түргэсгэж, улмаар улаан хоолой, ходоодны хорт хавдар үүсгэдэг байна.³

◆ **Ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал.**

Ургамлын гаралтай бүтээгдэхүүний түүхий эдэд ургамал, хорио цээрийн шинжилгээгээр илрүүлдэг хог ургамал, ургамлын өвчин, хөгц мөөгөнцөр, хортон шавьж, мэрэгч зэрэг нь түүхий эдийг бохирдуулснаар бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж, үр тарианы гарцыг эрс бууруулдаг байна.

УМХГ-ын Нэгдсэн төв лабораторийн Таримал ургамлын үр, хорио цээрийн хяналтын лабораторийн 2004 оны тайлангийн мэдээгээр 10 аймаг, 86 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн 13103.9 тн үр, үрийн материалыг төлөөлөх 592 дээжинд шинжилгээ хийсний дотор тарих үрийн 566, технологийн 3, хүнсний буудайн 11 дээжийг шинжлэхэд 97.8% нь стандарт, чанарын шаардлага хангаагүй байна.

Шинжилгээгээр улсын нөөцийн агуулахад хадгалагдаж байгаа 9750.1 тн үр тариаг төлөөлөх 120 дээжинд 3 төрлийн хог ургамал 2450 ш/кг хүртэл хэмжээгээр, 5 төрлийн ургамлын өвчин 1-49% хувь хүртэл, агуулахын хачиг амьд, үхсэн хэлбэрээр, номын бөөс зэрэг хөнөөлт шавьж илэрчээ.

Энэ байдал нь ирээх жилийн газар тариалангийн үр өгөөжид сөргөөр нөлөөлж, үр тарианы ургацыг эрс бууруулж, үр тариа болон гурил, түүний бүтээгдэхүүний чанарт муугаар нөлөөлөх нь дамжиггүй юм. Ингэснээр хоол хүнсний хомсдол дараа дараагийн жилд арилахгүй байх нэг шалтгаан болж байна.

◆ **Импортын хүнсний аюулгүй байдал.**

2003 онд 31 улсаас 27 төрлийн 146 нэрийн 81.138.2 тн хүнсний бүтээгдэхүүнийг импортолсны дөнгөж 16.4% нь лабораторийн шинжилгээнд хамрагджээ. Эдгээрээс химийн шинжилгээгээр шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний 31.2%, хор судлалын шинжилгээгээр 0.6%, нян судлалын шинжилгээгээр 5.3% нь хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй байна.

2004 оны эхний хагас жилийн байдлаар УМХГ-ын харьяа 23 лабораторид 53472 хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийсний 18% нь импортын хүнсний бүтээгдэхүүн эзэлж байгаа ба 120741 үзүүлэлтээр шинжилсний 16.7% нь чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй байна. Төрөлжсөн 6 лабораторид хийгдсэн шинжилгээний үзүүлэлтээр хөгц мөөгөнцрийн лабораторийн шинжилсэн сорьцын 18.9% хөгц мөөгөнцөрөөр бохирдсон байсан ба үүнийг хүнсний нэр төрлөөр нь авч үзэхэд цай кофе, какаоны 16.7%, жимс, жимсгэний 11%, бусад бүтээгдэхүүний 38.5%-д нь бохирдол илэрсэн байна.

Нийт импортлогдож буй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний 80 гаруй хувийг БНХАУ-аас оруулж байна.

НЭМХ-ээс явуулсан судалгаагаар БНХАУ-аас импортолсон хүнсний ногооны 113 дээжийн 33 буюу 29.2% нь нитратыг ЗДХ-ээс ихээр агуулсны дотор төмсний

³ Д.Пүрэвэ, Сүү, цагаан идээний үйлдвэрлэлийн “Сангийн далай” ТББ

дээж хамгийн их хувийг буюу 42.4%-ийг эзэлж, түүний дараа лууван (36.4%), байцаа (15.1%) зэрэг нь нитратын бохирдолт ихтэй байв. Нитрат нь хүний биед хорт хавдар үүсгэдэг нитрозаминуудын урьдал нэгдэл болдог бөгөөд орчин үед хорт хавдар үүсгэдэг 100 гаруй нитрозонэгдлүүдийг судалсны зарим нь ходоодонд сонгомлоор үйлчилдэг болохыг нотолжээ.

◆ Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуй, халдвар хамгааллын байдал.

УМХГ-ын 2004 оны 1-р улиралд хүнсний эрүүл ахуйн хяналт шалгалтанд хамрагдсан нийт байгууллагын 36.2% нь хүнсний дэлгүүр, 34.5% нь хоол үйлдвэрлэл, 4.1% нь гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр, үлдсэн хувь нь архи, пиво, ус, ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, талх, талхан бүтээгдэхүүний үйлдвэр болон хүнсний төв (супермаркет), агуулах эзэлж байна.

2003 оны эхний 6 сарын байдлаар нийслэлийн хүнсний 16 худалдааны төв, зах ажиллаж байгаагийн 60 гаруй хувь нь зориулалтын бус байртай, 27% нь ажилчдын хувцас солих өрөөгүй, 47% нь агаарын температурыг зохицуулах төхөөрөмжгүй, 20% нь онцгой түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах хөргүүргүй нөхцөлд худалдаалж байв.

Улаанбаатар хотод 2003 оны байдлаар хүнсний чиглэлийн ажил, үйлчилгээ эрхэлж буй 7085 объектын 26%-ийг түргэн үйлчилгээний цэг (ТҮЦ), 3.3%-ийг чингэлэг эзэлж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаа алдагдах, улмаар хүн амын дунд халдварт өвчин нэмэгдэх гол хүчин зүйл болж байна.

ДӨРӨВ. ХООЛ ТЭЖЭЭЛ, ТҮҮНИЙ ШИМТ ЧАНАРТАЙ ХОЛБООТОЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛ (NUTRITION AND RELATED HEALTH RISKS)

Хоол тэжээлийн дутагдал, илүүдэл нь хүн төрөлхтөнийг зовоож буй олон өвчин эмгэгийн шалтгаан болж байна. Манай улсын хүн амын дунд хоол тэжээлийн дутал болон илүүдэлээс үүдэлтэй эмгэгүүд аль аль нь тохиолдож байна. Хоол тэжээлийн дутал нь ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхний дунд уураг илчлэгийн дутал (УИД), цус багадалт, сульдаа, иод дутлын эмгэг (ИДЭ) зэрэг хэлбэрээр илэрч буй бол илүүдэл нь таргалалт, судасны хатуурал, цусны даралт ихдэх, харвалт, инсулин үл хамааралт чихрийн шижин, хавдар зэрэг хэлбэрээр тохиолдож байна.

Хоол тэжээлийн дутлын улмаас бага насны хүүхдийн оюуны болон биеийн хөгжил хоцорч улмаар тэдний ойлгох, санах, тогтоох чадвар аажим суларч, сурах чадварт сөргөөр нөлөөлдгийг дэлхий дахины олон судлаачид тогтоожээ. Мөн биеийн эсэргүүцэл сулран халдварт амархан өртөж олон дахин өвчлөх ба өвчин нь ужиг явцтай, дахих хандлагатай байдаг.

4.1. Хоол тэжээлийн талаар төрөөс авч буй арга хэмжээ

Хүн амын хоол тэжээлийн талаарх манай улсын хууль, эрх зүйн гол баримт бичиг бол Хүнсний тухай хууль (1999 оны) юм. Уг хуулийн хүн амын “хүнсний хэрэгцээг хангана” хэмээн дэвшүүлсэн санаа нь хүний бие махбодийн өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах шим тэжээл бүхий

хүнсний түүхий эд, бэлдэц, хоол, идээ, ундаа, ундны усаар хангах гэсэн ойлголтыг багтааж байна.

Хүнсний тухай хуулийн хоол тэжээлийн хэрэгцээг хангах ойлголт зориулалтын хүнс, стратегийн хүнс, хүнсийг баяжуулах гэсэн асуудлууд орсон байна. “Зориулалтын хүнс”-ийг энэхүү хуулийн 3.1.5-д “хүний эрхэлж байгаа хөдөлмөр, бие махбодийн онцлогт тохируулан, эсхүл эмчилгээний зориулалтаар тусгайлан бэлтгэсэн хүнсийг хэлнэ” хэмээн тодорхойлж, 5.1.7-д Засгийн газар зөвхөн уг асуудлыг судлахаас өөр бусад зориулалтын хүнсийг хэрхэн бэлтгэж, хангах асуудлыг орхиод зогсохгүй “зориулалтын хүнс хэрэглэгч” гэж хэн байхыг ч тодорхойлоогүй байна.

Мөн уг хуулинд хүүхдийн хоол тэжээлтэй холбоотой нэг ч заалт байхгүй байгаа нь хүүхдийн хоол тэжээл, түүний хангамж, хүрэлцээний асуудал үндсэндээ төрийн зохицуулах ёстой үүрэгт огт хамаарагдахгүй болсон байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай 1996 оны хуулийн 5 дугаар зүйлийн 2-т “Хүүхдийн эрүүл мэнд өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, хүчирхийллээс ангид байх эрх”-ийг баталгаажуулж, хүүхдийг хувцас, хоол хүнс, ... зэргээр санаатай гачигдуулахыг хориглосон байна. Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 4-ийн 3-т хүүхдийн өсөлт хөгжилт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн баталгаат хоол хүнс ... зэргээр хангах асуудлыг хүүхдэд үзүүлэх нийгмийн халамжийн арга хэмжээнд тусгажээ.

Манайд “Бичил тэжээлийн далд өлсгөлөн”, түүний дотор Иод дутлын эмгэг бодитойгоор оршиж буйг төр онцгойлон анхаарч бодлого, хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд “Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай” хуулийг 2003 оны 10 дугаар сарын 10-ны өдөр баталж, иод дутлын эмгэгтэй тэмцэх үйл ажиллагааг хуулиар зохицуулжээ.

Хүн амын хоол тэжээлийн байдлыг 2001 оны Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, 2003 оны Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, 2004 оны Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого зэрэг төрөөс баримтлах хэд хэдэн бодлого стратегид тусган хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд ажиглалт хийхэд эхний арга хэмжээ болон насанд хүрсэн хүн амын хоол тэжээлийг сайжруулахаар төлөвлөсөн арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Үүний шалтгаан нь уг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх санхүүжилтийн гол эх үүсвэрийг улсын төсвөөс жил бүр төсөвлөн гаргах ёстой байтал санхүүжилт огт хийгдээгүйгээс санхүүгийн эх үүсвэргүй болсонтой холбоотой аж.

Хөтөлбөрийн “Цэцэрлэгийн насны болон өсвөр үеийн хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах стратеги боловсруулан хэрэгжүүлэх” арга хэмжээний хүрээнд 2002-2003 онд Цэцэрлэгийн насны болон өсвөр насны хүүхдийн хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлыг судалж, үнэлгээ өгсөн боловч цаашид авах арга хэмжээний зөвлөмж, аргачлал боловсруулаагүй байна.

Хөтөлбөрт эмзэг бүлгийн хүн амын хоол, тэжээлийн байдлыг сайжруулах зорилт дэвшүүлсэн боловч энэ талаар орон нутгийн сан байгуулах, энэ чиглэлийн үйл ажиллагааг орон нутгийн төсөвт тусгахад орон нутгийн удирдлагуудын оролцоо, санаачлага хангалтгүй байгаагаас уг зорилт хэрэгжихгүй байна.

Монгол улсын засгийн газраас 2002 оны 12 дугаар сарын 4-ний 245 тоот тогтоолоор батлан гаргасан “Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрийн 5-р зорилт нь хүүхэд, өсвөр үеийнхний зохистой хооллолтыг дэмжих, аюулгүй хоол хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа бөгөөд энэ зорилтын хүрээнд авах арга хэмжээг 2003-2004 онд хэрэгжүүлж дуусгасан байхаар төлөвлөжээ.

Гэтэл хүүхэд өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээнд нийцсэн шимт чанар сайтай, аюулгүй хоол хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн дагнасан сүлжээ байгуулагдаагүй, холбогдох үйл ажиллагаанд Засгийн газрын хөрөнгө төсөвлөгдөж, зарцуулагдахгүй байна.

4.2. Хоол тэжээл, түүнтэй холбоотой өвчлөлийн өнөөгийн байдал.

◆ 5 хүртэлх насны хүүхдийн хооллолтын байдал

Хүүхдийн хөхөөр хооллолт - Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих талаар 1980 оноос хойш 14 удаа хэлэлцэж шийдвэр гаргажээ. Тухайлбал:

1989 онд “Хүүхдийн эрхийн тухай” Конвенци, 1992 онд “Хоол тэжээлийн тухай” Дэлхийн Тунхаглал зэргийг дурьдаж болно.

1991 онд Хүүхдийг хөхөөр хооллох бодлогыг хэвшүүлэх 10 зорилтыг хэрэгжүүлэх талаар Монгол улсын Эрүүл Мэндийн сайдын тушаал гарч, “Хүүхдийг хөхөөр хооллох”, “Хүүхдэд ээлтэй эмнэлэг” санаачилга манай оронд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжих эхэлсэн байна.

Эхийн сүү нь төгс тэжээллэг чанартай бүтээгдэхүүн бөгөөд эхийн сүүнд хүүхдийн биед шаардлагатай уураг, өөх тос, нүүрс ус, амин дэм, бичил тэжээлийг хамгийн зохистой харьцаагаар агуулсан байдаг тул хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтийг бүрэн хангаж чаддаг. Хүүхдийг 6 сар хүртэл нь эхийн сүүгээр дагнан хооллох хэрэгтэй бөгөөд харин 6 сартайгаас нь эхлэн хүүхдэд нэмэгдэл хоолыг аажим дасган өгч эхлэх хэрэгтэй юм.

1995-1999 онуудад хүүхдийн хөхөөр хооллолтын байдлыг судалсан дүнгээс үзэхэд 2000 он хүртэлх 5 жилийн дунджаар нийт судалгаанд хамрагдсан хүүхдийн 92.6% нь төрсний дараа 30 минутын дотор хөхөө амлаж, эхний 4 сар хүртлээ дан хөхөөр хооллож байгаа хүүхэд 99.5%, үүнээс хойш ерөнхийдөө хөхөө хөхөх байдал ой хүртлээ бага багаар буурсаар, 2 нас хүртлээ нилээд буурах хандлагатай байна.

Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн (ЭСОБ) нь угжаар хооллолтыг нэмэгдүүлж, хөхөөр хооллолтыг бууруулахад нөлөөлөх нь - 1981 онд НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-ын санаачилгаар “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний маркетингийн олон улсын хууль” гарсан. Энэхүү хуулийн зорилго нь хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг хөхүүлэн дэмжих, хамгаалах, эхийн сүү орлуулагч буюу нялхсын сүү, сүүн тэжээлийг зөвхөн шаардлагатай үед зөв хэрэглэх байдлаар нялхсыг аюулгүй, шаардлага хангасан хоолоор хооллоход хувь нэмэр болоход оршжээ.

Угжаар хооллож буй хүүхэд, халдварт, ялангуяа суулгалт болон амьсгалын замын өвчин ээмгэг болон харшилд өртөмтгий, өвчлөмтгий болдог.

Тэгвэл 2001 онд ЭМЯ, НЭМХ-ийн ХСТ, НҮБ-ийн Хүүхдийн сангаас хийсэн “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний маркетинг, хэрэглээг тодорхойлох

судалгаагаар: Манай оронд сүүлийн 5 жилд 13 орны 543.7 тн эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн импортоор орж ирсэн нь урьдах онуудаас даруй 6.6 дахин ихэсчээ. Гэтэл манайд одоогоор ЭСОБ-ийг хянах, зохицуулах, хүүхдийг эхийн сүүгээр хооллолтыг дэмжих хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

ТАВ. ӨРХИЙН ХҮНСНИЙ ХАНГАМЖ БАТАЛГАА (HOUSEHOLD FOOD SECURITY)

Өрхийн хүнсний хангамж, баталгаа гэдэг нь жилийн туршид өрхийн бүх гишүүдийн хоногийн хоолны хэрэгцээг чанартай хоол хүнсээр зохих түвшинд хангахыг хэлнэ. Өрх гэр хоол хүнсээ “үйлдвэрлэл” ба “худалдан авах” гэсэн 2 үндсэн арга замаар хангаж чаддаг. Энэ 2 зам нь хоёул тохирох эх үүсвэр буюу орлого шаарддаг.

Өрхийн хүнсний хангамж, баталгаа алдагдахад нөлөөлөгч гол хүчин зүйл бол ядуурал юм. Бүх ядуу хүмүүс хоол хүнсний хомсдолтой байдаг бол ихэнх хоол хүнсний хомсдолд орсон хүмүүс ядуу байдаггүй. Хүний эрхийн ойлголтоор ядуу хүн гэдэг нь хоол хүнсээр хангагдах эрх, эрүүл байх эрх, сурч боловсрох эрх зэрэг олон эрхээ эдэлж чадахгүй байгаа хүнийг хэлнэ.

Манай улс ЭЗНСЭТОУ-ын Пактын хэрэгжилтийн талаарх ээлжит гурав дахь илтгэл (1998 он)-ийн “Тэжээллэг хүнсний хүртээмж болон ядуурлын байдал” хэмээх хэсэгтээ 1993 онд хийсэн түүвэр судалгаагаар ядуу өрхийн нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний зүйлийн илчлэг дунджаар 1240 ккал байсан нь физиологийн нормын 30 гаруйхан хувь болж байгаа бөгөөд өрхийн ам бүлийн эрүүл мэндэд ноцтой нөлөөлөх түвшинд хүрсэн байна. Дээрх өрхүүд хүнсэндээ орлогынхоо дийлэнхийг зарцуулдаг байна.” гэж бичсэн байдаг.

Хороо уг илтгэлийн хариуд 2000 онд Ерөнхий зөвлөмж гаргасан ба түүний 13-т “Оролцогч-улс Монголын бүх хүн амын 42%-ийг эзэлж байгаа хүүхдүүдэд ядуурлын үзүүлэх нөлөөллийн сөрөг үр дагаврыг зөөлрүүлж чадаагүйд Хороо зовниж байна.” гээд 14-т “Тэтгэврийнхэн, цөөн малтай малчид, өрх толгойлсон эмэгтэйчүүд, настайчууд, ажилгүйчүүд, хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийнхний хүнсний аюулгүй байдалд учирч буй аюулын тухай оролцогч-улсын мэдээг Хороо харамсан хүлээж авав.”... дээрх асуудлуудад Хороо сэтгэл түгшиж буйгаа илэрхийлээд дараахь зөвлөмжүүдийг өгсөн байдаг. Үүнд:

22. Оролцогч-улсыг цаашдаа ядуучуудад хөрөнгө зарцуулж, өөрийн ээлжит дөрөв дүгээр илтгэлдээ дээр дурдагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Хороонд мэдээлэхийг Хороо хичээнгүйлэн уриалж байна. Үүнтэй холбоотойгоор оролцогч-улс нь Хорооны №3 Санамжийн 12 дугаар хэсэгт заасны дагуу хөрөнгө мөнгөний онцгой гачаалыг үл харгалзан нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах үүрэг хүлээснийг Хороо сануулахыг хүсэж байна.

24. Оролцогч-улсыг хүн амын амин чухал хэрэгцээг хангахад тэргүүн зэргийн ач холбогдол өгөх, үүнд олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хандуулахыг Хороо хичээнгүйлэн уриалж ... байна” гэжээ.

Улс орон бүрт өрхийн хүнсний баталгаа нь зарим талаараа орлогын тэгш байдлыг шаардаж, газрыг хуваарилах болон үйлчилгээг хүргэх байдлаас хамаардаг байна. Өрхийн хүнсний хангамж, баталгаанд хэдийгээр өрхийн түвшин дэх

чадавхи хамгийн их нөлөөлдөг боловч үйлдвэрлэл, орон нутаг, үндэстэн болон олон улсын түвшин дэх үйл ажиллагаа бас нөлөөлдөг байна.

5.1. Ядуурал ба өрхийн хүнсний хангамж, баталгаа


Ядуу өрхийн хүнсний хангамж, баталгааг бүс нутгуудыг төлөөлж Улаанбаатар хот, Хэнтий, Дорноговь, Говь-Алтай, Архангай аймгуудын нийт 731 өрхөд асуулга судалгаа явуулж тогтоов. Судалгаанд нийт 731 өрхийн 3926 хүн ам хамрагдсан бөгөөд нийт өрхийн 263 буюу 36%-ийг өрх толгойлсон эмэгтэй эзэлж байна. Судалгаанд 18-аас доош насны 1842 хүүхэд хамрагдсан нь нийт судалгаанд хамрагдсан хүн амын 47%-ийг эзэлж байна. 5 хүртэлх насны хүүхэдтэй өрх судалгаанд хамрагдсан өрхийн 385 буюу 52.6%-ийг, нийт судалгаанд хамрагдсан хүн амын 14.3%-ийг 5 хүртэлх насны хүүхдүүд тус тус эзэлж байв. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 381 буюу 60% нь нэн ядуу, 209 буюу 32.5% нь ядуу өрх эзэлж байна.

Улсын хэмжээгээр хүн амын 36.1% нь буюу 100 хүн тутмын 36 нь хүнсний болон хүнсний бус зайлшгүй шаардлагатай хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй ядуу иргэд байгаагийн дотор ядуурлын хамралтын хүрээ хөдөөд хотоос мэдэгдэхүйц өндөр (хөдөөд 43%, хотод 30%) байна. Ядуу 9 хүний 5 нь сумын төв, хөдөөд, харин нийт ядуу хүн амын 1/3 нь хөдөөд (сумын төвөөс өөр газар) амьдарч байна. Ядуурлын энэ хандлага нь 1999-2002 онд жил дараалан зуд, ган болсноор малын тоо бараг 30 хувиар буурч, Монгол улсын макро-эдийн засагт өөрчлөлт гарсантай хамааралтай байна.

Өрхүүд сарын хоол хүнсээ янз бүрийн замаар олж авч байгаагаас дийлэнх нь ганц эх үүсвэрээс (68.8%) олж авч байна. Өрхийн хоол хүнсээ олж авдаг арга замуудыг авч үзвэл худалдан авах замаар ихэнх өрх (судалгаанд хамрагдсан өрхийн 84%) хоол хүнсээ олж авч байгаа бөгөөд харин нийт өрхийн 24.9% нь зээлээр, 11.8% нь гуйлгаар, 7.8% нь өөрийн аж ахуйгаас, 5.1% нь ах дүүгийн тусламжаар хоол хүнсээ олж авдаг байна. (Зураг 1.)

Хоол хүнсний хэрэглээг хүнсний бүтээгдэхүүний нэр төрлөөр нь авч үзвэл: гурил, гурилан бүтээгдэхүүнийг өрхүүд мах, махан бүтээгдэхүүнээс илүү түлхүү хэрэглэж, будаа, төмсгийг нийт өрхийн ердөө тал нь хэрэглэж байгаа бол монгол хүний гол эрүүл мэндийг тэтгэгч сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ эрс багасч, эрдэс бодис, аминдэмийн гол эх үүсвэр болсон жимс, жимсгэнийг хамгийн бага хэрэглэж байна.

Зураг 1. Өрхийн хоол хүнсээ олж авдаг арга замууд



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.

Зураг 2. Өрхийн хүнсний хангамж, баталгааг үнэлэх түвшин



Өрхийн сарын хоол хүнсэнд хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл нь тухайн өрхийн нэг гишүүнд сард оногдох орлогын хэмжээнээс хамаарч, өрхийн орлого нэмэгдэх тутам сард хэрэглэх хүнсний нэр төрөл олширч ($R_{xy}=0.4$; $P<0.01$) байна.

Хүнсний хангамж, баталгаа нийт өрхийн 35.3%-д нь алдагдаж, өлсгөлөнд хүчтэй нэрвэгдсэн байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна. (Зураг 2.)

Өрхийн хүнсний хангамж, баталгаа тухайн өрхийн орлогоос шууд хамааралтай ($R_{xy}=0.6$; $P<0.01$) байна. Өөрөөр хэлбэл, өрхийн орлого буурах тутам өрхийн хүнсний хангамж, баталгаа алдагдаж, улмаар нэн ядуу өрх өлсгөлөнд хамгийн их хүчтэй нэрвэгдэж байна.

Хүүхдийн хоол хүнсний хангамж баталгаа алдагдаж байгааг батлах асуултуудад нийт өрхийн 70.9% нь баталсан хариу өгсөн нь насанд хүрсэн бусад гишүүд (65.4%-ийнхээс илүү байна. Тухайлбал, нийт өрхийн 66.9%-д нь насанд хүрсэн гишүүд цадталаа иддэггүй байхад, нийт өрхийн 77.3%-д нь хүүхдүүд цадталаа иддэггүй байна. Энэ байдал нь “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 1.1-д заасан “*эцэг, эх асран хамгаалагч нь хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, амьдрах эрүүл саруул, аюулгүй орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс ... зэргээр хангах*” үүргээ биелүүлэхгүй байгаагийн нэг илрэл болой.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн ихэнх нь манай улсын нийгмийн эмзэг бүлэг болох ядуу, тэр дундаа нэн ядуу өрх эзэлж байсан бөгөөд ЭЗНСЭ-ийн Хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж №12-ын 28-д “*Оролцогч улс эдийн засгийн тэгшитгэл, эдийн засгийн уналт, цаг уурын хүчин зүйл болон бусад хүчин зүйлүүдээс шалтгаалан нөөцийн хязгаартай болсон үед хүртэл хүн амын эмзэг бүлэг болон хувь хүмүүст зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг нь баталгаажуулах шаардлагатай*” гэж зөвлөсөн байдаг.

◆ Зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн эрх зүйн зохицуулалт

1. Хүн амын зохистой, аюулгүй хоол хүнсээр жигд хүртээмжтэй хангагдах эрхийг олон улсын түвшинд ерөнхийд нь хүний ХҮНСНИЙ ЭРХ гэсэн ухагдахуунд хамааруулан ойлгож, үүнийг хангахын тулд хүний эдлэх ёстой нийгэм, соёлын бусад эрхтэй салшгүй холбоотой “өлсгөлөнгөөс ангид байх” үндсэн эрх болон “зохистой хоол хүнсээр хангагдах эрх” гэсэн 2 эрхэд гол анхаарлаа хандуулж, улс орнуудыг уг хоёр эрхийг төрийн хууль, тогтоомжоор баталгаажуулахын чухлыг

онцлон тэмдэглэсэн байдаг тул энэ судалгаанд тэмдэглэсний дагуу хүнсний тухай хуулийг дахин шинэчлэн найруулж өөрчлөх шаардлагатай байна.

2. Манай улс зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг Үндсэн хуулиндаа шууд утгаар нь тусгаагүй байна. Харин уг эрхийн хувьд нилээд өргөн хэмжээтэй тусгасан хууль бол манайд 1999 оны “Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулга болж байна. Гэтэл уг хуулинд хүнсний эрх гэдэг ойлголт бас шууд утгаараа тусгаагүй байгаа бөгөөд хүн амын зохистой хоол хүнсээр хангагдах эрхтэй холбоотой зарим чухал асуудал үндсэндээ эрх зүйн зохицуулалтгүй болоход хүрсэн байна.

3. Хүнсний тухай дээрх хуулийг “шинэчилсэн найруулга” хэмээн тодотгон хэлэх болсон цаад утга нь анх манай улс 1995 онд “Хүнсний тухай” хуулийг батлан гаргаж мөрдсөн юм. Уг хуулинд хүнсний эрхийн асуудлыг нилээд ойлгомжтой нарийн тусгаж, хүн амын зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхэд төр засгийн үүрэг ролийг нилээд тодорхой бөгөөд өргөн хүрээнд тусгасныг энэ сэдвийн 1, 2-т дэлгэрэнгүй өгүүлсэн билээ. Гэтэл 1999 оны хуулийн шинэчилсэн найруулга дээр уг эрхтэй холбоотой, хүнсний хангамж, баталгаатай холбоотой бараг бүх заалтуудыг өөрчлөн хуулиас зарим чухал заалтуудыг шууд хассан нь уг хуулийн гол ач холбогдлыг бууруулахад хүргэсэн байна.

◆ Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал

4. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчин өнөөдөр үндсэндээ бүрдээд байна гэж дүгнэж болох авч, хууль тогтоомжийг биелүүлэх асуудлууд амьдрал дээр бүрэн хэрэгжихгүй байна. Энэ нь **нэгд** хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн зохицуулалт ялангуяа импортын хүнсний аюулгүй байдлыг хангах асуудал дээр ямар нэг хориг арга хэмжээ үгүйлэгдэж байна. **Хоёрт**, хүнсний хангамжийн сүлжээ үндсэндээ хувийн секторт шилжсэнтэй холбоотой хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаалалт, импортлолтыг хэн хүссэн нэг нь эрхэлж байгаа тул тэдгээр хүмүүсийн мэргэжил, мэдлэг, ухамсар, хөрөнгө мөнгөний бололцооноос хүнсний аюулгүй байдал шууд хамаарч байна. **Гуравт**, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын үйл ажиллагаа “Хүнсний тухай” хуулийн заалтуудтай зөрчилдөж, зарим хяналт хийдэгдэх, эсвэл хяналтын зарим ажлууд давхардаж болох хандлагатай байгаа бөгөөд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүд болон хяналт тавих дүрэм, стандарт байхгүй, шинжилгээ хийх лабораторийн хүчин чадал сул, ялангуяа импортын хүнсний бүтээгдэхүүн орж ирдэг хилийн хяналтын боомтууд дээр лабораторийн хяналтын шинжилгээ огт хийгдэхгүй байгаа зэрэг зөрчил дутагдлаас шалтгаалан хүнсний аюулгүй байдал алдагдах үндсэн нөхцөл болж байна.

ХУУЛЬ БУСААР БАРИВЧЛАГДСАН ЦАГДАН ХОРИГДСОН, ШИЙТГЭГДСЭН ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН АСУУДАЛД

П.Оюунчимэг,
ХЭҮК-ын ахлах референт, магистр

А. Хохирогчийн тухай ерөнхий ойлголт

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хохирогчийн эрхийг хамгаалах нь хүний эрхийн тулгуур асуудлуудын нэг бөгөөд үүнийг дэлхийн улс орнууд өөрсдийн дотоодын хууль тогтоомжоор янз бүрээр зохицуулсан байдаг.

Монгол улсын хувьд хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой хуулийн заалтууд бий болсон боловч тэдгээр нь тэр бүр хохирогчийн бүх талын эрхийг баталгаатай хангаж чаддаггүй.

Байцаан шийтгэх хуульд хохирогчийн эрхийг тусгаж өгсөн хэдий боловч процесс ажиллагааны явцад хэдийд нь хохирогчийн хохирол төлбөрийн асуудлыг шийдвэрлэх, ямар журмаар гаргаж тооцох талаар нарийн зохицуулалт байхгүй байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаархи хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглалын”¹ заалтаас харахад **хохирогч** гэдэгт.... **Эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл эс үйлдлийн улмаас бие махбодийн болон оюуны гэмтэл учирсан, сэтгэл санааны дарамтанд орсон, эд хөрөнгийн хохирол учирсан, эсхүл үндсэн эрх нь ноштойгоор зөрчигдсөн бие хүн болон хамт олныг ойлгоно”** гэжээ.

Манай улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулинд зааснаар хохирогчийг тодорхойлохдоо:

... гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэж заасан байна. Иргэн хуулийн этгээдийг хохирогчоор тогтоохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гарган тогтооно хэмээжээ.

Дээрхи хоёр тодорхойлолтоос харахад олон улсын баримт бичигт хохирогчийн талаар дэлгэрэнгүй тайлбарласан **/нэр төр, сэтгэл санаа, бие эрхтэн, эд хөрөнгийн хохирлоос гадна үндсэн эрх нь зөрчигдсөн байх/** байна.

Хохирогч бол байцаан шийтгэх ажиллагааны чухал оролцогчийн нэг бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тодорхой эрх эдэлдэг.

Хохирогч нь:

- өмгөөлөгч авах
- баримт сэлт гаргаж өгөх
- нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах

¹ “Шүүх ба хүний эрх” 135-р тал

- шүүх хуралдаанд оролцох
- шүүгдэгч гэрч, шинжээчид асуулт тавих
- хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах
- эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах
- хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах
- гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх
- цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах
- бусад этгээдээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол эсэргүүцэлтэй танилцаж тайлбар гаргах
- хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах эрхтэй байна.

Эдгээрээс үзэхэд хохирогч нь нилээд өргөн эрхтэйгээр байцаан шийтгэх ажиллагаанд оролцох бөгөөд хэргийг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой нь харагдана.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны гол оролцогч болохын хувьд хохирогч нь өмгөөлөгч авах, асуулт тавих болон гомдол гаргах өргөн эрхээр хангагдсан байгаагаас гадна өмгөөлөгчтэй адилаар хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах эрхтэй байгаа нь байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдоос ялгаатай байна. Яллагдагч зөвхөн өөрт холбогдсон хэргийн материалтай танилцах эрхтэй байдаг /ЭБШХ-ийн 36.3.8-д байна/.

Хохирогч мөн цагаатгах тогтоолд давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй байгаа нь түүнийг ялладагчийн эсрэг байр суурьтай хоёр дахь ялагч мэт болгодог.²

Б. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас хохорсон хохирогчийн эрхийг хамгаалах асуудал

Монгол улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 14-д: иргэн нь бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй... гэж заажээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5-д: хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй гэж³ заасан байна.

Манай улсын 2002 оны ЭБШХ-д “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай” шинэ бүлгийг /44 бүлэг/ нэмж оруулсан нь уг хуулийн өмнөх хуулиасаа ялгагдах гол том онцлог болсон гэж хэлж болно.

² Эрүүгийн байцаан шийтгэх хууль, шинжлэх ухааны тайлбар, 2003 он, 48-р тал

³ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Төрийн мэдээлэл сэтгүүл 2004 он, 15-р тал

Энэ асуудалтай холбоотой хууль тогтоомжийн уламжлалыг сонирхож үзвэл 1990 онд “БНМАУ-ын шүүх прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хуулийг баталж, мөрдлөг болгож байв.⁴/2002 онд хүчингүй болсон/.

Энэхүү хуульд “Хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, ажилд нь эргүүлэн тогтоох, ажилласан хугацаанд тооцох, тэтгэвэр тэтгэмж тогтоох, орон сууц эзэмших эрхийг нь сэргээх, цол шагнал хассаныг сэргээх зэрэг ажиллагааг хэрхэн шийдвэрлэх талаар заасан байв. Хууль бусаар хорих ял шийтгүүлсний улмаас зогсоосон тэтгэвэр тэтгэмжийг нийгэм хангамжийн болон холбогдох бусад байгууллага нөхөн төлнө гээд шүүхийн шийдвэрээр хураасан, улсын орлого болгосон түүнчлэн хэрэг бүртгэх мөрдөн байцаах байгууллагын гаргуулсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг биет байдлаар нь буцаан олгох ба хэрэв олгох боломжгүй болсон тохиолдолд анхны тогтоосон үнээр бодож тухайн орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн байгууллага улсын төсвийн хөрөнгөнөөс олгохоор заасан байв.

Мөн хуульд иргэнд учирсан хохирлыг улс хариуцах талаар заасан. Үүнд иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, мөн захиргааны шийтгэлийн журмаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу баривчлах арга хэмжээ оногдуулснаас иргэнд учирсан эд хөрөнгийн хохирлыг шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын албан тушаалтны гэм бурууг харгалзахгүйгээр улс хариуцан арилгана. Харин шүүх прокурор, мөрдөн байцаах хэрэг бүртгэх байгууллагын гэм буруутай албан тушаалтанд БНМАУ-ын хууль тогтоомжинд зааснаар **эрүүгийн, сахилгын, эд материалын болон бусад хариуцлага** хүлээлгэнэ гээд, хэрвээ уг ажиллагаа гэмт хэрэг болох нь зохих журмаар тогтоогдвол эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар бүрэн төлүүлнэ хэмээн заасан байв. Харамсалтай нь энэхүү хууль практикт тэр бүр тууштай хэрэгжихгүй байсаар байгаад 12 жилийн дараа хүчингүй болж одоогийн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн нэг бүлэг болон өөрчлөгдөн орсон билээ. Уг хуулиар зарим хохирлыг шууд төрөөс бус өөр байгууллагаас тэтгэвэр тэтгэмж гаргуулах талаар заасан байсан хэдий боловч тухайн үедээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хохирсон хүний эрхийг хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хийсэн анхны оролдлого байсан гэдгийг хэлэх хэрэгтэй.

Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй ЭБШХ-д ийм төрлийн хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл, журмыг тусгай бүлэг болгон оруулснаас үзэхэд хууль тогтоогч энэ асуудалд ихээхэн ач холбогдол өгсөн гэж хэлэх үндэслэлтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлгийн ихэнх заалт нь төрийн албан тушаалтнуудын хууль зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсооход чиглэгдснээс гадна хэрэг нь хэрэгсэхгүй болгогдсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагавраа арилгуулах, тэтгэвэр тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад үндсэн хуулиар олгогдсон эрхээ нөхөн сэргээлгэх эрхийг бодитойгоор тусгаж өгснөөрөө өмнөх хуулиасаа яах аргагүй дэвшилтэтэй болжээ.

⁴ БНМАУ-ын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хууль, 1990 он /2002 онд хүчингүй болсон/

Хуульд зааснаар дараах тохиолдолд хохирол нөхөн төлүүлэх эрх үүснэ. Үүнд:

- баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс суллагдсан
- тухайн иргэнийг цагаатгасан шүүхийн тогтоол гарсан
- тухайн хэрэг нь гэмт хэргийн бүрэлдхүүнгүй, эсхүл тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон
- эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус тогтоолыг хүчингүй болгосон тохиолдолд уг эрх үүсэхээр заасан байна.

Хууль зөрчсөн ажиллагааны улмаас хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь хүнийг хууль бусаар хохироосон нь тогтоогдвол хариуцлагыг хууль тогтоомжинд заагдсанаар хүлээхээс гадна хэрвээ үйлдэл эс үйлдэхүй нь гэмт хэрэг болох нь зохих журмаар тогтоогдвол эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр заасан байна.

Хуульд эд хөрөнгийн чухам ямар хохирлыг нөхөн төлүүлэхийг тодорхой гаргаж тавьсан нь энэ хуулийн бас нэг ололттой тал юм.

Үүнд:

- хууль бус ажиллагааны улмаас иргэний аваагүй дундаж цалин хөлс болон амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлого
- хууль бусаар хорих ял шийтгүүлсний улмаас зогсоосон тэтгэвэр тэтгэмж
- шүүхийн шийдвэрээр хураасан, улсын орлого болгосон, түүнчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын гаргуулсан эд хөрөнгө
- шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж гаргуулсан торгууль, иргэнээр төлүүлсэн байцаан шийтгэх ажиллагааны болон бусад зардал
- хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлс⁵ гэжээ.

Гэвч ийм тодорхой заалттай хууль хэрэгжиж эхлээд 2 жил хагас болж байгаа хэдий ч өнөөдөр практик дээр хуулийн байгууллагын ажилтнуудын хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн гаргуулах хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх ажил хууль хэрэгжүүлэгч байгууллагын дунд байхгүй байна гэж хэлэхэд хилсдэхгүй байх.

Улсын Ерөнхий Прокурорын газрын мэдээгээр 2003 онд хэрэг бүртгэлтийн шатанд 5932 хэрэг, мөрдөн байцаалтын шатанд 8585 хэрэг хэрэгсэхгүй болгогдож байсан бол, 2004 онд хэрэг бүртгэлтийн шатанд 4681 хэрэг, мөрдөн байцаалтын шатанд 5910 хэрэг хэрэгсэхгүй болгогдож байжээ.

Энэ олон хэрэгт холбогдож байсан хэдэн мянган хүний тодорхой хэсэг нь хоригдсон, баривчлагдсан, эд хөрөнгө, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаагаараа хохирсон нь ойгомжтой. Гэтэл нөхөн төлбөр гаргуулж авсан тухай ямар ч мэдээ баримт байхгүй байна.

Шүүхийн статистик мэдээнээс харвал 2004 онд Монгол улсын шүүх 11695 холбогдогчтой эрүүгийн 7443 хэрэг хүлээн авч, 757 холбогдогчтой 374 хэргийг урьдчилсан мөрдөн байцаалтанд буцааж, 711 холбогдогчтой 341 хэргийг гэмт хэргийн бүрэлдхүүнгүй улмаас хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. 2003

⁵ Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 он

онд 267 хэргийн 569 холбогдогчид холбогдох хэргийг мөн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.⁶

Эд хөрөнгийн бус сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах талаар хуулийн заалт байгаа боловч энэ нь практикт хэрхэн мөрдөх нь тодорхой биш байна. УДШ-ийн иргэний хэргийн танхимын 2000 оны 6 сарын 25-ны өдрийн хуралдаанаар гаргасан “Зөвлөмж” хуучин иргэний хуулийн 392 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тайлбарлажээ. “Эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэдгийг үндэсний болон гадаад валютаар төлбөр хийх, эсхүл үнэт цаас болон бусдаас авах авлага хонжвороо шилжүүлэх, үнэ хөлсгүй ажил үүрэг гүйцэтгэх, олон дахин уучлал хүсэх, сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг үзүүлэх зэргийг хэлнэ гээд хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар гэдэгт нийгмийн амьдралд идэвхтэй оролцож чадахгүй болох, ажлаас халагдах, шагнал урамшлаас хасагдах, гэр бүл болон захидал харилцаа болон өвчний нууц алдагдах, гэр бүл, эцэг эх, үр хүүхдийн сэтгэл санаанд нөлөөлөх, сэтгэцийн гутралд орох, ажил сургуульдаа явж чадахгүй байх гудамжинд гарахдаа олон түмнээс ичих зэргээр сэтгэл санааны таагүй байдалд орсон байхыг ойлгоно” хэмээжээ.⁷

Өнөөдрийн шүүхийн практикт сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлын шийдвэрлэлт маш хүндрэлтэй байна. Ямар нэгэн тогтсон практик, хуулийг оновчтой тайлбарласан хуулийн тайлбар, жишиг байхгүйгээс шүүх хууль бусаар хоригдсон, мөрдөгдсөнтэй холбоотой сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэхгүй орхиж байна. Жишээ нь: ХЭҮК-ын төлөөлөн нэхэмжлэлтэй хүн амины хэрэгт долоон жил шахам мөрдөгдөж, дөрвөн жил гянданд хоригдсон Э-д холбогдох иргэний хэрэгт сэтгэл санааны хохиролыг тогтоогдохгүй байна гэж хэрэгсэхгүй болгож байв.

В. Хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тайлбарлах журмын тухай

Эрүүгийн хэргийг цагаатгасан буюу хэрэгсэхгүй болгосон тухай тогтоолын хуулбарыг хохирсон иргэнд өөрт нь гардуулан өгөх буюу шуудангаар илгээх тухай заалтыг хуульд тусгаж өгчээ. Үүний хамт хохирлоо нөхөн төлүүлэх журмыг хамтад нь тайлбарлах, шүүхэд хэрхэн хандаж эрхээ сэргээлгэх, ямар журмаар нэхэмжлэл гаргах, шүүхэд хандах хугацаа болон харьяалалын талаархи мэдээллийг тухайн иргэнд цогцоор нь хүргүүлсэн байх ёстой. Гэвч энэ нь өнөөдрийн байдлаар бүрэн төгс хэрэгждэггүй, тунхаглалын шинжтэй хуулийн заалт болоод байгааг энд онцлон тэмдэглэмээр байна.

Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлоо арилгуулах тухай нэхэмжлэлийг тухайн хохирсон иргэн нь өөрөө эсвэл хууль ёсны төлөөлөгч, мөн тухайн иргэний итгэмжлэгдсэн төлөөлөгч болон өмгөөлөгч нар нь гаргаж болно.

Насанд хүрээгүй этгээдээс үйлдсэн гэмт хэргийг цагаатгасан тохиолдолд түүний нэрийн өмнөөс эцэг, эх, өмгөөлөгч, асран хамгаалагч нар гаргадаг.

Тухайн иргэнтэй холбоотой эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр гаргах өргөдлийг уг хэргийг цагаатгасан болон хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлалыг

⁶ Өдрийн сонин, 2005.03.21 №070/1891/

⁷ Сэтгүүлч ба цуврал – “Нэр төр гүтгэлэг” сэтгүүл №05, 2003 он, 135-р тал

тухайн хохирсон иргэн хүлээн авснаас хойш 3 жилийн дотор гаргаж болохоор хуульд тусгасан нь цаг хугацааны хувьд ч, тухайн хэрэгт холбоотой нотлох баримтыг цуглуулан бүрдүүлэн бэлтгэж уг асуудлыг шүүхэд гарган хөөцөлдөхөд хангалттай хугацаа гэж үзэж байна.

Сэтгэл санаа, эрүүл мэнд, нэр төрийн хохирлыг сэргээлгэх тухай өргөдлийг эрхийг нь тайлбарлан өгсөн хуудсыг хүлээн авснаас хойш нэг жилийн дотор гаргахаар тусгасан боловч харамсалтай нь практикт огт хэрэгждэггүйгээр барахгүй энэ талаар эрхийг нь тайлбарласан хуудас гардуулсан тохиолдол өнөөдрийн байдлаар байхгүй байна.

Хохирогч тухайн өргөдлийг өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ шүүхэд хандан харьяалалын дагуу өргөдлөө гарган шийдвэрлүүлэх ёстой.

Хохирол нөхөн төлүүлэх тухай өргөдлийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ. Мөн 511-р зүйлд зааснаар эдийн бус гэм хорыг арилгахдаа бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээдэг.

Хэдийгээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 397 дугаар зүйлийн нэгдэх хэсэгт зааснаар хохирол нөхөн төлүүлэх тухай өргөдлийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ хэмээн заасан боловч, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх журмын тухай хуулийн 133 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд гэсэн ангилалд энэ заалт байхгүй байгаа нь энэ хоёр хуулийн хоорондоо зөрчилдөж байгаа заалтууд яах аргагүй мөн.

Энэ нь хуулийг практикт нэг мөр ойлгон хэрэглэх шүүн таслах ажиллагааны практикт хүндрэл учруулж байгааг хэлэх хэрэгтэй.

НУТГИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР БА БИЗНЕС ЭРХЛЭГЧИДИЙН ЭРХ АШИГ

Н.Отгончимэг,
МУИС-ийн ХЗС-ийн докторант

Эрх зүйт төрийн нэг чухал шалгуур болсон хууль дээдлэх зарчим хэрэгжих болсноор төр, түүний албан тушаалтны явуулж байгаа аливаа үйл ажиллагаа иргэдэд **үйлчлэх** чиг баримжаатай байх талаар “дээр”, “доор”-гүй ярих болжээ.

Төрийн үйлчилгээний нэг чухал төрөл болох захиргааны үйлчилгээний чанар, хүртээмж болон төрөөс хувийн сектортой харилцахад эрх зүйн ямар хэлбэрийг (захирамжлах эсхүл гэрээний хэлбэр г.м.) ашиглах, түүнчлэн зах зээлийн харилцаанд төрийн оролцооны зохистой хэлбэр, оролцох болон оролцохоос татгалзах асуудлын талаар анхаарал татсан нэлээдгүй асуудал байна.

Захиргааны үйлчилгээг бизнесийн салбарт хүргэх хэлбэр нь эрх бүхий албан тушаалтны шийдвэр буюу захирамж, тушаал, заавар зэрэг захиргааны акт гаргах байдлаар илрэх нь түгээмэл юм. Жишээ нь: нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх, эсхүл согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл олгох шийдвэр гаргах, мөн газар олгох асуудлыг шийдвэрлэх, мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлж янз бүрийн шаардлага, сануулга өгөх гэх мэт.

Бизнес эрхлэгчдэд эдгээр үйлчилгээг хүргэх нэрийдлээр хууль тогтоомжоор тэдэнд олгосон таатай нөхцөл, боломжийг хязгаарласан, эсхүл бүр хориглосон шийдвэр гаргах, зарим үед тэдгээр боломжийг олгосон шийдвэр гаргахдаа бизнесийнхний дотоод хэрэгт хөндлөнгөөс хууль бусаар хутгалдан орох нь олонтаа гарч байна.

Зөвшөөрөл, лиценз олгож, хуульчилсан бусад акт гаргах нэрийдлээр аж ахуйн хэвшлийн дотоод хэрэгт хутгалах нь хэрхэвч хууль зүйд нийцэхгүй юм. Энэ нь Үндсэн хуулийн зарчим, зорилгод харшлах билээ. Гэвч өмнөх 70 гаруй жилийн “удирдлагын арга барилаа” өнөө болтол тавьж хаяхгүй байгаа нь захиргааны байгууллагуудаас аж ахуй эрхлэгчдэд холбогдуулан гаргасан шийдвэр, актуудад илэрсээр байна. Түүнчлэн төрийн зүгээс бизнес эрхлэгчидтэй харилцахдаа үнд суртал, илүү шат дамжлагыг өөрсдөө зохиомлоор бий болгосон захиргааны актууд гаргаж дарамт учруулах нь цөөрөхгүй байгаа нь харамсалтай. Орон нутгийн байгууллагуудаас гаргасан зарим актад үндэслэн энэ талаар жишээлэн өгүүлж, санаа бодлоо хуваалцаж.

а. Төрийн оролцооны талаар

Захирамж 1. Нэгэн’ аймгийн Засаг даргын 2001.11.7-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” 392-р захирамжид аж ахуйн үйл ажиллагааг түр зогсоох, эрх хасах арга хэмжээг авах тухай заажээ.

Захирамжийн 1-д аймгийн хэмжээнд орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдэд ажлын байрыг түрээсээр олгохдоо албан татварыг нь төлүүлсний дараа гэрээ, хэлцэл хийж ажиллахыг түрээслэгч ААН, байгууллагын захирал нарт үүрэг болгожээ.

Нэг иргэн нөгөөдөө Иргэний хуулийн дагуу харилцан тохиролцож өөрийн эд хөрөнгөө түрээслүүлэх, ашиглуулах нь төрийн байгууллагын ямар нэг оролцоогүйгээр явагдаж, Иргэний хуулийн дагуу зохицуулагддаг харилцаа юм. Энэ харилцаанд төр хөндлөнгөөс шууд оролцож “түрээслүүлж болохгүй” гэх мэтчилэнгээр хориг саад хийсэн нь өмнөх төрийн төвлөрсөн шууд удирдлагын арга барилыг яах аргагүй санагдуулж байна. Ийм явдал гарахаас сэргийлж Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль гарсан билээ. Энэ хуулийн 11.2-т зааснаар төрийн болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд тодорхой төрлийн **үйл ажиллагаа явуулах, бараа үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон буюу хязгаарласан** шийдвэр гаргахыг хориглодог. Иймд захирамжийн уг заалт байраа түрээслүүлж байгаа ААН-ын зах зээлийн харилцааны чөлөөт үйл ажиллагааг хязгаарлаж, хууль зөрчжээ.

Түүнчлэн уг захирамжийн 2-т албан татвараа төлөөгүй буюу татварын тооцоо хийгээгүй иргэдэд ажлын байр түрээслүүлсэн ААН, байгууллагын **үйл ажиллагааг түр зогсоох**, аймгийн Засаг даргын захирамжаар олгогдсон **тусгай эрхүүдийг зогсоох** хүртэл арга хэмжээ авахыг үүрэг болгожээ.

Татвар ногдуулах, төлөх нь зөвхөн **татвар төлөгч ба төрийн холбогдох байгууллага** хоорондох харилцаа юм. Энэ харилцаанд хөндлөнгийн этгээдийг, тодруулбал татвар төлөгчид байраа түрээслүүлж байсан ААН-г татан оролцуулж үүрэг хүлээлгэн, улмаар биелүүлээгүй бол хариуцлага хүлээлгэхээр заасан нь Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуульд харшилж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Захирамж 2. Нэгэн аймгийн Засаг даргын 2004.5.24-ний өдрийн 134-р захирамжаар махны үнэ хэт хөөрөгдсөн тул аймгийн бөөний худалдааны төвөөр дамжуулан 2 тн махыг 300 төгрөгөөр хямд зарж үнийн зөрүү болох 600000 төгрөгийг аймгийн хөгжлийн сангаас гаргаж өгчээ.

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 11.3.1.-д төрийн болон нутгийн захиргааны байгууллага хоорондоо болон аль нэг аж ахуйн нэгжтэй тохиролцон бараа бүтээгдэхүүний **үнийг бууруулсан, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн** шийдвэр гаргахыг хориглодог. Энэ бол шударгаар өрсөлдөж байгаа нөхцөлийг алдагдуулахгүй байх зорилготой. Иргэдийн хувьд махыг арай бага үнээр худалдан авах нь амьдрал ахуйд нь хэрэгтэй ч, энэ таатай байдлыг бий болгохын тулд нутгийн захиргаа хууль бус арга хэрэглэж болохгүй нь мэдээж билээ. Өөрөөр хэлбэл хууль зөрчсөн байдлыг ямар ч зорилго зөвтгөж чадахгүй юм. Нутгийн захиргааны байгууллагын авч хэрэгжүүлсэн энэ арга хэмжээ байсан төвөгтэй байдлыг бүрэн шийдвэрлэсэн гэхээсээ илүү зах зээлд өрсөлдөөнийг хаан боогдуулсан шинжтэй болжээ.

* “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн” ТББ-ын салбараас 5 аймагт зохион байгуулсан бизнес эрхлэгчид, иргэний нийгэм, төрийн байгууллагын уулзалт дээр эдгээр захирамжуудын талаар тухайн аймгийн захиргаанд зохих байдлаар танилцуулж ярилцсан, түүнчлэн дээрх сөрөг үзэгдлүүд зөвхөн нэг аймгаар хязгаарлагдаагүй нийтлэг байсан тул аймгийн нэрийг дурдалгүй орхив.

Захирамж 3. Нэгэн аймгийн Засаг даргын 2002.1.22-ны “Согтууруулах ундаа худалдан борлуулах ажлыг журамлах тухай” 14-р захирамжаар зөвхөн тодорхой нэрийн архийг худалдан борлуулахыг зөвшөөрчээ.

Захирамжийн 1-д зөвхөн өөрийн аймгийн “Г” ХК, “Б” ХК, “А” ХХК-ны үйлдвэрүүдийн “К”, “Б”, “Х” нэрийн архи, АПУ-гийн болон импортын архийг борлуулахыг зөвшөөрчээ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд согтууруулах ундааны талаарх тусгай зөвшөөрөлд ямар үйлдвэрийн архи гэдгээр нь огт ялгаж, зааглалгүй зөвшөөрөл олгохоор зохицуулсан байдаг. Ийнхүү согтууруулах ундааг үйлдвэрлэсэн газраар нь ялгаж зааглаж байгаа нь Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд зааснаар төрийн болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд бараагаа нэг зах зээлээс нөгөөд борлуулахыг хориглосон буюу хязгаарласан шийдвэр гаргахыг хориглосон хэм хэмжээг зөрчиж байна. Энэ бол зах зээлийн өөрийнх нь хуулиар зохицуулагдаад явах асуудалд төрөөс оролцож удирдаж байгаа тод жишээ юм. Энэ мэт хууль бус оролцоо нь бизнест яв ч нэмэр болохгүй, харин саад тотгор болж байна.

Захирамж 4. Нэгэн аймгийн Засаг даргын 2001.4.20-ны өдрийн “Зөвшөөрөл олгох, журам батлах тухай” 106-р захирамжаар “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх хяналт тавих журам” –г баталжээ.

Энэ журмын 2.1.-д “I зэрэглэлийн дэлгүүрийн шаардлага хангасан объектд экспорт, импортын, зоогийн газарт АПУ, орон нутгийн, II зэрэглэлийн дэлгүүрт орон нутгийн архи борлуулахыг зөвшөөрөхөөр заажээ. Тэгвэл мөн л Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд зааснаар төрийн болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд бараагаа нэг зах зээлээс нөгөөд борлуулахыг хориглосон буюу хязгаарласан шийдвэр гаргахыг хориглосон байдаг. Энэ заалт нь шударга өрсөлдөөнийг хаан боогдуулсан гэх үндэстэй.

б. Зарим тусгай зөвшөөрлийн журмын талаар

Захирамж 1. Нэгэн сумын ИТХТ-ийн 2003.1.13-ны өдрийн 3-р тогтоолоор тоглоомын болон биллярдын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, дагаж мөрдөх журмыг баталжээ.

Энэ тогтоолын 3.5.-д “Тоглоомын газраас хааш хаашаагаа 50 метр газрыг байнга цэвэр үзэмжтэй байлгаж тохижуулсан байх (*мод зүлэг тарих, гэрлэн чимэглэл, гэрэлтүүлэг тавих гэх мэт*) гэж заажээ. Өөрөөр хэлбэл энэ бол тухайн үйлчилгээ эрхлэх хүнд тавьж буй шаардлага, үүрэг байна. Энд дурдсан мод зүлэг тарих, гэрлэн чимэглэл, гэрэлтүүлэг тавих гэх мэт ажлын санхүүжилт нь хаанаас гарах ёстой талаар мэдээж асуулт гарч байна. Тоглоомын газраас хааш хаашаагаа 50 метр газарт энэ ажлыг хийх ёстойгоос үзвэл тухайн газар ААН, иргэний эзэмшлийн бус болох нь илт байна. Хааш хаашаагаа 50 метр гэх энэ газар бол Газрын тухай хуульд зааснаар нийтийн эзэмшлийн гудамж, талбайд хамаарах юм.

Тэгвэл мөн хуулийн 22.2.3.-т багийн Засаг дарга нутаг дэвсгэртээ нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуй, ариун цэврийн асуудлыг хариуцахаар заасан байгаа шүү дээ. Иймд нийтийн эдэлбэрийн газарт мод зүлэг тарих, гэрлэн чиглэл, гэрэлтүүлэгийн ажил нь тоглоомын болон биллярдын үйлчилгээ явуулж байгаа иргэдийн үүргийн асуудал биш юм. Харин тэдгээр ажлыг тухайн иргэн зөвхөн өөрийн санаачлагаар, сайн дураар хийж болох талтай.

Мөн тогтоолын 3.8.-д “Төр захиргаа, орон нутгийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, нийтээр дагаж мөрдөх тогтоол, захирамжийг биелүүлж **хотынхоо тохижилтод тодорхой хувь нэмэр оруулах**” үүрэгтэйг заажээ. Хотын тохижилтод хувь нэмэр оруулна гэдэг нь ямар нэгэн байдлаар эдийн засгийн өртөг бүхий нэмэр өгнө гэсэн үг билээ. Биеийн хөдөлмөрөөр хувь нэмэр оруулах нь хүртэл эдийн засгийн өртөгтэй байдаг шүү дээ. Гэтэл Татварын хуульд зааснаар төр иргэнээс зөвхөн 3 хэлбэрээр төлбөр, мөнгө шаардах эрхтэй байдаг. Үүнд: албан татвар, төлбөр, хураамж гэж бий. Тэгэхлээр “**хотынхоо тохижилтод тодорхой хувь нэмэр оруулах**” гэдэг үүрэг бол татварын хууль зөрчиж иргэдэд хууль бусаар үүрэг ногдуулсан явдал болжээ. Харин эсрэгээр “**хотынхоо тохижилтод тодорхой хувь нэмэр оруулах**” эрхтэй гэж зааж өгсөн бол иргэн сайн дурын үндсэн дээр, боломжоороо хувь нэмэр оруулах боломжийг олгох байлаа.

Тогтоолын 4.6.-д “Тоглоомын утга санаа нь алаан хядаан, садар самуун, **төр засгийн бодлого, шийдвэрийн эсрэг утга агуулгатай** тоглоом тоглуулах үйл ажиллагаа явуулах”-ыг хоригложээ. Төр засгийн бодлого, шийдвэрийн эсрэг утга агуулгатай үйл ажиллагаа явуулахыг хориглох гэдгийг бичлэгийн хувьд “хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулж болохгүй” гээд заачихсан бол хууль зүйн хувьд алдаагүй болох байлаа. Учир нь Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16-д зааснаар иргэд итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үгээ хэлэх эрхтэй бөгөөд энэ нь төр засгийн аливаа бодлого, шийдвэрийн талаар өөрийн гэсэн үзэл бодолтой байх, хууль бус гэж үзвэл түүний талаар хуулийн дагуу санаа бодлоо илэрхийлэх эрхтэйг илтгэж байдаг. Иймд үүнийг аж ахуй эрхлэгчийн дотоод итгэл, хэрэгт хууль бус аргаар нөлөөлж байгаа сөрөг үзэгдэл гэж үзэхээс өөр аргагүй байна.

Захирамж 2. Нэгэн аймгийн Засаг даргын 2003.9.3-ны өдрийн “Газар олгох тухай” 239-р захирамжаар иргэн, ААН, байгууллагад газар олгожээ.

Захирамжийн хавсралтад дурдсан нэр бүхий иргэн, ААН, байгууллагад газар олгохдоо эзэмших зориулалтаар 2 жилийн хугацаа тогтоожээ. Гэтэл Газрын тухай хуулийн 30.1.-д “Газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад **15-60 жил хүртэл хугацаатайгаар** эзэмшүүлж болно” гэж заасан. Өөрөөр хэлбэл газар эзэмшүүлэх доод талын хугацаа нь ядаж 15 жил байх ёстой гэсэн үг юм. Энэ захирамжид заасан хугацаа нь иргэн, ААН, байгууллагад хуулиар олгосон эрхийг даруй 13 жилээр хорогдуулсан байна. Ийнхүү хуулиар олгосон таатай боломжийг хаан боогдуулж богино хугацаагаар газар олгох нь иргэдэд чирэгдэл учруулах, улмаар олон удаа сунгуулахад хүнд сурталтай тулгарахаас эхлээд олон бэрхшээл үүсгэх сөрөг талтай юм.

Газар олгохдоо хуульд зааснаас богино хугацаагаар олгодог энэ зуршил олон захирамжид давтагдаж байна. Иймд Монгол Улсын иргэн, хуулийн этгээд газрыг

15-60 хүртэл жил эзэмшихээр хуулиар олгогдсон эрхийг нутгийн захиргааны байгууллагын зүгээс хүндэтгэн, хууль зөрчихгүй байх шаардлагатай байна.

в. Төлбөр, хураамжийн талаар

Захирамж 1. Нэгэн аймгийн Засаг даргын 2001.6.7-ны өдрийн “Газар олгох тухай” 207-р захирамжийн II хавсралтаар газар авсан иргэн, ААН, байгууллагад тавигдах шаардлагыг баталжээ.

Энэ захирамжийн II хавсралтын 3-д “Газар олгохдоо барилга барих талбайг 2 дахин өсгөсөн хэмжээг 12000 төгрөгөөр үржүүлэн дүнг хотын ногоон байгууламж тарих зардалд тооцно” гэжээ. Энэ нь иргэн, хуулийн этгээдэд үүрэг болгосон заалт бөгөөд хуульд заасан хураамж, газрын төлбөрийн аль нь ч биш юм. Үүнийг хотын тохижилтод оруулж байгаа хандив гэж нэрлэж болох юм. Гэвч хураамж, газрын төлбөрөөс хандивын ялгагдах гол шинж нь сайн дурын үндсэн дээр өгдөгт оршино. Иймд хот тохижилтын нэрийдлээр хандив өгөхийг үүрэг болгох нь газар авахын тулд иргэн, ААН, байгууллагад хуулиар хүлээлгэсэн үүрэгт хамааралгүй, нэмэлт үүрэг болж байна. Ийнхүү хуульд тусгагдаагүй төлбөр мөнгө шаардаж байгаа нь аж ахуй эрхлэгчдэд хуулиар олгосон боломжийг хязгаарласан явдал болжээ.

Захирамж 2. Нэгэн аймгийн Засаг даргын 2004.6.15-ны 159-р захирамжаар мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам баталжээ.

Энэ журмын 3.5.-д тусгай зөвшөөрөл 100000 төгрөгийн хураамжтай байна гэжээ. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 7-д зааснаар тусгай зөвшөөрөл авахдаа тэмдэгтийн хураамж төлсөн баримт гаргаж өгөх ёстой. Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15.1.-д “Хууль тогтоомжид заасны дагуу тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зөвшөөрөл олгоход 12500 төгрөгийн хураамж хураана.” гэж заасан. Энэ нь мал эмнэлгийн үржлийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авахад 12500 төгрөгийн хураамж төлнө гэсэн үг юм.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.2.-т хуульд зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардахыг хориглосон байдгийг тэмдэглэх хэрэгтэй болов уу.

Захирамж 3. Нэгэн сумын Засаг даргын 2003.4.2-ны өдрийн 20-р захирамжаар зарим ажил, үйлчилгээ, төрийн өмч ашигласны төлбөр, хураамжийг тогтоожээ.

Захирамжийн Хавсралтаар баталсан журамд согтуу хүнийг түр саатуулж хамгаалалтад авахад 1 удаа 2000 төг, согтуу хүнийг гэр, оронд нь хүргэж өгөхөд 1 удаа 500 төг авахаар заажээ.

Нийгмийн хэв журмыг сахиулах нь цагдаагийн байгууллага, түүний ажилтны хуулиар хүлээлгэсэн үүрэг шүү дээ. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлд цагдаагийн ажилтан олон нийтийн газар согтуугаар хэвийн бус яваа хүнийг тусгай байранд эрүүлжүүлэх, эсхүл **хамгаалах хүнд хүлээлгэн өгөх**

үүрэгтэйг заажээ. Иймд төлбөр, хураамж тогтоож авахыг хуулиар тусгайлан заагаагүй тохиолдолд цагдаагийн байгууллага хүлээлгэсэн үүргээ хэрэгжүүлэхдээ иргэдээс хураамж, төлбөр авах нь яав ч хуулийн зарчимд нийцэхгүй юм.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 14.2.-т эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журмыг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно гэж заасан байдаг. Энэ бол эрүүлжүүлэх арга хэмжээ авахад иргэдээс тодорхой хэмжээний хураамжийг авч болохыг хуульчлаад өгчихсөн байгаа тохиолдол юм. Ийнхүү хуульд тусгайлан заагаагүй бусад тохиолдолд аль нэг албан тушаалтан хийх ёстой ажлынхаа төлөө ямар нэгэн хууль зүйн үндэслэлгүйгээр төлбөр хураамж авах нь хууль бус болно.

Мөн журамд бооцоот тоглоомын орлогоос 10% төсөвт төлөх үүрэг хүлээлгэжээ. Тэгвэл Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгож, өөрчилж, хүчингүй болгоно гэж заасан байдаг. Хэрэв Улсын Их Хурал эрх олговол татварын хувь, хэмжээг Засгийн газар болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тогтоож болдог. Сумын Засаг дарга орлогоос авч, улмаар төсөвт оруулах татварын хувь хэмжээг тогтоосон нь хууль зүйн үндэслэлийн хувьд эргэлзээ төрүүлж байна.

Энэ журмаар цагдаагийн ажилтны торгуулын орлогыг төсөвт орлогод төвлөрүүлэх **төлөвлөгөөнөөс** жилээр давсан орлогын 80 хувийг нийгмийн баталгаа хангахад зарцуулан **төлөвлөгөөт орлогоос** төсөвт оруулсан орлогын 35 хувийг цагдаагийн албаны ажилтны албан ажлын хэрэгцээнд төвлөрүүлэн ашиглах эрх олгожээ. Энэ заалтаас үзвэл цагдаагийн байгууллага торгуулийн орлогын төлөвлөгөөг ажилтнууддаа өгдөг нь харагдаж байна. Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар торгууль гэдэг нь захиргааны зөрчил гаргаж, түүнд хүлээлгэдэг шийтгэлийн нэг төрөл юм. Тэгэхлээр цагдаагийн байгууллага хэдэн зөрчил, хэзээ, ямар хэмжээгээр гарахыг урьдчилан төлөвлөдөг гэсэн үг болж байна. Энэ нь цагдаагийн байгууллага төлөвлөсөн торгуулийн орлогоо бүрдүүлэхийн тулд зөрчлийг таслан зогсоох, ялимгүй бол сануулах гэх мэт арга хэмжээг хэрэглэхээс илүүтэй торгохоо урьтал болгох буруу зуршлыг бий болгох сөрөг талтай.

Энэ мэт жишээ (эерэг бус) олонтаа тааралдах бөгөөд хэрэв цаашид улам олширвол эдийн засаг, нийгэмд ямар сөрөг үр дагавар авчирар нь төсөөлөгдөж байна. Иймд энэ мэт алдаатай, эргэлзээтэй актууд байваас нутгийн хурал, захиргааны байгууллагаас түүнийгээ эргэн нэг харж “хүннээс дуулсан, эсхүл өөрөө мэдсэн” гэдгээр ялгалгүй засаж залруулж, улмаар хойшид ийм шийдвэр гаргахгүй байх нь бизнес эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, сахиж байгаагийн илрэл болох болов уу.

Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу төрөөс аж ахуйн аливаа хэвшлийн үйл ажиллагааг зохицуулсан шийдвэр нь (мөн гэрээ байгуулахдаа) эдгээр хэвшлийн хөгжлийг хангахад чиглэгдсэн байх учиртай билээ.

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ НОТЛОХ АЖИЛЛАГААНД ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ДЭЭДЛЭХ ЗАРЧМЫГ ХАНГАХАД АНХААРАХ АСУУДАЛД

Б.Батзориг,

Цагдаагийн Академийн эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн
тэнхмийн ахлах багш, цагдаагийн хошууч, докторант

Дэлхий нийтээр хууль зөрчиж цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг шүүхийн шийдвэрт нөлөөлөх хүчин чадалтай албан ёсны нотлох баримт болгоход:

1. Хууль зөрчсөн бол ашиглахыг хориглодог,
2. Хууль зөрчсөн тохиолдолд ашиглахыг зөвшөөрдөг,
3. Яллагдагчийн гэм бурууг нотлох баримт олж авахад гаргасан хуулийн зөрчилтэй харьцуулан дэнсэлдэг,
4. Байцаан шийтгэх ажиллагааны явцад хууль зөрчиж олж авсан нотлох баримтыг хууль зөрчилгүйгээр олж авч болох байсан бол ашиглаж болно гэсэн үндсэн агуулгатай үзэл баримтлал хуульчлагдсан байдаг.¹

Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс оронд хууль бусаар олж авсан нотлох баримтыг шүүхийн шийдвэр гаргахад ашиглалгүй хэрэгсэхгүй болгох нь хүний эрх, эрх чөлөөг хангаж байгаагийн нэг баталгаа байдаг.² Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд³ энэ үзэл баримтлалыг хуульчилсан боловч бидний “Эрүүгийн хэргийг нотлох ажиллагааг боловсронгуй болгох асуудал” сэдэвт докторантын судалгааны ажлын явцаас үзэхэд бичигдээгүй хуулийн (*discretion iustise*) тогтолцоо олон жилийн турш оршоор ирсэн байдал ажиглагдаж байна.

Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд олон журам хуульчлагдсан боловч тэдгээрээс онцлон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид эрх, үүргээ хэр мэдэж байгаа, түүнд ямар хүчин зүйлс нөлөөлж байгаа талаар хийсэн судалгаа, санал дүгнэлтээ “Хүний эрх” сэтгүүлийн уншигч, судлаач та бүхэнтэй хуваалцахыг хүслээ.

Судалгаанаас⁴ үзэхэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас оролцогчдод эрх, үүргийг нь танилцуулж өгөхөд иргэд сайн ойлгодоггүй бөгөөд энэ тохиолдолд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын зарим үйл ажиллагаа нь эхний ээлжинд дарамталж, айлган сүрдүүлж байгаа мэт сэтгэгдлийг төрүүлдэг байна. Түүнчлэн зарим тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын хууль ёсны үйлдэл /мөрдөн байцаалтын зарим тактик хэрэглэх үед/ ч тэдний эсрэг чиглэсэн, хууль

¹ Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. Шинжлэх ухааны тайлбар. УБ., 2003., 42-р тал

² Ali Safak, Vahit Bigak. Ceza Muhakemesi Hukuku ve Polis. Ankara. 1999., 252.

³ Монгол Улсын ЭБШХ-ийн 8.2. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд энэ хуулийн 8.1.-ийг зөрчвөл түүний гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүйд тооцож, түүнд хариуцлага хүлээлгэнэ. Мөн хуулийн 79.4. Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

⁴ 2004 онд Нийслэлийн 6 дүүрэг, 5 аймагт хийсэн судалгаа /Г.Б.Батзориг/

бус үйлдэл мэтээр ойлгогдож эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын хооронд үл ойлголцох явдал үүсдэг байдал ажиглагддаг. Энэ үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт хандан “Та нар иргэдэд, тэдний төлөө ажиллаж байгаа, хууль зөрчөөгүй гэдгийг хэлж болохгүй юмуу” гэхэд “бид хууль зөрчөөгүй учир тэр болгоныг тайлбарлаад байх боломж ч, завч байхгүй, тэд гомдлоо гаргаад үнэн зөвийг олно биз” гэсэн байдлаар хандаг нь иргэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын дундах үл ойлголцох, хүний эрхийг зөрчиж байгаа гэсэн төрөл бүрийн ойлголт нийгэмд илүү хурдацтайгаар тарахад нөлөөлж байна.

2005 оны 3 дугаар сард нийслэлийн 2 дүүргийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албанд шалгагдаж байгаа гэрч, хохирогч, сэжигтэн, ялагдагч нарын дунд явуулсан судалгаанаас үзэхэд тэдний 90 хувь нь байцаагдахын өмнө эрх, үүргээ ямар нэгэн хэмжээгээр мэддэггүй байсан бол, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцсоны дараагаар 75 хувь нь ямар нэгэн хэмжээгээр мэддэг болсон, 9 хувь нь маш сайн мэддэг болсон гэж хариулж байв. Судалгааны явцад эрх, үүргээ ямар нэгэн хэмжээгээр мэддэг болсон гэсэн хүмүүстэй уулзаж ярилцахад зөвхөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцохдоо эдлэх эрх, үүргийн талаар бүдэг төсөөлөлтэй болсон боловч энэ тухайн хүний боловсрол, мэргэжлийн байдлаас шалтгаалан ихэвчлэн буруугаар буюу өөрийн үнэлэмжээр ойлгосон байсан бол маш сайн мэдэж авсан гэж хариулснаас хуульч мэргэжилгүй хүмүүстэй уулзаж ярилцахад өөрийнхөө хууль ёсны эрх, үүргийг хангалттай эдлэх хэмжээний мэдлэггүй байгаа байдал ажиглагдсан юм.

Энэ байдлаас улбаалан яагаад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч иргэд өөрийн хууль ёсны эрх, үүргээ мэдэж чадахгүй байгаа талаар судалж үзэхэд үүнд дараах хүчин зүйлс нөлөөлж байна гэж үзлээ.

1. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь жирийн иргэн уншаад ойлгоход төвөгтэй төдийгүй хуульчдын дунд хоёрдмол утгаар ойлгогдох заалтууд багагүй байдаг.

2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар хуульд зааснаар оролцогчдын эрх, үүргийг тайлбарлаж өгөх бус зөвхөн уншиж өгөх буюу уншуулах байдлаар хязгаарлаж байгаа нь иргэдэд ийм ойлголтыг бий болгож байна.

3. Мөн оролцогч эрх, үүргээ сайтар мэдэх нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын үйл ажиллагаанд багагүй саад болдог гэдэгтэй судалгаанд хамрагдсан хэрэг бүртгэгч, нарын 64 хувь нь санал нийлсэн байна.

Нөгөө талаас эдгээр сөрөг үзэгдлүүд нь хууль сахиулах байгууллагын захиргааны байгууллагын алааа доголдлын нэг илрэл байдаг,⁵ түүнчлэн АНУ-ын судлаач William B. Waegel энэ нь хуулийн байгууллагын ажилтнуудын зан авираас үнэхээр арилгаж болохооргүй элемент⁶ гэж үзэж байгаатай зарим талаараа санал нийлж байна.

Ийнхүү эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч иргэдийн хууль ёсны эрх, эрх чөлөөгөө эдлэхэд гол саад болж байгаа зүйл нь тэдний эрх, үүргээ мэдэхгүй байдал гэдгийг судалгаанд хамрагсдын олонхи нь зөвшөөрч байсан билээ.

⁵ Pogrebin. Qualitative approaches to criminal justice: Perspectives from field.

⁶ Waegel, William B. Case Routinization in investigative Police Work: Social problems p.94-106

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, төр, иргэдийн хоорондох үл итгэлцлийн байдлыг арилгахын тулд

1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар оролцогчдод эрх, үүргийг нь хуульд зааснаар тайлбарлаж өгөх

2. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албадын ойр орчимд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг жирийн хүнд ойлгомжтой, энгийн байдлаар зурагт хуудас байдлаар байрлуулах ажлыг хийж болох бөгөөд дараах хүндрэл учирч болох юм.

2004 оны 12 дугаар сард нийслэлийн 6 дүүргийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын дунд явуулсан судалгаанаас үзэхэд судалгаанд хамрагдагсад тэдний явуулж байгаа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны 40-52 хувь нь техникийн шинжтэй/тогтоол бичих, зарлан дуудах хуудас бичих, хэрэг дугаарлах, үдэх гэх мэт/, захиргааны шинжтэй /хурал, зөвлөгөөн, сургалт гэх мэт/, бусад ажил/хамгаалалт, төрөл бүрийн нэгдсэн арга хэмжээнд оролцох/ ажилд зарцуулдаг гэсэн байв. Өөрөөр хэлбэл тэдний үзэж байгаагаар ноогдох ажлын цагийн 50 орчим хувьд нь хэрэг мөрдөн шалгах ажлаа хийдэг болж байна.

Бидний хийсэн туршилтаас үзэхэд яг ижил тохиолдолд Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ягштал баримтлалгүй /одоо байгаа журмаар/ гэрчийг байцаахад ойролцоогоор 20 минут зарцуулж байсан бол Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмыг баримтлан эрх, үүргийг нь гэрчид ойлгогдохоор тайлбарлан байцаахад ойролцоогоор 50 минут зарцуулж байлаа. Бүх хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар ийм байдлаар байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулбал ажлын ачаалал хэд дахин нэмэгдэх нь ойлгомжтой.

Түүнчлэн оролцогчдод эрх, үүргийг нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч өөрийн үнэлэмж, ашиг сонирхолд нийцүүлэн тайлбарлаж болох нөхцөл байдал туршилтын явцад илэрсэнийг дурдахгүй өнгөрч болохгүй.

Энэ аргыг хэрэгжүүлэх өнөө үед захиргааны болон сургалтын олон талтай арга хэмжээг удаан хугацааны туршид тодорхой үе шатаар авч хэрэгжүүлсний дараагаар үр дүн гарна. Энэ хугацаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх явдал буурахгүй нь лав.

Хоёрдахь арга буюу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албадын ойр орчимд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг жирийн хүнд ойлгомжтой, энгийн байдлаар зурагт хуудас байдлаар байрлуулбал эхний ээлжинд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын ажилд багагүй хүндрэл учирдаг болох нь туршилтаар тогтоогдсон.

Бидний судалгаагаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны хүлээлгийн ерөөнд эрх нь зөрчигдвөл прокурорын мөрдөн байцаах албанд хандах тухай зурагт хуудсыг зориудаар байрлуулсны дараагаар оролцогчид өөрт нь таалагдахгүй л бол прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албанд хандах санал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт тавьж байсан ба уг зурагт хуудсыг авсны дараагаар энэ байдал харьцангуйгаар багассан байна.

Энэ бүхнээс үзэхэд манай нөхцөлд нэн түрүүнд оролцогчдын эрх, үүргийг энгийн, ойлгомжтойгоор тайлбарласан зурагт хуудсыг байрлуулах нь илүү үр дүнтэй байж болно.

Энэ тохиолдолд иргэд өөрийн эрх, үүргийг мэддэг болж энэ хэмжээгээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарыг хуулиа биелүүлэхийг шаардах, өөрийнх нь эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх талаар санал, хүсэлт гаргах болж улмаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын сурах идэвх дээшилнэ.

Эцэст нь дүгнэж хэлэхэд хүний эрхийг хангая гэвэл цагдаагийн алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх нь зүйн хэрэг тул албаны давтан сургалтыг оновчтойгоор зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

ХҮНИЙ ЭРХ БА ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Б.Оюутбол
**Баянхонгор аймгийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч,
цагдаагийн ахлах дэслэгч, хууль зүйн магистр**

Хүний халдашгүй эрх гэж өөрийнх нь төрөлх, жам ёсны хэрэгцээнээс үүдэлтэй мөн чанарын хувьд төрөөс тогтоосон биш зөвшөөрсөн бөгөөд эрх зүйн хэм хэмжээгээр бэхжүүлэгдэж хамгаалагдсан, ямар ч тохиолдолд хөндлөнгийн хэн ч дур мэдэн хөндөж хязгаарлаж болохгүй хэд хэдэн туйлын эрхийн тухай цогц ойлголт юм.¹

Олон улсын гэрээ, конвенциудад хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан олон заалтууд байдаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл Тунхаглал “Хүн бүр.. эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан эрхтэй”, 9-р зүйлд “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй”² гэж заажээ.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 3-р зүйлд “... шүүх, засаг захиргаа, хүүхдийг халамжлан хамгаалах байгууллага аль нь ч аливаа ажил явуулахдаа хүүхдийн эрх дээд зэргээр хангахад анхаарлаа хандуулна”, 37-р зүйлд “... нэг ч хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дур мэдэн хасч болохгүй”³ гэж заасан.

Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт /цаашид ИУТЭТОУП гэнэ/-д “Энэхүү пактаар хүлээн зөвшөөрөгдсөн аливаа хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн бөгөөд энэ нь албан үүргээ гүйцэтгэж байсан этгээдийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан тохиолдолд хохирогчийг хууль зүйн дагуу хамгаалах үр нөлөөтэй арга хэмжээ авах, ... хууль зүйн хамгаалалтын хэрэгслийг олгосон үед түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэглэх явдлыг хангах...” зэргээр шаардлагатай арга хэмжээ авахыг тус пактад оролцогч улсуудад үүрэг болгосон байдаг.

Монгол улс хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан 50 гаруй гэрээ, конвенцид нэгдэн орсон бөгөөд тэнд заагдсан зүйл, заалт бүрт ялангуяа хүнийг хууль бусаар мөрдөн мөшгих, эрх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон хэм хэмжээг чанд сахих үүрэгтэй билээ.

Ийм ч учраас Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-д “хүн бүр халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...иргэний...халдашгүй байдлыг хуулиар хамгаална”⁴ гэж заасан байдаг.

¹ Г. Эрдэнэбат, Хүний халдашгүй эрх, УБ, 2002

² Хүний эрх, Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл, НҮБ, УБ, 1992

³ Хүний эрх, Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл, НҮБ, УБ, 1992

⁴ Монгол улсын Үндсэн хууль, 1992

Манай улсад 2002 онд УИХ-аас шинэчлэн найруулсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг батлан гаргасан бөгөөд уг хуулинд хүний эрхийг хамгаалах, албан тушаалтны дур зоргоороо авирлах, хууль бус үйлдлээс хамгаалахад чиглэгдсэн илт ололт, дэвшилттэй, шинэлэг заалтууд орсон. Үүний нэг тод жишээ нь сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг олгох эрх шүүхэд шилжсэн явдал билээ.

Гэсэн хэдий ч манай Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь олон улсын эрх зүй болох ИУТЭТОУП болон бусад гэрээ, конвенцтэй зөрчилдсөөр байна.

Тухайлбал, ИУТЭТОУП-аар баривчлагдсан, саатуулагдсан этгээд хэргээ аль болох ахар богино хугацаанд шүүхээр хэлэлцүүлэх эрхтэй байхаар заасан. Гэтэл манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд цагдан хоригдож буй хүнийг цаад тал нь 30 сар хорихоор заасан. Мөн Хүүхдийн эрхийн тухай Конвенцид хүүхдийг хорихдоо аль болох богино хугацаа хэрэглэхээр заасан байхад манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд хүүхдийг хорих цаад хугацаа 18 сар байхаар заажээ.

Монгол улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний зарим нэг эрх, эрх чөлөөг Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зайлшгүй тохиолдолд хязгаарлахаар заасан байдаг. Тухайлбал, Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхийг оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах таслан сэргийлэх арга хэмжээгээр /цаашид ТСАХ гэнэ/, хөдлөх, үл хөдлөх хөрөнгөө чөлөөтэй эзэмшиж, захиран зарцуулах эрхийг эд хөрөнгө барьцаалах ТСАХ-аар хязгаарлаж байна. Гэхдээ энэхүү хязгаарлалтуудыг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмаар тогтоох ёстой болохыг хуульчилж өгсөн.

Ийм ч учраас Эрүүгийн байцаан шийтгэх /цаашид ЭБШ гэнэ/ ажиллагааны үед хүний эрх, эрх чөлөө хөндөгдөж зарим тохиолдолд түүнийг зайлшгүй хязгаарлах шаардлагатай байдаг учраас түүнд туйлын нягт нямбай үндэслэлтэй хандах хэрэгтэй.

ТСАХ нь ЭБШ ажиллагаан дахь албадагыг хамгийн тод хэлбэрээр илэрхийлдэг бөгөөд хүний халдашгүй эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоодог албадагын үндсэн шинжийг агуулж байдаг. ТСАХ-ний мөн чанарыг харуулахын тулд хүний эрх, эрх чөлөөний тухай асуудлыг хамтатган авч үзэх шаардлага зүй ёсоор гардаг.

Практикт ТСАХ-г хэрхэн хэрэглэж байгаа талаар Баянхонгор аймгийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нараас мөн Цагдан хорих ТСАХ авагдсан 30 гаруй хүнээс асуулга авч, эрүүгийн 50 хэргийг судалж үзэв.

ТСАХ-г ямар үед хэрэглэх вэ? Гэсэн асуултанд хуулийн байгууллагын албан хаагчдын 50 орчим хувь нь гэмт хэрэгт сэрдэгдэж сэжигтнээр тооцогдсон үед, 22 хувь нь уг этгээдэд ял сонсгосон үед, 38 хувь нь гагцхүү ТСАХ авах хуулинд заасан үндэслэл байгаа тохиолдолд хэрэглэнэ гэжээ. ТСАХ-г заавал хэрэглэх шаардлагатай юу гэсэн асуултанд 78 хувь нь тийм, 22 хувь нь үгүй гэж хариулсан байна.

Мөн цагдан хорих ТСАХ авагдсан хүмүүсийн дийлэнх нь буюу 82 хувь нь бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэгт цагдан хоригдож, нийт хоригдож байгаа хүмүүсийн 60 хувь ямар үндэслэлээр цагдан хорих ТСАХ авсан болохыг мэдээгүй, 22 хувь нь хэргээ хүлээгээгүй буюу хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулж болзошгүй, 18 хувь нь оргон зайлж, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэсэн үндэслэлээр цагдан хорих ТСАХ авагдсан гэжээ.

Шүүхээр шийдэгдсэн эрүүгийн 50 хэргийг судалж үзэхэд: 29 хэргийн сэжигтэн, яллагдагчид батлан даалтанд өгөх ТСАХ, 19 хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид цагдан хорих ТСАХ, 2 хэргийн сэжигтэн, яллагдагчид оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах ТСАХ авсан байсан болно.

Гэхдээ оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах ТСАХ-г авахдаа нэг тохиолдол нь тогтоолыг бичээгүй зөвхөн баталгааг бичүүлж гарын үсэг зуруулсан, нөгөө тлхиолдолд нь ТСАХ авах тогтоолыг бичсэн боловч өөрсдөөр нь баталгааг бичгээр гаргуулж аваагүй байв.

Харин эд хөрөнгө барьцаалах ТСАХ-г нэг ч хэрэг дээр аваагүй байв. Мөн ТСАХ авсан тухай тогтоолыг сэжигтэн, яллагдагчид танилцуулж гарын үсэг зуруулаагүй 14 тохиолдол байсан ба цагдан хорихоос бусад төрлийн ТСАХ авахдаа ямар үндэслэлээр уг ТСАХ-г авч байгаа талаараа тогтоолд огт дурддаггүй, ТСАХ-ны аль нэг төрлийг зайлшгүй авах шаардлагатай болохыг нотолсон баримт сэлт, мэдээлэл хавтаст хэрэгт огт байхгүй, зөвхөн үйлдсэн хэргийн товч утгыг бичсэн байдал ажиглагдсан. Уг 50 эрүүгийн хэргийн дийлэнх нь хөнгөн, хүндэвтэр хэрэг байсан болно.

Энэ бүгдээс дүгнэлт хийж үзэхэд батлан даалтанд өгөх ТСАХ-г ЭБШ хуулийн 62-р зүйлд заасан үндэслэл тогтоогдоогүй байхад байнга авч хэвшсэн, гэмт хэрэг үйлдсэн бөгөөд цагдан хорих ТСАХ авах үндэслэлгүй л бол сэжигтэн, яллагдагчид аль нэг төрлийн ТСАХ-г зайлшгүй авах шаардлагатай гэсэн ойлголт нийт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын дунд байдаг: хөнгөн, хүндэвтэр хэргийн сэжигтэн, яллагдагч нарт цагдан хорих ТСАХ-г ихээр авч байгаа: ТСАХ хамгийн хөнгөн төрөл болох Гадагш явахгүй байх тухай баталгаа авах болон эд хөрөнгө барьцаалах ТСАХ-г маш бага авдаг болох нь харагдаж байна.

Мөн прокурор нь ЭБШ хуулийн 71-р зүйлд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд ТСАХ-г өөрийн санаачлагаар авах, өөрчлөх, хүчингүй болгох эрхээ тэр бүр эдэлдэггүй бөгөөд ТСАХ нь хууль ёсны, үндэслэлтэй эсэхэд хяналт тавих үүргээ муу биелүүлж байгаа нь харагдаж байна.

Үүнээс гадна зарим нэг тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө өргөдөл, гомдол, мэдээллийг шалгах хугацаандаа иргэнд батлан даалтанд өгөх ТСАХ авсан тохиолдол ч байх бөгөөд, прокурор нь сэжигтэн, яллагдагчид ямар ч ТСАХ аваагүй байна гэж хэргийг буцааж байсан тохиолдол ч гарч байсан байна.

Гэтэл ЭБШ хуулийн 62-р зүйлийн 1-д сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болох буюу эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болох, эсхүл гэмт хэрэг үйлдэж болох үндэслэлтэй бол түүнд ТСАХ аль нэг төрлийг авч болохоор заасан.

Хэрэв дээрх үндэслэлийг аль нь ч байхгүйгээс сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ТСАХ аваагүй нөхцөлд ЭБШ хуулийн 73-р зүйлд зааснаар **Дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг авхуулах** хэрэгтэй юм.

ТСАХ-г авах нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үүрэг биш тэдний эрх юм. Харин ТСАХ-г хуульд чанд нийцүүлж авах, түүнийг хэрэглэх явцад иргэдийн эрх, эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлах, зөрчихгүй байх үүргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хүлээнэ.

Ингээд дээрх зөрчил дутагдлыг дахин давтан гаргуулахгүй байх, ТСАХ-г хэрэглэх явцад хүний эрхийг зөрчүүлэхгүй байх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна:

1. Хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарТСАХ аль нэг төрлийг хэрэглэхэд ЭБШ хуулийн 62-р зүйлийн 1-д заасан үндэслэл байна гэдгийг зайлшгүй нотолсон байх. Таамаг, таавар, өөрийн үзэмжээр субъектив үнэлэлт өгч ТСАХ авахгүй байх.
2. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ТСАХ авахдаа тэдний үйлдсэн гэмт хэргийн ангилал, хувийн байдал, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, гэр бүлийн байдал, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол зэргийг харгалзан үзэж байх.
3. Сэжигтэнд онцгой тохиолдолд л ТСАХ-г хэрэглэж байх. Хэрэв сэжигтэнд ТСАХ аль нэг төрлийг хэрэглэснээс хойш 14 хоногийн дотор гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдоогүйгээс ял сонсгох үндэслэлгүй бол түүнд авсан ТСАХ-г хүчингүй болгож энэ талаар өөрт нь заавал мэдэгдэж байх.
4. ТСАХ авсан тогтоол, захирамжид сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн үйлдсэн гэх хэргийн талаар болон, ТСАХ авах болсон үндэслэлийг тодорхой бичсэн байна. *Болзошгүй* гэсэн үг хэллэгээс аль болох зайлсхийх. Эрүүгийн хэрэгт ТСАХ-г авах үндэслэл байгааг нотолсон баримт сэлт, мэдээллийг хавсаргах.
5. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид заавал ТСАХ авах албагүй гэдгийг байнга анхаарч, хэрэв ТСАХ авах үндэслэл байхгүй бол ЭБШ хуулийн 73-р зүйлд зааснаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг авахуулж хэвших шаардлагатай байна.

Хэрэв дээрх саналыг ТСАХ-г хэрэглэж байгаа албан тушаалтан нар хэрэгжүүлж чадваас ТСАХ-г хэрэглэх явцад хүний эрхийг зөрчих явдал тодорхой хэмжээгээр багасах юм.

Монгол улсын Засгийн газрын урилгаар НҮБ-ын Эрүүдэн шүүхийн асуудлаархи Тусгай илтгэгч Монгол улсад энэ оны 6-р сарын эхээр айлчилсан юм. Тусгай илтгэгч Ноён Манфред Новак-тай “Хүний эрх” сэтгүүлийн редакциас ярилцлага хийсэн юм. Энэхүү ярилцлагыг уншигчиддаа толилуулж байна.

Асуулт: Ноён М. Новакаа, юуны өмнө та НҮБ-ын Тусгай илтгэгч гэж хэн бэ? Тусгай илтгэгчийн эрх хэмжээ болон ажлын чиг үүргийн таалар манай уншигчдад танилцуулахгүй юу?

Хариулт: *НҮБ-ын Тусгай илтгэгч гэсэн албыг анх 1985 онд НҮБ-ын Хүний эрхийн Коммисоос санаачилсан юм. Миний хувьд бол эрүүдэн шүүхийн асуудлаархи Тусгай илтгэгчээр 2004 оны 12-р сарын 1-нд томилогдсон. Би бол эрүүдэн шүүхийн асуудлаархи дөрөвдэх Тусгай илтгэгч юм. Тусгай илтгэгчийн мандат бол НҮБ-ын гишүүн аль ч орны хувьд хүчинтэй байдаг. Энэ нь НҮБ-ын дүрмийг үндэслэсэн хяналтын механизм бөгөөд эрүүдэн шүүхийг мөрдөн шалгах аас гадна хорих байгууллагын нөхцөл байдлыг дэлхийн бүх улс орнуудад мөрдөн шалгах эрхтэй юм. Мөн түүнийхээ дагуу илтгэл бичиж тайлагнаж байх ёстой. Тухайн жилд шалгасан улстай холбоотой тайлангаа Женев-ын Хүний эрхийн чуулганд 3-4 дүгээр сард тайлагнана.*

Тусгай илтгэгч нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

1. Эрүүдэн шүүгдсэн тухай өргөдөл гомдлыг хохирогч, түүний гэр бүл, ТББ болон Засгийн газрын байгууллагаас хүлээн авч, түүний мөрөөр тодруулга хийж, тэр этгээд саяхан баривчлагдан, эрүү шүүлт явагдсан, үргэлжлэн явагдаж байгаа бол, Тусгай илтгэгч нь тус улсын Засгийн газар болон Гадаад хэргийн яаманд хандаж даруй арга хэмжээ авахыг хүссэн захиа бичдэг.

Үүний зэрэгцээгээр тус улсын Засгийн газраас богино хугацаанд эрүү шүүлтийг зогсоох ба уг хэргийг мөрдөн шалгахыг хүсдэг.

2. Тусгай илтгэгч нь тодорхой сэдвээр илтгэл бичдэг. Илтгэл нь ихэвчлэн тодорхой улс орны хувьд эрүү шүүлийн талаар ямар байдалтай байгааг гаргаж өгдөг.

3. Тусгай илтгэгч нь аль нэгэн улсын Засгийн газрын урилгаар томилолтоор явж ажилладаг. Урилгаар ажиллахдаа эрүүдэн шүүлтийн нөхцөл байдал болон урьдчилан хорих, шоронгийн газрын нөхцөл байдлын талаар үнэн зөв мэдээлэл олж авах, холбогдох хүмүүстэй нүүр тулж уулзах, мэдээлэл олж авах, эрүү шүүлтийг хориглосон хууль зүйн тогтолцооны үр дүнг судлах үүнээсээ тухайн орны тодорхой дүр зургийг үнэн зөв гаргахыг хичээдэг. Түүнчлэн тусгай илтгэгчийн зориолго бол тус улсын Засгийн газартай бие даасан үр бүтээмж бүхий харилцаа үүсгэн хамтарч ажиллахын

зэрэгцээ, Засгийн газарт эрүүдэн шүүхийг хэрхэн багасгах тэмцэх талаар дэмлэг туслалцаа үзүүлэх, санал зөвлөмж өгөх явдал болно.

4. Миний хувьд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт протоколд нэгдэн орохыг уриалан, сурталчлах нь бас нэг том зорилго болно.

Асуулт: Эрүү шүүлт гэж юу вэ? Өнөөдөр дэлхий нийтэд Эрүү шүүлт нь ямар хүрээнд байна гэж та үзэж байна вэ?

Хариулт: Эрүүдэн шүүлт нь хүнлэг бус харьцааны хамгийн харгис хэрцгий хэлбэр юм. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн 1-р зүйлд эрүү шүүлтийн тодорхойлолтыг өгсөн. Үүнд:

1. Төрийн албан тушаалтны санаатай үйлдэл
2. Зорилго нь хэн нэгнээс мэдээлэл авахад оршсон
3. Хохирогчийг оюун санаа болон бие махбодийн хувьд шаналган зовоох ба зодох тамлан зовоох гэх мэт

Асуулт: Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын Конвенцид 2000 онд нэгдэн орсон, уг Конвенцид нэгдэн орсон улс орон ямар үүрэг хүлээдэг вэ?

Хариулт: Энэ конвенцид нэгдэн орсон улс гүрнүүд нь эрүүдэн шүүсэнтэй холбоотой өргөдөл гомдлыг хүлээн авч шалгаад эрүү шүүлт явагдсан байгаа эсэхийг даруй тэр доор нь мөрдөн байцаах ажлыг яаралтай хийх шаардлагатай байдаг. Хэрэв эрүү шүүлт явагдсан нь нотлогдох юм бол хэрэг үйлдсэн хүмүүст хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх ёстой.

Монгол улсад 2002 онд явагдсан эрх зүйн шинэтгэлийн хүрээнд холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулсан, гэж байгаа хэдий ч санаа зовоож буй зүйл бол Эрүүгий байцаан шийтгэх хуулийн зарим заалтууд байна. Энэ хууль нь олон улсын стандартыг тухайлбал, ИБУТЭТОП болон Хүүхдийн эрхийн Конвенцийг зөрчиж байгаагаас гадна Монгол улс эрүү шүүлтийг хууль тогтоомждоо томъёолоогүй байна. Түүнчлэн Монголд гянданд ганцаарчлан олон арван жилээр хорих болон цаазаар авах ял үйлчилж байгаа нь байдлыг хүндрүүлж байна.

Асуулт: Та Монголд байгаа нөхцөл байдлыг ямар байна гэж дүгнэж байна вэ?

Хариулт: Монгол улсад сүүлийн жилүүдэд хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах талаар зарим үйл ажиллагаа явуулж байгаа хэдийч Монгол улсад эрүүдэн шүүх, тамлан зовоох асуудал одоо хүртэл оршоор үргэлжилсээр байгаа нь тодорхой харагдаж байна.

Асуулт: Эрүү шүүлтэй холбоотой анхаарал татсан ямар асуудлууд Монголд байна гэж та үзэж байна вэ?

Хариулт: Бидний 4 өдрийн айлчлалын хугацаанд олж авсан баримтууд нь Монголд эрүүдэн шүүх асуудал болон хэргүүд байгаа гэдгийг нотолж байна. Тухайлбал, эрүүдэн шүүх болон тамлан зовоох асуудал урьдчилан хорих төвүүдэд болон Ганц худагийн урьдчилан хорих төвд маш ноцтойгоор гарч буй баримтыг

бид олсон. Түүнчлэн Цагдаагийн ажилтанууд болоод хорих байрны ажилтануудын буруу үйл ажиллагааны улмаас тэд нарын дарамтанд орж, зодуулан тамлан зовоогдсон ийм хэргүүд байгаа.

Хамгийн сүүлд болсон энэ хэрэг дээр жишээ татъя гэж бодлоо, тухайн хэрэг бидний айлчлалын өмнө 2 долоо хоногийн өмнө болсон байна. Батаагийн Мөнхбаяр гэж залуу Ганц худаг дахь урьдчилан хорих төвд 2005 оны 5 дугаар сарын 17-нд хүргэгдэж ирсэн, 5-р сарын 20-нд энэ хүнийг Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэс дээр ар гэрийхэн нь хүлээн авчээ. Гэтэл Ганц худагт байх 3 хоногийн хугацаанд маш ихээр зодуулж, үүнээсээ болоод 5-р сарын 29-нд нас барсан байгаа. Нотлох баримт болгон авсан фото зурагнууд надад байгаа, энэ зурагнуудыг би хэвлэлийн бага хурал дээр үзүүлсэн.

- Түүнээс гадна энэ 4 өдрийн айлчлалдаа бид Хорих ангиудаар явж хоригдож буй хүмүүстэй болон хохирогч нартай уулзаж ярилцсан, мөн өөр ноцтой баримтууд ч бий. Бидний хорих ангиудаар явах хугацаанд мэргэжлийн эмч дагаж явсан, эмч үзлэг хийгээд тамлан зовоогдсон зодуулсан ул мөр байсан, энэ хэргүүдийг Засгийн газар болон хууль тогтоох байгууллагуудад санал гарган, тухайн хэргийг мөрдөн шалгахыг санал болгох болно. Энэ хэргийг үйлдсэн хүмүүст хатуу хариуцлага хүлээлгэхийг бид шаардана.

Үүнээс гадна сэтгэл зовниж буй асуудал бол ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ялын тухай болон ялын дээд хэжээг тойрсон асуудал юм. Цаазаар авах ялыг гүйцэтгэх журмаас гадна цаазаар авах ялтай холбоотой мэдээлүүд, тухайлбал, шүүхээс оноосон цаазаар авах ял шийтгүүлэгчдийн тоо, цаазаар авах ял авсан хүмүүсийн хоригдож буй өрөө камер, тэдгээрийн нөхцөл байдал маш нууц байна. Цаазаар авах ялын хэмжээ сүүлийн үед маш их ихэсч байгаа гэсэн мэдээг би авсан. Бидний олж авсан баримтаар жилд 20-22 хүнд цаазаар авах ял оноож байна гэсэн мэдээ байгаа. Түүнчлэн би энд байх хугацаандаа ялын дээд хэмжээтэй холбоотой тоо мэдээллийг авах гэж олон байгууллагуудын удирдлагуудаас хүсч хичээсэн боловч хэрэгцээтэй мэдээллээ авч чадаагүй.

- Мөн цаазаар авах ял авсан этгээдүүд нь маш хүнд нөхцөлд хоригдож байдаг юм байна, гар нь гавтай хөл нь дөнгөтэй байдгаас гадна энэ хүмүүс нь цаазаар авах ялыг гүйцэтгэхээс өмнө хүнд нөхцөлд хоригддог. Бидэнд цаазаар авахуулах ялтай хүмүүсийн тодорхой тоо баримт байсан, мөн аль урьдчилан хорих төвд байгаа тухай ч мэдээлэл байсан. Хорих газарт очоод үзлэг хийгээд явж байхдаа тухайн хүмүүстэй уулзах хүсэлт тавьсан боловч удирдлагууд нь энд тийм ялтай хүмүүс байхгүй өөр бусад хорих төвд байгаа гэх мэтчилэнгээр харуу өгч бид нарт уулзах боломж гараагүй юм. Бид Ганц худаг дахь урьдчилан хорих төв болон Төв аймгийн урьдчилан хорих төвүүдэд очсон, тухайн үед бид цаазаар авах ял авсан хүмүүсийн байрлаж буй байрыг зааж өгөхөөс гадна уулзуулж өгөх хүсэлт тависан боловч уулзуулаагүй. НҮБ-ын хаана ч саадгүй нэвтрэх бүрэн эрхтэй Тусгай илтгэгчийн эрхийг зөрчиж, хүссэн газарт нэвтрүүлэхгүй байсан нь Монгол улсын Засгийн газар НҮБ-тай хийсэн гэрээ конвенцийг зөрчиж байна гэж би үзэж байна.

- Дараагийн миний сэтгэл зовниж буй асуудал бол хүнд ноцтой гэмт хэрэг үйлдээд 30 жилээр гянданд ял эдэлж буй хүмүүсийн хоригдож буй орчин нөхцөлийн талаар асуудал байна. Бид Тахир соёт дахь онцгой дэглэмтэй хориход

очсон, энд 30 жилээр гянданд хоригдох ял авсан 9 хүнтэй уулзаж ярицсан, энэ хугацаанд бид нарын үзсэн харсан зүйл бол, тэр хүмүүсийн хоригдож байгаа нөхцөл болон камер нь хэмжээний хувьд маш бага байсан бөгөөд хүнд нөхцөлд хоригдож буй нь олт байлаа. Энэ бүх байдлыг хараад сэтгэл зовнихийн хажуугаар НҮБ-ын олон бичиг баримтад, "...олон жилээр хорих ял авсан хүн нь аль болох олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдах болон энэ чиглэлээр нөхөн сэргээгдэх үйл ажиллагаа явагдах ёстой" гэсэн зарчим, стандарт зөрчигдөж буйг харсан.

- *Урьдчилан хорих төвүүдэд саатуулагдсан болоод хоригдсон хүмүүс нь тухайн урьдчилан хорих төвд ажилладаг төрийн албан хаагчдын дарамтанд байдаг, зодуудаг түүнээс гадна харгалзагч нар үүрэг өгч бусад хоригдож буй хүмүүсээр тэр хүмүүсийг зодуулах, дарамтлуулах асуудал ихээр тааралдаж байлаа. Хүнийг ийм маягаар эрүүдэн шүүж, зодон тамлаж, хэргийг нь хүлээлгэх ийм практик Монголд маш их байна гэж үзэж байна.*

- *Дараагийн нэг ажигласан зүйл бол жирийн дэглэмтэй хорих ангиуд нь урьд өмнөөсөө сайжирсан гэсэн дүгнэлт хийсэн. Тухайлбал, хорих ангийн орчин цэвэр, хоолны асуудал сайжирсан гэж үзэж байгаа.*

- *Ерөнхий Прокурорын газрын дэргэд Мөрдөн байцаах алба Монгол улсад байгуулагдсан байна, хууль сахиулах байгууллагын ажилтнууд хэрэгт сэжигтэнгээр татагдсан этгээдүүдийг дарамтлах, зодох болон тухайн хэрэг дээр цагдаагийн ажилтануудыг мөрдөн шалгах ийм үүрэгтэй алба байгаа. Гэтэл тус газар нь үйл ажиллагаагаа идвэхтэй сайн явуулж чадахгүй байгаа гэсэн дүгнэлтэд хүрч байгаа, тийм ураас энэ чиглэлээр гомдол хүлээж авах анхан шатны мөрдөн байцаалтыг явуулахад тусгай бие даасан байгууллагыг байгуулах нь зүйтэй гэж үзэв.*

- *Эрүүдэн шүүсэн этгээдүүд ял завших асуудал Монгол улсад маш ихээр байна. Үүнээс үүдэн Монгол улсын Эрүүгийн хуулинд хүнийг эрүүдэн шүүх, тарчлаан зовоох гэмт хэргийн тодорхойлолтыг өгөх, хуульчлах нь, ийм төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэгтнүүдтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой. Эрүүдэн шүүх бол хүнд гэмт хэрэг учраас үүнийг үйлдэж буй этгээдүүд хариуцлага шийтгэл хүлээх ёстой гэж үзэж байна.*

Түүнчлэн би Монгол улсын Засгийн газарт ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ялыг устгах түүнчлэн олон жилээр хорих ял оноох асуудал дээр анхаарч үзнэ үү гэж санал болгож байгаа. Түүнчлэн урьдчилан хорих төвүүдийн тоог цөөлөх, одоо байгаа урьдчилан хорих төвүүдийн нөхцөл байдлыг сайжруулах талаар мөн Засгийн газарт өөрийн зүгээс санал болгож байгаа.

- *Эцэст нь Монгол улсын Засгийн газрыг эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орохыг уриалан санал болгож байгаа. Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орсноор Монгол улсын ХЭҮК нь, энэ хэргүүдийн талаар эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, хорих байр, цагдан хорих байранд, хорих ангиудад байнгын хяналт үзлэг шалгалт хийх боломжийг олгож байгаа юм.*

Асуулт: Бидний мэдэж буйгаар Эрүү шүүлттэй тэмцэх нэлээд хэдэн Олон улсын механизм байдаг тэдгээрийн талаар болон хоорондын уялдаа хобооны талаар ярина уу?

Хариулт: *НҮБ-ын Хүний эрхийн хороо болон Эрүү шүүлтийн эсрэг хороо нь гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр тулгуурлан Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын дагуу ажиллах бөгөөд хяналтыг хэрэгжүүлэх маягаар хувь хүний гаргасан өргөдөл гомдлыг авч үзэх, улс орны илтгэлийг шалгах түүн дээрээ үндэслэн хяналт шалгалтын ажиллагаа хийх зэргээр үйл ажиллагаа явуулдаг. Гэхдээ тухайн үйл ажиллагаа нь тус конвенцид нэгдэн орсон улсад л хамааралтай байдаг. Миний хувьд дэлхий нийтэд хамаатай НҮБ-ын Дүрмийн дагуу ажлаа явуулдаг. Өөрөөр хэлбэл тухайн улс Эрүү шүүлтийн эсрэг Конвенцид нэгдсэн, эс нэгдсэн нь ач холбогдолтой биш юм. НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороотой Тусгай илтгэгч хамтран ажилладаг. Мөн Эрүү шүүлтийн эсрэг хороо нь тухайн улсад гарсан эрүү шүүлтэд төрөөс арга хэмжээ авсан эсэхийг шалгадаг.*

Асуулт: Та Монголын талаар хувийн сэтгэгдлээ ярина уу?

Хариулт: *Монголд ирсэндээ би их баяртай байгаа. Гол нэг ажигласан зүйл бол хаана ч хотод ч, хөдөө ч хүмүүс нь маш их найрсаг байсан гэж хэлмээр байна.*

Монголын байгаль их таалагдсан, олон сайхан үзэсгэлэнтэй газруудтай юм билээ.

Бидний энэ удаагийн айлчлалд НҮБ-ын хамт олон, найзууд болон бусад ажлын шугамаар харьцаж байсан болон эргэн тойрны хүмүүс их тусалсан юм.

Надад хүндэтгэл үзүүлж, сэтгүүлдээ ярилцлага авч буй, “Хүний эрх” сэтгүүлийн редакцид чин сэтгэлээсээ амжилт хүсье.

Редакци:

Танд баярлалаа, таны ажилд амжилт хүсье.

МОНГОЛЫН ЗАН ЗАНШИЛ, СОЁЛЫН ХҮЧИН ЗҮЙЛС ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХЭД НӨЛӨӨЛЖ БАЙГАА НЬ

(ХЭҮК, Эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийг дэмжих төслөөс Эрдэмтэн судлаачдын дунд, “Монголын зан заншил, соёлын хүчин зүйлс эмэгтэйчүүдийн эрхэд нөлөөлж байгаа нь” сэдэвт шилдэг илтгэл шалгаруулах уралдаанд 1-р байр эзэлсэн итгэл)

Ч.Алтангэрэл

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Түүх, Нийгмийн Ухааны
Сургуулийн Нийгмийн ухааны тэнхим, Философийн багш.

Дэлхий дээрхи бүх эмэгтэйчүүдийн тэн хагас нь нэг л хэлээр ярьдаг.

Тэрхүү хэл нь “дуугүй байх” явдал.

/Миннесотагийн Их Сургуулийн ханан дээрхи бичээснээс/

Хүний эрх нь хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлс болохынхоо хувьд үндэс угсаа, нас хүйс, нийгмийн гарал байдал үл хамааран бүхий л улс үндэстнүүд, овог аймаг, шашин шүтлэгтнүүдэд нийтлэг бөгөөд хүчин төгөлдөр байх ёстой юм. Гэвч өнгөрсөн хийгээд өнөөгийн түүх нь хүн төрөлхтөний эрх, эрх чөлөөний асуудал нь янз бүрийн соёл уламжлал болон төр улсын хэлбэр байгууламжаас шалтгаалан олон янзын арга хэлбэрээр өрнөж ирснийг гэрчилнэ.

Хүнд төрөлхөөс нь заяасан эрхүүд гэж байдаг. Хүний эрх бол хүн болж төрснийхөө хувьд угаас заяасан төрөлх чанар бөгөөд түүнийг жам ёсны дагуу эдлэх эрх чөлөө мөн. Гэтэл маш олон эмэгтэйчүүд зөвхөн “эмэгтэй” болж төрснийхөө төлөө тэрхүү эрхүүдээ эдэлж чадахгүй байгаа нь ихээхэн харамсалтай хэрэг билээ.

Энэхүү сэдвийн дагуу эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийг өөрийн орны зан заншил, соёлын хүчин зүйлсийн үүднээс дүн шинжилгээ хийхийг чармайсан болно.

Өнөөг хүртэл олон оронд эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөө их, бага ямар нэгэн байдлаар зөрчигдсөөр ирсэн бөгөөд цаашдаа ч энэ байдал үргэлжлэх хандлага байсаар байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл маш олон төрлийн арга хэлбэрээр өдөр тутмын амьдрал бүхий л нийгмүүдэд оршсоор байна. Эмэгтэйчүүд өдөр тутам зодуулж, гэмтэл шарх авч, эрэмдэглэгдэх, мөн бэлгийн хийгээд сэтгэл санаа, эд материалын янз бүрийн дарамт хүчирхийлэлд өртөж байна¹.

Үүний үр дүнд НҮБ-аас Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци (ЭЯГБХУК, 1971)-ийг батлан, түүний зарчмуудыг даган биелүүлэх, хэрэгжүүлэхийг тунхагласан байна. Гэвч эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тэдний эрх чөлөөг санаатай хийгээд санамсаргүйгээр зөрчих явдал байсаар байна. Энэ нь хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо нь эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалах найдвартай баталгаа болж чадахгүй байгааг харуулж байна.

¹ UN Fact Sheet # 23. Harmful traditional practices affecting the health of women and children. 1998

CEDAW буюу ЭЯАГБХУОУК-ийн 1-р зүйлд “эмэгтэйчүүдийг алагчлах гэдэг ойлголт нь эмэгтэйчүүдээс тэдний гэр бүлийн байдлаас хамаарахгүйгээр эрэгтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм соёл, иргэний болон аливаа салбарт хүний эрх, эрх чөлөөг эдлэх хэрэгжүүлэхэд нь хүйсээр ялгаварлах буюу хязгаарлахыг хэлнэ” хэмээн тодорхойлж өгсөн. Мөн 2-р зүйлийн “Д”-д дурьдсанаар эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан хууль тогтоомж, зан заншил, дадлыг өөрчлөх буюу хүчингүй болгох талаар зохистой арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээ авах хэмээсэн байна.

Хэдийгээр манай улсад harmful traditions буюу Африк, Ази, Ойрхи дорнодын болон Латин Америкийн зарим орнуудад даган мөрдөж ирсэн хүчээр богтлон суух, олон эхнэртэй байх, гивлүүр зүүх, эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний хэлүүг огтлох зэрэг өнөөгийн соёлт нийгэмд цочирдом боловч тухайн нийгэмдээ уламжлал болон ирсэн хортой зан үйл, заншлууд²³ үгүй боловч ахуй, сэтгэлгээний уламжлал, түүнээс улбаалсан зөрчлүүд байсаар байна. Үүнийг бид өөрсдийн дорнын соёлын өв уламжлал, язгууртай холбон үзэж болох юм. Ерөөс хүний эрхийн дэлхий дахины мэтгэлцээний нэгэн гол сэдэв бол хүний эрхийн хэм хэмжээнүүд улс үндэстэн, шашин шүтлэг, соёл уламжлалын шинжээс хамааран харьцангуй шинжтэй тухай “Соёлын харьцангуй чанарын” онол юм.

Соёлын харьцангуй чанарын онол нь ХХ зууны эхэн үеэс хүний эрхэд холбогдох олон улсын эрх зүй, гадаад бодлого, соёлын болон антропологийн судалгааны салбарын мэдлэгийн харилцан интеграцийн үр дүнд Өрнөдийн соёл иргэншил нь хөгжлийн хамгийн дээд шат хэмээн үздэг Евроцентрист хандлагыг шүүмжлэх агуулгаар бүрэлдэн бий болсон гэж үздэг. Хүний эрхийн харьцангуй байдлыг номлогчдын гол бүрэлдэхүүн болох Ази, Ойрхи дорнодын болон гуравдагч ертөнцийн орнууд өөрсдийн соёл зан заншил, шашин шүтлэгийн язгуур чанаруудад нийцсэн хүний эрхийн альтернатив хэв маягийг идэвхтэй эрэлхийлж, номлож ирсэн. Тухайлбал, “Хинди иргэншил дэх хүний эрх”, “Исламын шашин дахь хүний эрх” зэрэг ойлголтууд орчин үеийн улс төр, хууль эрх зүй, философийн бүтээлүүдэд ихээхэн тохиолдох болсон. Тэдний хувьд улс үндэстэн, шашин шүтлэг, бүс нутгийн соёлын ялгарал, олон ургальч байдлыг илэрхийлсэн хүний эрхийн олон улсын хэм хэмжээ бүрдүүлэн, түүний үйлчлэх механизмыг тодорхойлоход чиглэдэг.

Уг онолыг баримтлагчдын үзэж байгаагаар Азийн улс үндэстнүүдийн дундахь нийтлэг нэг шинж бол уг бүс нутагт хувь хүнийг бус харин тэдгээрийн нийтлэгийн эрх ашиг, хэм хэмжээг илүү эрхэмлэн үздэг явдал юм. Тухайлбал, судлаач Хиаоронг Лигийн үзсэнээр⁴ “Дорнын болон Өрнөдийн соёл, уламжлал дахь хамгийн том ялгаа бол хувь хүн ба нийтлэгийн харилцааны асуудал мөн. Ази тивийнхний хувьд түүхэн уламжлалын дагуу гэр бүл, овог аймаг, улс үндэстний гэсэн тодорхой нийтлэгүүдийн нэгэн гишүүн болох тухай мэдрэмж, сэтгэлгээ зонхилдог бол өрнийн соёлт ард түмнүүдийн хувьд өөрийн “БИ”-г эрхэмлэх чанар давамгайлдаг” байна. Иймээс хүний эрхийн тухайд өрнө дахинд “Хувь хүн төвт хандлага” баримталж байгаа бол Ази тивийнхний хувьд “нийтлэг төвт хандлага”-ыг илүү

² UN fact Sheet # 23. *Harmful traditional practices affecting the health of women and children*. 1998

³ Xiaorong Li *Asian values and Universality of Human Rights, Research Paper*

⁴ Хүний Эрхийн Үндэсний Комиссын “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл (2002 он) хууд. 41

эрхэмлэдэг хэмээн хэлж болно. Үүнээс гадна Ази төвт хандлагыг дэмжигчид “Хувь хүн төвт хандлага” нь хүний хамтын аж төрөх ёсыг орхигдуулж, нийгмийн дотоод зүй зохицол, тусгаар тогтнолд сөрөг нөлөөтэй байж болох юм хэмээн шүүмжилдэг байна. Эндээс бид өөрсдийн зан заншлыг чандлан мөрдөж, төр засгаа, шашин шүтлэгээ, уул усаа тахин шүтэж ирсэн билээ. Үүний үрээр Монголчууд бид “эр хүнийг төрийн хүн” хэмээн дээдэлж, “эмэгтэйчүүд гэрийн хүн” хэмээн ойлгож төсөөлж, бас мөрдөж ирсэн билээ.

Ийнхүү Монголчуудын уламжлал, зан заншил эмэгтэйчүүдийн эрхэд хэрхэн нөлөөлж байгаа талаар дараахи байдлаар шинжлэн үзье.

Нэгэн зүйл: Эцгийн эрхт ёс нь Монгол дахь эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийн үндсэн шалтгаан мөн.

Хэдийгээр хүний эрхийн хэрэгжилтэнд нийгэм улс төрийн тогтолцоо, эдийн засгийн хүчин чадавхи, боловсролын түвшин зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байгаа боловч эмэгтэйчүүдийн эрхийн хамгийн гол зөрчил, түүний үндэс язгуур нь “Патриархаль буюу эцгийн эрхэт ёс” хэмээн үзэж болох юм. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн хоорондын патриархаль харилцаа нь тэгш бус байдлын хамгийн анхдагч, мөн ялгаварлан гадуурхах, үл хүндэтгэх үзлийн гол учир шалтгаан хийгээд үр дагавар болж байна. Хүйсийн хооронд буй биологийн ялгааг нийгмийн бүхий л харилцаа, сэтгэл зүйн хүрээнд онцлон үзэх замаар патриархаль харилцаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хоорондын тэгш бус байдал, шатлан захирах ёсыг ямагт дэмжиж байдаг.

Энэхүү цэгээс бид олон зөрчлийн эх сурвалж, язгуур үндсийг олж харж болно. Хүний эрхүүд маань өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой, салшгүй байдгийн адилаар хүний эрхийн зөрчлүүд нь мөн адил харилцан хамааралтай байдаг нь илэрхий байна. Судлаач миний үзэж байгаагаар, уг анхдагч үндсэн шалтгаан нь дараахи олон талт шалтгаануудыг нөхцөлдүүлж байна.

Нэгэн зүйл: Нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтууд нь эмэгтэйчүүдийн эрхийг зөрчих үндсэн шалтгаан мөн.

Энд хэвшмэл ойлголт буюу social stereotype гэдэгт ерөнхийд нь бид өвөг дээдсээсээ уламжлан авсан зан заншил, шашин шүтлэгийг хамруулан ойлгож байгаа ба эдгээр нь хүний амьдрал, сэтгэл санаанд хэрхэн нөлөөлж байгаагаас хүний эрхийн асуудал мөн шалтгаалж байна. Олонхи соёл уламжлал болон сэтгэлгээнд эрэгтэйчүүд анхдагч буюу тодорхойлогч, давуу, хараат бус бие даасан зэрэг давуу шинжээр ойлгогддог бол харин эмэгтэйчүүдийн хувьд эдгээрийн эсрэг ойлголт болох сул дорой, эмзэг, хараат зэрэг шинж чанараар илүү тодорхойлогддог. Үүний үрээр эрчүүд нийтийн буюу улс төр, засаглал, үйлдвэрлэл бизнесийн зэрэг ажил эрхэлж, харин эмэгтэйчүүд нь гэрээ цэвэрлэх, хүүхэд төрүүлж асрах, хоол хийх гэх мэт гэр ахуйн буюу гүйцэтгэх ажил хийх ёстой гэсэн ойлголт тогтсон байдаг. Магадгүй, дээр дурьдан буй эцгийн эрхт ёсноос улбаалан эмэгтэйчүүдийг гоёл чимэглэлийн зүйлс, гал тогооны хүн, сул дорой хүйстэн зэргээр ялгаварлах хандлага нийгмийн сэтгэл зүйд төлөвшин тогтмой, өнөөг хүртэл амь бөх оршоор байгаа нь илэрхий. Тухайлбал, бидний өдөр тутмын амьдралын салшгүй нэгэн хэсэг болох олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, тэдгээрийн зар сурталчилгаагаар манай эмэгтэйчүүдийн амьдралын салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд нь гал тогооны сав угаагч шингэн, угаалгын нунтаг, саван

болохыг илүү тодорхой мэдэрнэ.

Мөн бидний бахархан ярих дуртай ардын цэцэн мэргэн ухаан, түүхэн өв соёлыг илтгэж байдаг зүйр, хэлц үгс дотор ч “Эр муу ч эмийн дээр”, “Эмэгтэй хүн үс нь урт, ухаан богино” гэсэн эмэгтэй хүнийг дорд үзсэн агуулга байдаг билээ.

Гэхдээ судлаач миний үзэж байгаагаар асуудлын гол нь үүнд хүмүүс огт эмзэглэдэггүй, “хэвийн” хэмээн үзэж байгаад оршиж байна. Нөгөө талаас эмэгтэйчүүдийн өөрийгөө чамлах, өөртөө үл итгэх байдал нь тэдгээрийг нийтийн хүрээнд оролцох идэвхи оролцоог бууруулдаг байна. Мөн нийгмийн философийн хичээлүүд, жендерийн харилцааны тухай мэтгэлцээнүүдэд олон эмэгтэй оюутнууд хүйсийн хоорондын тэгш бус байдлыг зөвтгөж, түүнийг өөрийн амьдралдаа даган мөрдөхөд бэлэн байдгаа илэрхийлж байдаг. Гэвч энэхүү асуудлыг өөрийн гол сэдэв болгон дэвшүүлэн тавьдаг феминист философийн хийж буй дүгнэлтээр “энэхүү нийгэмд тогтсон эмэгтэйчүүдийн дүр төрх нь түүхэн шинжтэй зохиомол зүйл бөгөөд эр хүйсд тулгуурласан нийгэм дэх тэгш бус байдлын гол илрэл” хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл эм хүйсийн хувьд нийгмийн хоёрдогч буюу дагавар хүйс хэмээх ойлголт бүрэлдэн тогтсон ба нийгэм дэх зан заншил, уламжлалын механизмаар дамжин нэг үеэс нөгөөд уламжлагдан дамжиж, улмаар сэтгэлгээний хэв загвар болон тогтдог байна.

Нэгэн зүйл: *Хувийн болон нийтийн хүрээний тусгаарлалт нь эмэгтэйчүүдийн эрхэд сөргөөр нөлөөлж буй бодит байдал мөн.*

Мэдээж та хувь хүн болж төрснийхөө хувьд өөрийн гэсэн хувийн амьдрал, гэр бүлтэй, нөгөө талаас нийгмийн нэгэн гишүүн болохын хувьд ажил төрөл, бизнес, урлаг соёл зэрэг олон нийтийн гэж болох амьдралын хүрээнд зэрэгцэн оршиж буй заа. Хувийн амьдрал ямар хэм хэмжээ үйлчилдэг вэ? Ихэвчлэн бичигдмэл бус дадал заншил, ёс суртахууны гэх мэт хэм хэмжээ үйлчилнэ. Харин нийтийн түвшинд албан ёсны бичмэл хууль дүрэм журам үйлчилнэ. Мөн үүний адилаар статусыг нийгмийн ба хувийн статус гэж ангилдаг. Нийтийн буюу эрх мэдэл, засаглал, орлогын төлөөх харилцаанд нийгмийн статус илүү үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, хүн ямар хүрээнд харьяалагдаж байна вэ гэдгээсээ хамаараад янз бүрийн статустай байдаг. Жишээ нь эмэгтэй хүн зөвхөн хувийн хүрээнд байснаар цөөхөн хязгаарлагдмал статустай байдаг бол нийтийн хүрээнд оролцох нь түүнд нийгмийн статусыг олгож, ингэснээрээ түүний нийгмийн байр суурийг дээшлүүлэх боломж бололцоо олгоно. Статус өндөр болоход эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх нь бага, өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэддэг зэрэг олон давуу талууд бүрэлдэнэ. Тиймээс тэдгээр эмэгтэйчүүдийн эрхийн зөрчил нь гэр бүлдээ байдаг эмэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй бага байдаг болох нь судалгаагаар нотлогджээ.

Эмэгтэйчүүд нь хувийн буюу гэр бүлийн хүрээнд хүчтэй өрсөлддөггүй, тийм боломж ч үгүй байдаг. Харин нийтийн хүрээнд та ямар нэг улс төрийн болоод эдийн засгийн хувьд нийгэм дэх өөрийн статусыг дээшлүүлэхийн тулд бусадтай өрсөлдсөөр байдаг. Гэхдээ өнөөгийн Монгол оронд эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголт нь бүрэн арилагүй байгаагаас нийгэмд энэ боломж нь зөвхөн эрэгтэйчүүдэд илүүтэйгээр олгогдоод, харин эмэгтэйчүүдэд маш хязгаарлагдмал байна. Үүний нэгэн баталгааг бид өдөр тутмын сонинууд дээр гарах ажлын байрны зарууд дээрхи “хүйс”-ийн шалгуур заасан хэсгээс олж болно. Хүний Эрхийн Үндэсний Комиссын “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай

илтгэл (2002)-д дурьдсанаар “Ажил эрхэлж буй салбарыг хүйсээр харьцуулан харвал эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг бодвол боловсрол, эрүүл мэнд, зоогийн газар, санхүүгийн ажлыг илүү эрхэлж байна. Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харахад боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 40.3 мянгаар, зочид буудал, зоогийн газар, санхүүгийн салбарт 5.6 мянгаар их байгаад зогсохгүй, боловсруулах үйлдвэр, худалдааны салбарт эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс илүү байна⁵.” Өөрөөр хэлбэл, одоогийн Монголчуудын амьжиргааны эмзэг түвшинд оруулан тооцож буй “цалин хөлс бага, ядуу төсвийн байгууллагууд” болох сургууль, эмнэлэг зэрэг нь эмэгтэйчүүдийн ажлын байрны зонхилох хэсгийг бүрдүүлж байна. Энэ байдал нь Монгол улсын Үндсэн хууль (1992)-ийн үзэл баримтлал болоод Хөдөлмөрийн тухай хууль (1999)-ийн 7.2-д “Хөдөлмөрийн харилцаанд үндэс угсаа, арьсны өнгө, эрэгтэй эмэгтэй, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.” хэмээн заасныг зөрчиж байна. Монголын олонхи бүсгүйчүүд, ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүд гэр бүлийнхээ хүрээнд илүү их хөдөлмөрлөдөг, олон нийттэй харилцах нь бага тул тэр хэмжээгээр нийгэмд эзлэх байр суурь бага байх хандлагатай. Иймийн тулд тэднийг хувийн хүрээнээс нь олон нийтийн хүрээнд оролцох оролцоог нэмэгдүүлснээр нийгэм дэх өрсөлдөөн ихсэж, улмаар нийгмийн хөгжил хурдсаж, жендэрийн тэгш байдал хангагдах учиртай.

Нийгмийн хөгжлийн үйл явцад “хувийн ба нийтийн” хэмээн тодорхойлж буй дээрхи хүрээнүүд нь өөр хоорондоо тусгаарлагдаж, холдсоор буй тул аливаа хүн хоёр хүрээнд зэрэг оролцох боломжийг шууд үгүйсгэдэг. Өөрөөр хэлбэл: эмэгтэй хүн олонхи тохиолдолд гэр бүлийнхээ хүрээнд байх нь нийгмийн хүрээний өрсөлдөөнд оролцох боломжийг хязгаарладаг. Үнэхээр эмэгтэйчүүдэд үр хүүхдээ төрүүлж өсгөх, хүмүүжүүлэх нийгмийн үүргийг байгалиас заяасан учраас тэд өөрсдөө энэхүү сонголтыг хийдэг. Харин асуудлын нөгөө тал нь Ю.Хабермасын тодорхойлсноор “Эмэгтэйчүүд хэдийгээр нийтийн хүрээнд амжилт гаргаж чадах боловч хэзээ ч хувийн хүрээнээс салж чадахгүй, түүнтэй ямагт холбоотой байдаг байна.” Ийм учраас тэд нийгмийн хүрээнд илүү эрчимтэй оролцож амжилт гаргахын тулд өөрийн гэр бүлийн амьдралаа золиослох шаардлагатай тулгарч байна. Үүнийг бид тодорхой нэр хүнд олж амжилтанд хүрсэн эмэгтэйчүүдийн олонхи нь өөрсдийн хувийн амьдрал, гэр бүлээ орхин байж нийтийн хүрээнд оршин тогтнох сонголттой тулгардаг жишээнүүдээс харж болно.

Нэгэн зүйл: *Эмэгтэйчүүд нийгмийн үүргээ гүйцэтгэж буйн төлөө тэдний хөдөлмөрийг үнэлгээжүүлэх шаардлагатай.*

Эмэгтэйчүүдийн хувьд хүүхэд төрүүлж өсгөх нь зөвхөн гэр бүлийн төдийгүй, **НИЙГМИЙН** үүрэг байдаг. Тиймээс тэдгээр хөдөлмөрүүдийг үнэлгээжүүлснээр тэдгээрийн эдийн засгийн эрх мэдэл өндөрсөж, улмаар эрэгтэйчүүдээс хараат бус болж, өөрсдийн бие даасан байдлыг олж чадна.

Судлаач Ричард Роббинс “Global Problems and the Culture of Capitalism 1999” номондоо: эмэгтэйчүүд дэлхийн нийт ажил хөдөлмөрийн 2/3-г хийдэг атлаа нийт орлогын 10%, өмчийн зөвхөн 1%-ийг л эзэмшдэг⁶ гэжээ. Яагаад хүмүүс энэ

⁵ Richard H. Robbins “Global Problems and the Culture of Capitalism 1999, p 124

⁶ Хүний Эрхийн Үндэсний Комиссын “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл (2002 он) хууд. 43

хүйсийн тэгш бус байдлыг анхаарч үздэггүй вэ гэхлээр эмэгтэйчүүд зөвхөн хувийн хүрээндээ үнэлгээгүй хөдөлмөр эрхэлж байгаа юм. Хувийн хүрээ нь хуульчлагдаагүй, үнэлбэр бус хөдөлмөрийн сектор хэмээн тооцогддог учир тэнд эмэгтэйчүүдийн үнэлгээгүй хөдөлмөр ихээхэн хэрэгждэг байна. Хүний Эрхийн Үндэсний Комиссын мөн илтгэлийн “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх” хэмээх бүлэгт “Гэр бүлийн хүрээнд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн тэгш байдал уламжлалт зан заншлаас шалтгаалж ялгавартай байсаар байна. 2000 онд хийсэн ҮСГ-аас хийсэн Цаг ашиглалтын судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс /хотод 2 цаг, хөдөөд 6 цаг 30 минут/ илүү олон цагийг гэрийн хөдөлмөрт зарцуулсаар байгаа дүн гарсан. Ийнхүү эмэгтэйчүүдийн гэрийн хөдөлмөрт зарцуулах цаг их байгаа нь тэдний өөрсдийгөө боловсруулах, хөгжих боломжийг хязгаарлаж байна⁷. Уламжлал ёсоор эмэгтэйчүүдэд ноогддог тодорхой үүрэг, хөдөлмөрийг үнэлгээжүүлж, нийгмийн хамгаалал, даатгалын тогтолцоонд хамруулснаар эмэгтэйчүүд илүү их эдийн засгийн эрх мэдэлтэй болж, улмаар тэгш эрхийн асуудал аяндаа шийдвэрлэгдэх юм. Гэтэл ихэнх хүмүүс эмэгтэйчүүд бүгд дарга болчихоод гэрийн ажил хийх хүнгүй болчих мэт айдас болгоомжлол /бидний хоёрдугаар асуудал болгон дэвшүүлсэн нийгмийн хэвшмэл ойлголт, stereotype/ байсаар байгаа нь тэдэнд энэ боломжийг олгоход хаалт болж байна. Энэ талаар Скандинавын зарим улс орнууд дэвшил хийж, хүүхэд асарсан хугацааг хөдөлмөр эрхэлсэнд тооцох, даатгалын системд хамруулж цалин хөлс олгодог зэрэг нь ихээхэн үр дүнтэй арга хэмжээ юм.

Дээр дурьдан эдгээр хүчин зүйлүүд бол асуудлын зөвхөн нэг л тал хүрээ болохыг хэлэх нь илүүц биз ээ. Мэдээж аливаа эрх, эрх чөлөөний зөрчлийн томоохон шалтгаануудын нэг бол нийгэм эдийн засгийн хүчин чадал, түүнээс хамаараад иргэдийн хүлээж авч мэдээлэл, нийгмийн халамж хамгаалал, боловсрол эрүүл мэндийн буюу товчоор хэлбэл, төрийн үйлчилгээний асуудал билээ. Игэдийн улс төрийн идэвхи оролцоо, нийгмийн зүгээс хүлээж авч буй ачаа дарамт, хот ба хөдөөгийн ялгаа, хөдөлмөрийн чадвар зэрэг өөр бусад олон хүчин зүйлүүд хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг тодорхойлоход нөлөөлдөг. Тухайлбал, “хөдөө орон нутгийн боломж, бололцоогоор ядмагхан амьдрал хөдөөгийн эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, тэдний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг зөрчиж байна. Үйлчилгээний хүртээмж муу, хэрэглээний хомс байдал, орлогын ядуурал зэргээс болж, гадуурхагдах, гэр бүлийн хүчирхийлэл үүсэх шалтгаан болох зэрэг сөрөг нөлөө гарч ирдэг. Түүнээс гадна хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлөх байгаль орчны үзэгдлийг ч бий болгож байна. Үүний зэрэгцээ орлогын ядуурал, хөдөөгийн эдийн засгийн бэрхшээлтэй, олон асуудал, аливаа хүнд ачааллыг хөдөөгийн эмэгтэйчүүд нуруундаа үүрч, цаг зав, эрч хүчээ тэдгээрийг даван туулахад зориулж байна. Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээг нягтлан үзэхдээ гэрийн хүнд хүчир ажлын их ачааг үүрснээс болж, эмэгтэйчүүд ядарч туйлдаж байгаа асуудлыг анхааралгүй орхигдуулаг байна⁸.” хэмээсэн судалгааны дүгнэлтээр энэхүү сэдэвт холбогдох асуудлын бусад талыг төлөөлүүлэв.

⁷ НҮБХХ Монголын хөдөө дэх жендерийн дүр зураг: Бодлогод тусгах тоо баримт ба мэдээлүүд
УБ. 2003. хууд. 138

⁸ The People’s Movement for Human Rights Learning /PDHRE/ www.pdhre.org

Энэхүү илтгэлийн дараагийн хэсэг бол эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг дээшлүүлэх, гарч буй зөрчлийг арилгах зэрэг цаашдын арга хэмжээнд хандаж байна. Илтгэлийн эхэн хэсэгт гаргасан нэгэн санаагаар хүний эрхийн асуудал өөрөө олон талтай, өргөн агуулгатай бөгөөд үүнийг даган хүний эрхийн зөрчил, эрсдэл үүсэн гарах олон үндэс шалтгаан байгааг гаргаж байсан. Үүний адилаар хүний эрх, ялангуяа эмэгтэйчүүдийн эрхийг дээшлүүлэх, эрх чөлөөт байдлыг хангахад мөн олон талт арга зам, бодлогыг баримтлан хэрэгжүүлэх шаардлагатай нь тодорхой болж байна. Иймд дээр дурьдаж буй эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтэнд нөлөөлж буй харилцан уялдаа холбоо бүхий хүчин зүйлүүдийн сөрөг нөлөөллийг аль болох бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд:

- Патриархаль харилцааг ойлгох, өөрчлөхийн тулд юу хийх, юунд суралцах ёстой вэ?

§ Хүний эрхийг хүндэтгэх хандлагад тулгуурласан нийгмийн зохион байгуулалтын зарчмуудыг хэрхэн боловсруулж, мөрдөх вэ?

§ Патриархаль харилцаа, дэг журмыг өөрчлөхийн тулд хүний эрхийн стандарт, механизмуудыг хэрхэн ашиглах вэ? хэмээх олон асуудлууд дэвшигдэж байна.

Үүнийг ярихын тулд бид зарим дүгнэлтийг хийж үзье. Тухайлбал илтгэлд дурьдан буй эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтэд нөлөөлж байгаа зан заншил, соёлын хүчин зүйлүүд нь дан ганц Монгол орны өвөрмөц байдал биш болохыг тэмдэглэх нь зүйтэй. Ерөнхийдээ дэлхий дахинд эрчимтэй өрнөж буй феминист хөдөлгөөний гол агуулга нь дээрхи эцгийн эрхт харилцаа, нийгэмд тогтсон “хоёрдогч хүйсийн” хэвшмэл ойлголт, тэдгээрээс урган гарч буй сөрөг үр дагавар, хандлагуудтай тэмцэхэд оршиж байна. Тухайлбал, ХХ зууны II хагаст өрнөсөн феминист хөдөлгөөн нь “Ялгаа бүхий тэгш байдал” гэсэн уриан доор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн хэлбэрийн төдий тэгш байдлыг нийгмийн бодит үйл хэрэг болгохын төлөө чиглэж байна. Үүний нэгэн салаа мөчир болох “Хүний эрхийн боловсролын төлөөх Ард түмний хөдөлгөөн” хэмээх санаачлага 1992 оноос үйл ажиллагаа эхэлсэн тэрхүү хөдөлгөөний дэвшүүлж байгаагаар хүний эрхийг зөрчих, үл тоомсорлохын хамгийн гол үндэс шалтгаан бол патриархаль харилцаан дээр тулгуурласан нийгмийн зохион байгуулалт бөгөөд үүнтэй тэмцэх, түүний сөрөг үр нөлөөг бууруулах зорилгоор дэлхийн хэмжээний мэдээлэл, санал солилцох, туршлага судлах, гэгээрлийн үйл ажиллагааг санаачлан эхлүүлээд байна⁹. Монголчуудын хувьд олон улсын, дэлхийн хэмжээний дээрхи арга хэмжээ, туршлага солилцох үйл ажиллагаанд өргөн хүрээнд оролцож, өөрийн орны соёл уламжлалын онцлог, тэдгээрт үзүүлж буй нөлөөллийг харгалзан нэгдмэл бодлого боловсруулж, олон түвшинд хэрэгжүүлж эхлэх нь хамгийн бодитой үр дүн бүхий гарц байх болов уу хэмээн үзэж байна.

Мэдээж, энэ тохиолдолд төрийн болон төрийн бус байгууллагуудын түвшинд яригдах ба нөгөө талаас дээрхи “эмэгтэйчүүдийн” хэмээн нэрлэгдэх олон талт зөрчлүүдэд өртөх магадлалтай эмэгтэйчүүд өөрсдийн мэдлэг боловсрол, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар анхаарах, хамтран ажиллах, бусаддаа дэмжин туслалт шаардлагатай болов уу. Энэ тухайд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннаны хэлсэн “Өнөө болон ирээдүйд зөвхөн та л өөрийн эрхийг хэрэгжүүлнэ. Хүний эрх бол таны эрх. Тэдгээрийг эзэмш, хамгаал, дэлгэрүүл,

түүнийг ойлго, мөн түүнийг шаард. Тэдгээрийг тэтгэ, баяжуул” хэмээх үгийг сануулах нь зүйтэй биз ээ. Өөрөөр хэлбэл бидний амьдралд өөрчлөлт авчрах хамгийн оновчтой арга хэрэгслүүдийн нэг бол иргэдийн хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийн соёлыг нийгэмд түгээн дэлгэрүүлэх явдал болно. Иймээс хүний эрхийн боловсролын талаархи сургалт, судалгааны ажлыг тогтмол зохион байгуулах, үр дүнг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, ялангуяа эмзэг бүлгийнхэнд болон эмэгтэйчүүдэд хүний эрхийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг бүхий л түвшний байгууллагууд зохион байгуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь Монгол улсын засгийн газрын олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг билээ. Энэхүү хандлагын дагуу Монгол улсын засгийн газар, хүний эрхийн үндэсний комисс болоод бусад боловсролын байгууллага, судалгааны төвүүд, төрийн бус байгууллагуудын зүгээс хамтран бүтцийн шинжтэй өөрчлөлт, үр дүн бүхий үйл ажиллагаануудыг зохион байгуулж хэрэгжүүлснээр өнөөгийн бидэнд тулгарч байгаа хүний эрхийн зөрчил, учирч болох аливаа эрсдлүүдээс сэргийлж чадна.

ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХИЙН ЦӨӨНХ - ТУВАЧУУД

(ХЭҮК-оос Канад Сангийн дэмжлэгтэйгээр зарласан Насанд хүрэгчдийн дунд “Үндэстний цөөнхийн эрхийн асуудал Монголд” сэдэвт шилдэг эссэ-ний I-р байр эзэлсэн эссэ)

А.Амундра
ШУТИС-КТМС-ийн Програм Хангамжын
ангийн 2-р курсын оюутан

Сурагчдын маань дотор казах хүүхдүүд их өнгөтэй, хөгжил хөдөлгөөн сайтай, ухаантай сэргэлэн байхад тува хүүхдүүд дуугүй чимээгүй, хор шаргүй, ноомой байдаг.

Баян-Өлгий аймгийн 2 –р арван жилийн багшын үгнээс

Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд үндэстний цөөнхийн цөөнх болсон тува ястанууд хэдэн зууны турш үе дамжин амьдарч ирсэн билээ. Эзэн Чингисийн албат байх үеэсээ дайчин, үнэнч эх оронч байсан ард түмэн гэгддэг бөгөөд өнөө үе хүртэл түрэг хэл, тэнгэрийг дээдэлдэг бөөгийн шашин, арван гурван Алтай, гучин гурван Хурмастдаа сангаа тавьж нутаг усаа шүтэн хайрладаг олон арван зан үйл ёс заншлаа мартаж гээлгүй үр хүүхэд ач гучдаа дамжуулан өвлүүлж ирсэн өвөрмөц ястан юм.

Нийгмийн аливаа түрлэг, хувьслыг гэтэлж ирсэн үндэстний цөөнх болсон Тува ястан сүүлийн хагас зуун жилийн хугацаанд мөхлийн ирмэгт тулаад байна. Аливаа үндэстний (ястны) орших баталгаа нь тухайн үндэстний дархлаажуулалтын итгэлцүүрээр хэмжигдэнэ гэсэн “хүмүүнлэг дэлхийн” түгээмэл зарчим буй. Өөрөөр хэлбэл улс төрийн бодит оролцоо, эдийн засгийн аюулгүй байдал (оюуны болон материаллаг дотоод нөөц), хэл соёлын уламжлал ба түүний хамгаалал, газарзүйн болон хүний хөгжлийн таатай орчин зэрэг болно.

Тэгвэл Баян-Өлгий аймгийн 8500 гаруй хүн амтай Цэнгэл суманд 2000-уулаа буюу үндэстний цөөнхийн цөөнх болон аж амьдралаа залгуулж буй Тува ястаны хувьд дээрх итгэлцүүрүүд ямар түвшинд байна вэ?

1962 оны үеэс эхлэн Баян-Өлгий аймгаас Төв, Хэнтий, Сэлэнгэ аймгуудад зохион байгуулалттай ажилчин малчин элсүүлэн авч байхад Цэнгэл сумаас тувачууд ах дүүгээрээ, бөөн бөөнөөрөө нүүснээр тува хүн амын 60 гаруй хувь нь шилжиж, отог омгийн тоо цөөрч төрөл саднууд өөр хоорондоо гэр бүл болж, улмаар цус ойртох аюул заналхийлэх болсон. 1991 онд Хүн судлалын төвөөс Цэнгэл сумын тувачуудад цусны шинжилгээ хийж цус ойртож байгаа гэсэн дүгнэлт гаргасан. Шашин шүтлэг өөр учир сумандаа хамт амьдран суудаг казахуудтай гэрлэдэггүй. Цус ойртоно гэдэг нь ястан үндэстний биологийн буюу хүний хөгжлийн мөхөл юм. Энэ нь Монгол улсын Үндсэн хуулийн 16.2-т заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэсэн заалт зөрчигдөж байгааг харуулж байна. Түүнчлэн Хүний эрхийн тунхаглалын 16.3-т заасан гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй гэсэн зүйл зөрчигдөж байна.

Цэнгэл суманд ажиллаж байсан ХАА-н нэгдэл, артель, НААУ-ний төв, худалдаа бэлтгэлийн анги, зоо мал эмнэлгийн алба зэрэг улс хоршооллын олон байгууллага тарснаар ажилгүйдэл нэмэгдсэн юм. Өнөөдөр ажилгүй тува иргэдийн дотор дээд боловсролтой 13, тусгай дунд боловсролтой 27 хүн байна. Жил бүр 8 ба 10-р анги төгсөж байгаа залуучууд ажилгүйдлийн эгнээнд шилжиж байна. ХАА-н “Алтайн оргил” нэгдэл тарж мал, хашаа хороо хувьчлахад нэг өрхийн хүн амын тоо цөөнөөс болж бага хувь хүртсэнээр ядууралд илүү нэрвэгдсэн байна. Нэг казах өрх 6-6,5 хүнтэй бол нэг тува өрх 4-4,5 хүнтэй байдаг. Цөөн хэдэн мал нь зүй бусын хорогдол, амины хэрэглээ зарлагын ая даахгүй, нөхөн үйлдвэрлэл явагдаж чаддаггүй болох нь Тува ястаны улам бүр дордож буй амьдралаар нэгэнт нотлогдчихоод байгаа бодит үнэн. Мөн сүүлийн жилүүдийн ган зуд олон айлыг цайны сүүгүй болгож бүр ч нэрмэсэн гэдэг нь ойлгомжтой. Сумын ЗДТГ-т 2 албан хаагч, гурван тува багт багийн дарга, бага эмч нийт 6 хүн, тува бага сургуульд бага ангийн багш 8 хүн, нийт 16 албан хаагчаас өөр Тува сэхээтэнгүй байна. Эдгээрийн улмаас тувачуудын эдийн засгийн оролцоо үлэмж хэмжээгээр хумигдаж тува ястаны эдийн засгийн чадамж (ялангуяа оюуны нөөц) суларсныг гэрчилж байна.

Эхлээд амьдар, дараа нь философид гэгчээр “сурч боловсрохын тулд илүүчлэх орлогогүй” Тувачууд хүүхдээ их дээд сургуульд сургах зардлыг дааж чадахгүй байгаа бөгөөд хүүхдээ их дээд сургуульд явуулагчдын тоо үлэмж цөөн болсон байна. Сургуулиас завсардсан нь олширсон, цэрэгт татагдах нь цөөрснөөс монгол хэл мэддэг хүний тоо багассан, өөр хоорондоо төрөлх тува хэлээр ярьдаг, сум дотроо казах хэлээр харилцдаг учир улс аймгийнхаа нийгмийн амьдралын талаар үнэн зөв мэдээлэл авах бололцоо нь багассаар байгаа нь яг одоо “дэлхийн ард түмний” зорин алхаж буй “мэдээлэл бол мөнгө” гэсэн чиглэлээс хэт алслагдахад хүргэж байна. Түүнчлэн Сумын тува бага сургууль нь 280 орчим сурагчтай бөгөөд тува хэлээр бичигдсэн өөрийн гэсэн сурах бичиг үгүй учир ОХУ-ын Тува Улсаас тусламжийн шугамаар 4-5 жилд нэг удаа сурах бичиг хөөцөлдөж авдаг боловч сурах бичгийн хэллэг оросожсон, зарим нь ойлгогддоггүй зэрэг бэрхшээлүүд учирдаг байна. Энэ нь МУ-ын Үндсэн хуулийн **16.7**-т заасан сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байгаагийн бодит илрэл юм.

Урьдах нийгмийн тогтолцооны үед аливаа сонгууль томилгоонд захиргаадалтын аргаар ястан үндэстний бүтэц бүрэлдэхүүнийг бодлогоор зохицуулан тува ястныг тодорхой хэмжээгээр дэвшүүлдэг байсан нь байхгүй болж ардчилал олонхийн засаглалд шилжсэнээр баг сум, аймаг орон нутгийн удирдах байгууллагад төлөөлөгч нь сонгогдох тухай бодох ч хэрэггүй болж, цөөнхийнхөө санал бодлыг дээш хүргэх, улмаар улс төрийн эрхээ эдлэх бололцоо нь хаагдав. Ийнхүү шууд болон төлөөлөгчийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох түүнчлэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй гэсэн МУ-ын Үндсэн хуулийн **16.9**-дэхь зүйл зөрчигдөж байна. Мөн Хүний эрхийн тунхаглалын **21.1** (хүн бүр эх орноо удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй) болон **21.2** (хүн бүр улс орондоо төрийн алба хаших эрхтэй) дугаар зүйлүүд тус тус зөрчигдөж байгаа юм.

Түүнчлэн тува залуучууд архидах, хулгайн хэрэгт холбогдох, ямарч зорилгогүй өдөр хоногийг өнгөрөөн худал хэлэх, айл хэсэх, хов жив хөөцөлдөх, охид жирэмслэх, эцэггүй бутач хүүхэд төрүүлэх, итгэл үнэмшилгүй болох, амьдралдаа гутрах хандлагатай болоод байгаа нь цөөн тувачуудын хувьд маш том эмгэнэл гэхээс өөр тодорхойлох хэллэг үгүй мэт.

Тува ястаны хувьд дээр өгүүлсэн үндэстэн, ястаны оршихуйн итгэлцүүр коэффициент үндсэндээ “тэг” заалтуур дээр байна. Нэг ёсондоо Тува ястан мөхлийн ирмэгт тулаад байна.

Төвөөс ирж ажилладаг төр засгийн эрхтэн дархтан болон гадаад дотоодын ТББ, төсөл хэрэгжүүлэгчид Баян-Өлгий аймагт ирэхдээ зөвхөн казах үндэстэн, тэдний соёл зан заншлыг сонирхдог оос бус алс бөглүү Цэнгэлийн тувачуудыг мэдэрч, хүрч чадаагүй. Өөрөөр хэлбэл улс орон маань зах зээлийн эдийн засагт шилжсэн сүүлийн 10 гаруй жилийн дотор тувачуудын амьдрал ахуй доройтон ирээдүй нь бүдгэрч, тэдний нийгмийн асуудлыг шийдэгдэлгүй хуримтлагдан төр улсын бодлогын гадна үлдсэн юм.

Монгол улсын нутаг дэвсгэрт аливаа ялгаварлан гадуурхалаас ангид “мөр зэрэгцэн” аж төрөх жам ёсны эрхтэй Тувачууд нь Монгол Улсын төр засагт 1990-ээд оноос хойш Тува ястны улам бүр бүдгэрч буй ирээдүйн талаар удаа дараа хандсан боловч ямарч дэмжлэг авалгүй өнөөг хүрсээр ирсэн нь МУ-ын Үндсэн хуулийн гол зарчим хэрхэн хөндөгдөж, түүний хэрэгжилт ямаршуу хуурмаг байгаагийн баталгаа бүс үү.

Бид, нэгэн нарны дор амьдарч буй улс орон гэдэг нь, хүн төрөлхтний нийтлэг эрх ашгийг хүндэтгэн үздэг ард түмэн гэдэг нь, үндсэн хуулиндаа хүн хийгээд түүний амьдрах орчин болсон нийгмийн хөгжлийн жам ёсны зарчмыг тунхаглан баталгаажуулсан нь **үнэн юм бол** Тува ястны (үнэн хэрэгтэй нийт монгол угсаатны) төлөөх эн тэргүүний доорх алхамуудыг нэн яаралтай хэрэгжүүлэх ёстой.

Үүнд:

- Хууль эрхийн мэдлэг олгох, эрүүл аж төрөх ёс, эрүүл мэндээ хамгаалах, архи дан согтуурах болон хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх талаар байнгын мэдээлэл цацаж байх, ялангуяа өсвөр залуу үеийг энэхүү сурталчилгаандаа татах зорилгоор сумын төвд нь **тува хэлээр** ажилладаг FM-радио станцтай болгох
- Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулах арга ухаанд сургах сургалтуудад хамруулах, жижиг үйлдвэр бий болгох, хоршоонууд байгуулах боломж нөхцлийг судлан бий болгох
- Цэнгэл сумын байгалийн үзэсгэлэнт газруудаар гадаадын жуулчдыг аялуулах маршрут бий болгох, жуулчны бааз байгуулах талаар судлах
- Хэл заншил нэгтэй Ховд аймгийн Буянтын тувачууд, Хөвсгөл аймгийн Цагааннуурын тувачууд болон ОХУ-ын Тува Улсын тувачуудтай соёл урлаг биеийн тамир спортын тэмцээн нөхөрсөг уулзалт тогтмол зохиож залуучуудыг танилцуулан бие биеэс нь арга туршлага судлуулах, хөгжүүлэхэд анхаарах
- Монгол Улсын сонгуулийн тухай хуулинд үндэсний тойрог байгуулах тухай заалт оруулах
- Олон улсын байгууллагуудын анхаарлыг Тува ястанруу чиглүүлэх талаар төрөөс зохион байгуулалттай арга хэмжээ авах
- “Цахим засаглал” хөтөлбөрийг тувачуудад бодит хүртээл болгох зэрэг болно.

Соёл (хэл, шашин) болон геополитикын (хил хязгаарын) өвөрмөц дарамтанд буй Тува ястныг хөх монголын тэнгэр ивээг!

МИНИЙ МЭДЭХ ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХ

(ХЭҮК-оос Канад сангийн дэмжлэгтэйгээр зарласан, дунд сургуулийн 8-10 дугаар ангийн сурагчдын дунд “Миний мэдэх Үндэстний цөөнх” сэдэвт зохион бичлэгийн уралдааны I-р байр эзэлсэн зохион бичлэг.)

Б. Итгэлчимэг,
БЗД-гийн 14-р сургуулийн 8-а бүлгийн сурагч

Хамгийн олон үндэстэн ястны өлгий болсон Ховд хотод төрж өссөнөөрөө би бахархдаг. Ясли, цэцэрлэг, сургууль, гудамж, талбай, тоглоомын газарт би олон насны хүүхдүүдтэй нэг гэр бүлийн хүүхэд шиг тоглон өссөн билээ. Гэвч казак, захчин, торгууд, урианхай, чантуу гэх мэтээр ярихаас ямар ёс заншилтай гэдгийг тэр бүр мэддэггүй байлаа.

Аав минь нэгэн албан байгууллагын дарга байснаар би казак үндэстний зарим ёс заншил, амьдрал ахуйтай танилцсанаа хэзээ ч мартдаггүй юм.

Аав минь намрын нэг өдөр “Японы жуулчид ирсэн, тэд казак үндэстний амьдрал ахуйтай танилцах юм” гээд надыг дагуулж явж билээ. Би хүүхэд байсан /8 настай/ боловч тэр бүгд миний санаанд маш тод, дурсгалтай үл мөр үлдээжээ.

Энэ тухай санаа бодол, дурдатгалаа хуваах завшаан тохиосонд баяртай байна.

Бид өглөө эртлэн манай казак түмний нутаг хэмээн нэрлэгдэх хадтай өндөр шовх хадтай уулсаар хүрээлэгдсэн Ховд сумыг чиглэн УАЗ-469, ГАЗ-66 машинтайгаар хөдлөхөд би, аав, Японы уулчдын ахлагч, нэрт уулчин Ишими Вада сантай хамт нэг унаанд сууж явлаа. Зам зуур аав нутгийнхаа сонин хачин, уул усны түүх, түүний дотор олон ястны тухай хуучилсаар бид 10 цагийн үед хүрэх газраа ирэхэд тэд биднийг угтан авч аяллынхаа төлөвлөгөө, чиглэлийг танилцуулаа. Өндөр өндөр шовх цагаан гэрүүдтэй, эрэгтэйчүүд нь +20 градусын халуунд энгэр нь задгай хөвөнтэй хар хилэн дээлтэй янз бүрийн хээгээр чимсэн тоорцог малгайтай, эмэгтэйчүүд нь урт цагаан даавуугаар толгойгоо боосон, улаан ногоон голдуу тод цоохор өнгийн дан дээл өмссөн, чанга чанга ярьсан хүмүүс байв. Биднийг гэрт ороход овгийн ахлагч гэж өөрийгөө танилцуулсан урт цагаан сахалтай, том биетэй өвгөн гэрийн хоймрыг голлон суух бөгөөд хүн бүрт том том улаан, цэнхэр цоохор аяганд сүү амтагдсан гашуун /өтгөн/ шаргал цайг хийж өгөөд цагаан даавуу дэвсэн түүн дээрээ ааруул эзэгий, чихэр боорцог, өрөм гэх мэт идээ тавьсан бөгөөд энэ идээг “дастархан” гэж нэрлэдэг, мөн цайгаа ууж дуусаад аягаа доош харуулж тавьдаг гэж хэлснийг сонссон учир би аягаа доош хөмөрч тавихад намайг ихэд өхөөрдөн тэдгээр хүмүүс инээлдэхэд би их л гайхаж байснаа тод санадаг юм. Гэр дотор сандал ширээ байхгүй, эргэн тойрон цагаан эсгий ширж, түүнийг өөрсдийн үндэсний хээгээр чимж, тойруулан дэвссэн бөгөөд ханандаа нэхсэн хивсэнцэрүүд хадаж, хөнжил дэрийг мөн л нэхсэн уутанд хийж их л цэвэрхэн эвхэж хураасан нь эмх цэгцтэй харагдаж байв.

Хоол цай идэж уусны дараа биднийг дагуулан гарч ирэхэд нүд нь хаалттай том бүргэд шувуу гэрийн гадаа аргамжаатай байсныг анч бүргэд гэж танилцуулан түүнийг морь унасан хүн мөрөн дээрээ суулган, уяаг нь тавихад нисэж яваад

эргээд ирэхэд нь дахин мөрөн дээрээ суулган үзүүлэхэд анчин эр бүргэд чоно, үнэг, туулай зэрэг ямар ч анг их өндрөөс олж хараад барьж чаддаг тухай ярьж сонирхуулсан нь их л сонин байв. Тэнд морь уралдуулж, бөх барилдаж, хөдөөгийн сонин сайхныг үзүүлэхэд японы уулчид их л сонирхож, харин аав минь эд нар монголжсон казакууд гээд л тоглоом шоглоом хийж байхад тэд ч аавтай инээн наадаж байлаа. Орой хоолоо идэхэд бүгд завилж суугаад баруун алган дээрээ зүүн алгаа тавиад ном аялгуулан уншиж дууссаны дараа хоолоо идэж эхэлсэн. Ингэж л миний мэдэх цөөнхийн тухай цухасхан дурдахад ийм байна. Үүнээс үүдэн надад доорхи санаа төрдөг юм.

1. Хотын төвөөр явахад олон янзын нэртэй хоолны газар, бар, ресторан байдаг. Гэтэл үндэстний цөөнхийхоолны газар, гуанз, ресторан, кафе, дэлгүүр байж болмоор санагдана.

2. Сургууль хамт олон үндэстний цөөнхийн хувцас, урлаг, ёс заншилыг тусгасан уралдаан, тэмцээн, өдөрлөг зохиож байх.

3. Үндэстний цөөнх гэхээр зөвхөн казак гэж ойлгодог. Гэтэл урианхай, торгууд, дөрвөд, баяд, тува гэх мэт олон ястны зан заншил, ёс журмыг сурталчлах, тэдний амьдрал ахуйн талаар төрөөс бодлого боловсруулж ажиллах.

4. Урд өмнө үндэстний цөөнхийг албан тушаалд тавих, сургуульд сургах талаар нилээд анхаардаг байсан гэж аав, ээж минь ярьдаг. Харин одоо албан тушаал, төрийн ажилд нэг нутаг, хамт сургууль төгсөгчид, найз нөхдөө томилж байгаад анхаарч дээрх уламжлалыг нөхөн сэргээх нь зүйтэй юм.

5. Казак үндэстний телевизийн суваг ажиллуулбал зүйтэй болов уу. Учир нь миний амьдарч байсан хөдөө нутаг Ховдод, Баян-Өлгий аймгийн хөдөө нутгуудад үндэстний ёс заншил хадгалагдаж байдаг гэж би бодож байна. Харин хүн ам төвлөрсөн хот суурин газар энэ нь алдагдаж байгаа нь харамсалтай. Тэд өөрийн үндэстнийхээ ариун ёс заншлыг орхих ёсгүй мэт санагдана.

Гэхдээ миний сонсож, уншиж байснаар монголын казакууд ёс заншлаа хэвээр хадгалж байдаг гэдэг. Энэ бол манай төр засгаас авч явуулж байсан зөв бодлогын илрэл юм. Харин хойч үе бидний үүрэг нь цаашид энэ уламжлалыг алдагдуулахгүй байх юм.

Ахас ихэсээ хүндэтгэх, ажлыг хар бор гэлтгүй хөдөлмөрлөж сурсан хөдөлмөрч чанар, эмэгтэйчүүд охидын цэвэр ариун чанар, ардын уянгалаг сайхан аялгуу нь надад энэ үндэстний бахархал хэмээн санагдаж, хүндэтгэж явдаг.

Мөн жилд зөвхөн ганц л өдөр жилдээ нэг удаа болдог Наурызын баярт зориулсан нэвтрүүлгээс өөр казак үндэстний нэвтрүүлэг гардаггүй нь даанч чамлалтай санагддаг.

ОРОН НУТГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ НАРААС ИРҮҮЛСЭН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧИЙН УЛИРЛЫН ТАЙЛАНГИЙН ТОВЧООН

Д. Жаргалсайхан,
Говь-Алтай аймгийн хүний эрхийн
итгэмжлэгдсэн төлөөлөгч

- Аймгийн төвөөс алслагдмал Баян-Уул зэрэг сумдад хүний эрх, НҮБХХ-ийн тухай, нийгмийн халамжийн багц болон зөрчигдсөн эрхийг хамгаалах сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулан хичээл сургалт явуулж, эвхмэл хуудас бэлтгэн тараав.
- Есөнбулаг сумын Харзат, Баянхайрхан, Баяншанд, Жарглант багийн төвүүд дээр баг тус бүрийн тахир дутуу иргэдийг цуглуулан нийгмийн халамжийн хуулиуд, зөрчигдсөн эрхээ хэрхэн хамгаалуулах, ХЭҮК-ын үйл ажиллагааны онцлог, тахир дутуу иргэдийн эрхийг хамгаалах хангах талаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд сэдвээр сургалт явуулж тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдлын талаар ярилцлага зохион байгуулсан.
- Албан газрын удирдлагуудын 7 хоног тутмын Лхагва гарагт болдог цуглаан дээр захиргааны хэргийн шүүх, ХЭҮК, НҮБХХ-ийн талаар хүний эрхийн зөвлөлийн гишүүдтэй хамтран мэдээлэл хийлээ.
- Хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлаар хандсан иргэдэд хууль эрхийн үнэ төлбөргүй зөвөлгөө өгч шаардлагатай зарим тусламж дэмжлэг үзүүлж байна.

ТӨВ АЙМАГ, ОРОН НУТАГ БА ХҮНИЙ ЭРХ

С. Энхжаргал,
Төв аймгийн хүний эрхийн
итгэмжлэгдсэн төлөөлөгч

Төв аймгийн ИТХ-ын “Хүний эрхийг хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт дүгнэх тухай” 2005 оны 3-р сарын 25-ны өдрийн 3-р хуралдааны тогтоолоор аймгийн ИТХ-ын Хүний эрхийг хангах зөвлөлд үүрэг болгосны дагуу аймгийн хэмжээнд хүний эрхийн төлөв байдал, ялангуяа хөдөлмөрлөх эрхийн төлөв байдал ямар багаа талаар судалгаа явуулж дүгнэлт гаргалаа.

Судалгааг анкет асуулгын, ярилцлага ажиглалтын, баримт бичигт дүн шинжилгээ хийх зэрэг аргуудыг ашиглан аймгийн ИТХ-ын Хүний эрхийг хангах зөвлөл, Хүүхдийн

төлөө төв, ҮЭ-ын холбоо, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийнэмлэг хамтран 2005 оны 4-р сарын 10-наас 5-р сарын 25 хүртэл явуулсан болно.

Судалгаанд аймгийн 15 сум, Хүмүүн цогцолбор сургууль, 2-р цэцэрлэг, Чандмань ХХК, Ажлын хувцас ХК, Дади Монгол оёдлын үйлдвэр, Дулааны эрчим хүчний үйлдвэр зэрэг газрууд хамрагдсан байна.

Сум орон нутагт хүний эрхийн шийдвэрлэл зохих ямар тулгамдсан асуудал байна вэгэсэн нээлттэй асуултанд судалгаанд оролцогчдын 30% нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулж ажлын байрыг нэмэгдүүлэх 25% нь албан тушаалтнуудын ба иргэд олон нийтийн хүний эрхийн эрх зүйн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх сургалт сурталчилгааг өргөн явуулах, 15.6% нь орон нутагт сургууль төгссөн боловсон хүчнээ ажлын байраар хангах, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, 12% нь дарга албан тушаалтнуудын хүнд сурталыг багасгах, сумын ЗДТГ-ын ажилтнуудын хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, иргэдийн санаа бодлыг сонсдог шийдвэрлэдэг болгох, 8.7% нь орон нутагт хүмүүсийн намын харьяалал, үзэл бодлоор нь ялгаварладаггүй болгох нь хамгийн тулгамдсан асуудал болсон гэж үзжээ.

Хөдөө орон нутагт хүний эрхийг зөрчихөд дараах хүчин зүйлс нийтлэг үндэслэл болж байна.

- Ажлын байр байхгүйн улмаас ядуурал, архидалт, гэмт хэрэг өсч байгаа
- Сумдад ажиллаж байгаа төрийн албан хаагчдын болон иргэд олон нийтийн хүний эрхийн мэдлэг дорой байгаа учраас хүний эрх зөрчихөд үл тоомсорлох
- Орон нутагт хүмүүсийг намын харьяалал, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж аливаа хөнгөлөлт, зээл тусламжыг танил тал, ах дүү хамаатан садандаа найр тавин өгдөг
- Төрийн албан тушаалтнуудын иргэдийн санал хүсэлтийг сосдоггүй, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэхийн оронд хэдхэн хүмүүс хоорондоо хуйвалдах, хүнд суртал гаргах, хүнийг олон өдрөөр чирэгдүүлэх зэргээр хүмүүсийг хохироодог
- Сумын иргэдийн боловсрол, эрүүл мэнд, ахуй ба бүх төрлийн худалдаа үйлчилгээ хангалтгүй учраас иргэд хот суурин газарруу нүүх асуудал багасахгүй байгаа. Ийм учраас эдгээр асуудлуудыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.

АРХАНГАЙ АЙМГИЙН ИТХ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧИГ ИЙН ДАРГА О.ЦЭВЭГЖАВ

Архангай аймгийн хүний эрхийг хангах арга хэмжээний төлөвлөгөөг /2001-2006 он/ боловсруулан аймгийн ИТХ-аар 2001 оны 12-р сард батлуулсан. Үг төлөвлөгөө нь хүний эрхийг хангах орчинг бүрдүүлэх, орон нутгийн чадавхийг дээшлүүлэх, эмзэг бүлгийн эрхийг хангах, баталгаа, хяналт шинжилгээ гэсэн 8 бүлэг 160 гаруй асуудал бүхий томоохон баримт бичиг болсон.

Аймаг, сумдын ИТХ-ын дэргэд хүний эрхийн зөвлөл байгуулан, аймгийн төлөвлөгөөг үндэслэн сумдын хүний эрхийг хангах арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хүний эрхийг хангах аймгийн төлөвлөгөөний биелэлтийн талаар аймгийн Засаг даргын мэдээллийг аймгийн ИТХ-аар 2003 онд хэлэлцүүлж, энэ онд бүх сум байгууллагаас төлөвлөгөө хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын тайланг гаргуулан дүгнэлт хийж цаашид эрчимжүүлэх ажил зохиолоо.

- Аймгийн ИТХ-ын Хүний эрхийн зөвлөлөөс сумдын ИТХ-ын хүний эрхийн зөвлөлийн ажлыг шалган туслах, хурлын дарга, ажилтан, хүний эрхийн зөвлөлийн гишүүдийн хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хэд хэдэн удаагийн сургалт явуулж, сумдад очиж ажиллан заавар зөвлөгөө өгөх, гарын авлага, арга зүйн материалаар хангах, сумын зөвлөлтэй хамтран тухайн сумын иргэдтэй уулзалт ярилцлага хийж, санал хүсэлтийг сонсох, аймгаас хурал, захиргаа, хууль хяналтын байгууллагын ажилтнуудыг уулзуулж, иргэдийн санал, гомдолд хариу өгүүлэх, ТББ-ын сонгуультнуудын бүсчилсэн сургалт, семинарт хамтарч оролцох зэрэг олон хэлбэрийн ажил зохиож байна.
- Аймгийн ИТХ-ын Хүний эрхийн зөвлөлөөс суманд Хүний эрхийн нээлттэй өдөр зохиох, иргэдэд хуулийн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх ажил зохиож байна. Ихтамир суманд хүний эрхийн нээлттэй өдөрт аймгийн шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх алба, Өмгөөлөх байгууллагын ажилтнууд оролцож лекц ярилцлага хийсний дээр тодорхой асуудлаар иргэдийн санал гомдлыг сонсож, тэдэнд зөвлөгөө өгч, зарим асуудлаар нь биечлэн туслах ажил зохиож, суманд анхан шатны нэгж нь байдаггүй, хүний эрхийн зөрчлийн асуудлыг шийддэг гол байгууллагын эрх мэдэл бүхий хүмүүс газар дээр нь уулзаж зөвлөсөн нь чухал ач холбогдолтой иргэдийн эрэл хүсэлтэд нийцсэн ажил болсон юм. Энэ онд сумдын судалгаа саналын үндсэн дээр захиалгын дагуу аймгаас тодорхой байгууллагын төлөөллийг оролцуулан нээлттэй өдөр зохиохоор бэлтгэж байна.
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, аймаг сумдын ЗДТГ-ын ажилтнууд, Засаг даргын харьяа хэлтэс, агентлаг, газар, албан байгууллагын дарга эрхлэгчид, хувийн хэвшлийн байгууллагын эзэд, ТББ-ын сонгуультнууд, Хууль хяналтын байгууллагынхан, төрийн үйлчилгээний албан хаагчид багш, эмч нар, дээд сургуулийн оюутнууд, зарим сум, багийн иргэд зэрэг нийгмийн янз бүрийн давхаргынхныг хамруулан хүний эрхийн сургалт сурталчилгааны ажлыг жил бүр зохиож байна.
- Энэ онд “Хүний эрх хөгжил” сонин 4 дугаар гарган иргэний эрүүл мэндийн даатгал, хүний эрхийг хангах үүрэг зорилготой олон улсын болон үндэсний байгууллагуудтай холбогдсон асуултын хариулт, сүрч боловсрох, нийгмийн хангамжийн эрхийн тухай нийтэллээ. ЕБС-ийн төгсөгчид, эцэг эхчүүдэд зориулан гаргасан сүрч боловсрох эрхийн тухай дугаарт их, дээд сургууль, коллежийн зарим суралцагчийн болон төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх, их, дээд сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, боловсролын багц хуультай холбоотой иргэдийн сонирхож байдаг асуултуудын хариултуудыг нийтэллээ. Энэ дугаарыг аймгийн нийт хот, айлын тоогоор буюу 4000 хувь хэвлүүлж үнийг аймгийн ИТХ-ын зардлаас гаргалаа.

- Жил бүр Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан сургалт сурталчилгааны ажлын тусгай төлөвлөгөөний дагуу явуулж зохион бичлэг, гар зургийн уралдаан, хошин шогийн тэмцээн, урлагийн тоглолт уралдаан тэмцээн зохион түүнд төр захиргаа, хууль хяналт, соёл боловсролын байгууллагынхан өргөн хүрээтэй хамрагдаж байна. Тухайлбал, “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр-бидний оролцоо” сэдэвт тэмцээнийг аймгийн ЗДТГ, цагдаа шүүх, прокурорын байгууллагынханыг оролцуулан, мөн арван жил, коллеж, дээд сургуулийн багш нарын дунд зохион байгуулав.

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ИЛТГЭЛ - 2005

НЭГ. СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

2004 онд явагдсан УИХ-ыг сонгох болон орон нутгийн сонгууль нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг амьдрал дээр харж судлах боломжийг олгосон, хүний эрхийн байгууллага, мэргэжилтнүүдийн анхаарлыг татсан онцлог үйл явдал байв.

ХЭҮК-оос хүний улс төрийн эрхийн хамгийн сонгодог илэрхийлэл болсон сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг эдгээр сонгуулийн үеэр судалж, дүн шинжилгээ хийсэн юм.

Өнөөдрийн байдлаар Монгол улсад УИХ-ын сонгуулийн тухай хууль /1992 он/, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль /1992 он/, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль /1996 он/-иар тус тус сонгуулийн харилцааг зохицуулж байна. 1992 оноос хойшхи хугацаанд УИХ-ын сонгуулийг 4 удаа, Ерөнхийлөгчийн сонгуулийг 3 удаа, орон нутгийн сонгуулийг 3 удаа тус тус зохион байгуулаад байна. Сонгуулийг зохион байгуулах явцад иргэдийн сонгох, сонгогдох эрхийг бодитой эдлүүлэхэд тус харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох явдал зайлшгүй чухал билээ. Ардчилсан сонгуулийн талаарх олон улсын баримт бичгийг судалж үзэхэд сонгох, сонгогдох эрхтэй /сонгууль/ холбоотой дараах үндсэн зарчмуудыг онцлон анхаардаг. Үүнд:

- Бүх нийтийн байх зарчим
- Тэгш эрхийн зарчим
- Чөлөөтэй байх зарчим
- Саналаа нууцаар гаргах зарчим
- Сонгууль тогтмол хугацаанд явагдах

Эдгээр үндсэн зарчмууд үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдал, сонгуулийн зохион байгуулах үе шатуудад эдгээр зарчмыг мөрдлөг болгодог эсэх талаар энэхүү илтгэлд авч үзэв.

Монгол улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжуудад сонгууль 4 жил тутам явагдана хэмээн заасан нь сонгууль тогтмол хугацаанд явагдах зарчмыг хэрэгжүүлж байна.

Нэг. БҮХ НИЙТИЙН БАЙХ ЗАРЧИМ

Сонгууль бүх нийтийн байх зарчим бол иргэдийн сонгох, сонгогдох эрхийн нэг гол баталгаа юм. Бүх нийтийн байх зарчим нь иргэд сонгуульд оролцоход ямар нэгэн төрлийн ялгаваргүйгээр бүгд тэгш эрхтэйгээр оролцох боломжтой байхыг хэлнэ.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 1-р зүйлийн 1-д "... Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ... сонгоно.", Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2-д: "...сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ...", Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 3-р зүйлийн 1-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Монгол улсын иргэд нийтээрээ...сонгох эрхтэй оролцож..." хэмээн заасан.

Бүх нийтийн байх зарчмыг хууль тогтоомжид тусгаж өгсөн хэдий ч энэхүү зарчмыг сонгуулийн бүх үе шатуудад мөрдлөг болгож чадаж буй эсэх нь сонгуулийн өдрийг товлох, сонгуулийн тойрог хэсгийн хороодыг байгуулах, санал хураах цаг, хугацаа, байрыг мэдээлэх, сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах, саналыг урьдчилж авах, зөөврийн хайрцгаар санал авах гэх мэтийн олон төрлийн үйл ажиллагаануудыг хэрхэн яаж зохион байгуулахаас шууд хамааралтай юм.

1.1. Сонгуулийг шударгаар зохион байгуулах, сонгууль бүх нийтийн байх, иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн үндсэн суурь нөхцлийн нэг бол сонгуулийн тойрог, хэсгийн хороодыг хуулийн дагуу байгуулах явдал юм.

Сонгуулийн хэсэг, тойргийн хороодод нам, эвсэл нам бусчуудын төлөөллийн тэнцвэртэй байдал алдагдах, нам, эвслүүд, нам бусчуудын төлөөллийг оруулахад саад тогтгор учруулах, тойрог, хэсгийн хороодыг хуульд заасан хугацаанаас хоцроож байгуулах зөрчил нь иргэдийн сонгох, сонгогдох эрхэд сөргөөр нөлөөлж байна.

Түүнчлэн "нам бус" гэдэг нэрийн дор аль нэгэн намд гишүүнчлэлтэй хүн тойрог, хэсгийн хороонд ажиллаж буйг сонгогчид шүүмжилдэг.

Энэ тухай нам эвсэл, нэр дэвшигчдээс цөөнгүй санал, гомдол гардаг ч холбогдох хуульд "...тойрог хэсгийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд ...нэр дэвшигч байж болохгүй" гэснээс өөр хязгаарлалтыг, тухайлбал, сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд аль нэг нам эвслийн төлөөлөл давамгайлахыг хориглосон зүйл байхгүй нь тойрог, хэсгийн хороодын бүрэлдэхүүний төлөөллийг тэнцвэртэй бус болгоход нөлөөлж байна.

Хуульд зааснаар сонгуулийн бүх шатны хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа хийхийг хориглодог боловч, нэг гэр бүлийн хүмүүсийн нэг нь нэр дэвшиж, нөгөө нь сонгуулийн хороонд ажиллах тохиолдол хөдөө, орон нутагт цөөнгүй байв. Хуульд тодорхой заалтгүйн улмаас сонгуулийн хороод аль нэгэн улс төрийн хүчин, нэр дэвшигчийг талархан дэмжигчдээс дагнан бүрдэхгүй гэсэн баталгаа үгүйн зэрэгцээ, нөлөө бүхий нам, эвслүүд хороодын бүрэлдэхүүнийг хоорондоо хуваах, нам бусчуудыг хороодын бүрэлдэхүүнд аль болох оруулахгүй байх нь 2004 оны орон нутгийн сонгуулиар ажиглагдаж байлаа.

Хэдийгээр нам эвслийн тохиролцож байгаа нь хууль зөрчөөгүй мэт боловч намын харьяалалгүй иргэд болоод өөр бусад жижиг намын гишүүдийг ялгаварлан гадуурхаж буй нэгэн хэлбэр гэж хэлж болно.

УИХ-ын сонгуулийн үеэр манай аймагт сонгуулийн хороонд ажиллаж байсан МАХН-ын төлөөлөгч болон, Эвслийн гишүүн хоёр тохиролцоод зөөврийн хайрцгаар санал авах хуудсаа тэнцүү тоогоор хувааж өөрийн намаас нэр дэвшигчдийн нэрийг дугуйлчихсан явдал гарсан /Увс, ХЭҮК-ийн төлөөлөгийн ярилцлагаас/.

УИХ хийгээд орон нутгийн сонгууль бол зөвхөн нам, эвслийн гишүүдийн сонгууль бус сонгуульд оролцох эрх бүхий бүх иргэдийн хүсэл зоригийн илэрхийлэл тул түүнийг эрхлэн явуулах сонгуулийн хороодыг байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, иргэдийн эрхийг тэгш, шударгаар хангах асуудал тулгамдсан шинжтэй болж байна.

1.2. Сонгуулийн хороодыг хуульд заасан хугацаанаас олон, цөөн хоногоор хоцроож байгуулах нь түгээмэл байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаанаас харахад сонгуулийн хэсгийн хороод хуульд заасан хугацаанаас даруй 9-13 хоног хоцорч байгуулагдсан /Дундговь аймагт хийсэн судалгаанаас/.

Тойрог, хэсгийн хороодыг хугацаа хоцроон байгуулж буй нь хороодын гишүүдийн дунд сургалт явуулах, ажил үүрэгтэйгээ танилцах зэрэгт муугаар нөлөөлж улмаар зөрчил гаргах нөхцөлийг бүрдүүлж байна.

1.3. Сонгуулийн хороодыг байгуулах явцад гардаг өөр нэгэн хүндрэлтэй зүйл бол боловсон хүчний хомсдол, тэнд ажиллах хүмүүсийн сонгуулийн талаарх мэдлэг боловсрол, эдийн засгийн болоод эрх зүйн баталгааны тухай асуудал юм.

Жирийн иргэдийг сонгуулийн хороодын үйл ажиллагаанд татан оролцуулах арга хөшүүрэг хангалтгүй, ажиллах хүнийг зөвхөн нам эвслийн гишүүд, эсхүл төр, төсвийн байгууллагад ажилладаг цөөн бүлэг хүмүүсээс эрж хайдгаас улбаалан эл хүндрэл зонхилон гардаг нь судалгааны явцад ажиглагдаж байлаа.

Ялангуяа орон нутгийн сонгуулийн үед хороод байгуулахад хамгийн бэрхшээлтэй асуудал нь чадварлаг, боловсролтой хүмүүс дутагддаг явдал аж.

Орон нутгийн сонгуулийн тойрог хэсгийн хороонд яг газар дээр нь ажиллаж байгаа хүмүүс асуудал шийдэх чадваргүй бүх юмаа дээд шатны хороо руу явуулахаас ажил алдагдаж, хүмүүс чирэгддэг. Мөн хийх ажлаа сайн мэддэггүй учраас алдаа гаргаж хүний эрх зөрчих тохиолдол их гардаг гэж судалгаанд оролцогчид тайлбарлаж байв

Хэдийгээр хуульд сонгуулийн хорооны гишүүдэд сарын дундаж цалинтай нь тэнцэх хөлс, тэтгэвэрт байгаа хүнд, төсвөөс зохих хөлс олгохоор заасан байдаг боловч энэ нь хангалттай урамшуулал болж чаддаггүй гэж тойрог, хэсгийн хороонд ажилласан хүмүүс үзэж байна.

Сонгуулийн хороодын гишүүдийн ажлын ачаалал их, өдөр бүр шөнө дөл хүртэл сууж ажилладаг төдийгүй амралтын өдрүүдээр ч ажиллахад хүрдэг. Гэтэл илүү цагийн хөлс нэмэгдэл урамшуулал байдаггүй бөгөөд тодорхой ажил эрхэлдэггүй бол ямар нэг цалин хөлс олгогдоггүй.

Сонгуулийн хороонд /ялангуяа орон нутагт/ ажиллахад ямар нэг нэмэгдэл урамшуулал, хөнгөлөлт байхгүй учраас нэр дэвшигч, нам эвслийн нөлөө, бэлэг сэлтэд автагдахгүй гэх баталгаа байдаггүй.

1.4. Санал авах байрыг товлох, нийтэд мэдээлэх асуудал нь сонгууль бүх нийтийн байх зарчмыг хангах чухал үйл ажиллагаа юм. Санал авах байрыг аль болох иргэдэд хамгийн ойр, хүндрэлгүй, багтаамжтай байх талаас нь товлох шаардлагатай. Түүнчлэн санал авах байрны талаар иргэдэд мэдээлэл хүргэх асуудал дээр анхаарах шаардлагатай байна. Хуульд 14 хоногийн өмнөөс нийтэд зарлана

гэсэн хэдий ч энэ нь тэр бүр хэрэгжихгүй байна. Сонгуулийн санал авах байрны багтаамжийн асуудал хүн ам олноор төвлөрсөн суурин газарт илүүтэй ажиглагддаг. Тиймээс санал авах байрыг товлохдоо сонгогчдын тоог харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай. Учир нь хүн ам ихтэй газрын санал авах байрт урт урт дараалал үүсэх, үүнээс болж зарим иргэд сонгуульд оролцохоос татгалзаж, түвэгшээх байдал сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. Санал авах байрны стандартыг тогтоож өгөх шаардлагатай юм. Энэхүү стандартад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай кабин байх гэх мэт. Кабин хоорондын зай ямар байх, ажиглагч, хэсгийн хорооны ажилтнуудын байршил ямар байх зэргийг тодорхой нарийн заасан стандартыг ч бий болгох шаардлагатай юм.

Сонгуулийн аливаа хэсгийн хорооны тэргүүн ээлжинд гүйцэтгэх үүрэг бол иргэдэд сонгуулийн санал хураалт явагдах байр, цаг хугацаа, журмыг бүгдэд нь хүртээмжтэй зарлан мэдээлэх явдал юм.

Сонгуулийн тойрог, хэсгийн хорооны зүгээс санал хураалтын цаг хугацаа, байр зэргийг хэрхэн мэдээлж ирсэн талаарх иргэдийн үнэлгээний судалгааг гаргасан болно.

Санал хураах цаг хугацаа, байр, журмыг мэдээлэх үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ

	УИХ-ын сонгууль		Орон нутгийн сонгууль	
Хангалттай	654	65,4	510	51,0
Дунд зэрэг	164	16,4	183	18,3
Хангалтгүй	69	6,9	83	8,3
Мэдэхгүй	113	11,9	224	2,4
Нийт	1000	100,0	1000	100,0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

Сонгуулийн санал хураалт хаана, хэзээ явагдах талаар судалгаанд хамрагдсан иргэдийн 50-60 гаруйхан хувь нь хангалттай, эргэлзээгүй мэдээлэлтэй байсан нь анхаарал татах асуудлын нэг мөн.

Ажиглалт явагдсан орон нутгуудад дээрх үзүүлэлт харилцан адилгүй авч иргэдийн дунд санал өгөх байр, журмын талаар төдийлөн сайн мэдэхгүй байх нь нийтлэг тааралдаж байсан болно.

Саналаа хаана өгөх, хэрхэн өгөх талаарх сонгогчдын мэдлэг хангалтгүй байна. Тэд санал өгөх байрыг мэдэхгүй бодвол хуучин өгдөгтөө л өгөх байхдаа гэгцгээж байсан. Энэ нь тус аймагт цахилгаангүй харанхуй, олныг хамарсан сурталчилгаа явагдахгүй байгаатай холбоотой болов уу/Завхан аймаг, судлаачийн ажиглалтаас/

Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарах нийтлэлүүдэд нэр дэвшигчдийн сурталчилгаа зонхилж байсан боловч, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг нь тайлбарлан таниулах, сонгуулийн хуулийн иргэдтэй холбоотой, тэдний зайлшгүй мэдэх ёстой зүйл заалтуудыг сурталчлах талаар ямар ч зүйл яригдахгүй байлаа /Хөвсгөл аймаг, судлаачийн ажиглалтаас/.

Нийслэл хотын захын дүүргүүдэд УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн хэсгийн хороо санал хураалтын талаар сонгогчдод хангалттай мэдээлэл хүргэж чадаагүй байв. Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн судалгаанд оролцсон

10 сонгогч дутмын нэг нь санал хураах цаг хугацаа, байр, журмын талаар тодорхой ойлголтууд байв.

1.5. Нэрийн жагсаалт гаргах үйл явц бол сонгууль бүх нийтийн байх эсэхэд нөлөөлөх томоохон хүчин зүйл. Нэрийн жагсаалтыг хэн гаргах, хэн, хэрхэн хяналт тавих, хэзээ нийтэд дэлгэн үзүүлэх зэргийг хуульд заасан. Хууль тогтоомжид тусгагдсанаар нэрийн жагсаалтыг багийн засаг дарга гаргаж, сонгуулийн хороодод хүргүүлэх үүрэгтэй. Багийн засаг дарга нь улс төрийн албан тушаалтан учраас нэрийн жагсаалтыг гаргахад улс төрийн сонирхолын үүднээс хандаж болохыг үгүйсгэдэггүй. Тийм учраас хууль тогтоомжид нэрийн жагсаалтыг гаргахад хөндлөнгийн хяналт оролцуулах асуудлыг тусгах нь зүйтэй. Нэрийн жагсаалтыг хуульд заасан хугацааны дотор гаргахгүй байгаа тохиолдол цөөнгүй байдаг. Энэ нь иргэдийн нэрийн жагсаалттай танилцах, тулгалт хийх зэрэг эрхээ эдлэхэд нь саад бэрхшээл учруулдаг. Хууль тогтоомжид нэрийн жагсаалтыг хэзээ гаргаж, хэзээ нийтэд ил тод болгох талаар дараах байдлаар зохицуулжээ.

• **УИХ-ын сонгууль:** Сонгуулийн хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хорооны баталсан маягтын дагуу хоёр хувь нэгтгэж, хэсгийн хорооны дарга гарын үсгээ зурж санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө, харин эмнэлэг, амралт, сувиллын газарт 7 хоногийн өмнө ил тавьж сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

• **Ерөнхийлөгчийн сонгууль:** Сонгуулийн хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг санал хураах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу хоёр хувь үйлдэж сонгуулийн хэсгийн хорооны дарга гарын үсгээ зурж, санал хураах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө, харин эмнэлэг, амралт, сувиллын газарт 7 хоногийн өмнө ил тавьж сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

• **Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль:** Сонгуулийн хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 8-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу хоёр хувь үйлдэж, хэсгийн хорооны дарга гарын үсгээ зурж, ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

Үүнээс үзэхэд УИХ-ын болоод, Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр сонгууль болохоос 45, 30 хоногийн өмнө гарсан нэрийн жагсаалтыг ямар үндэслэлээр 15-30 хоногийн дараа нийтэд ил тод болгож байгаа нь ойлгомжгүй юм. Мөн сонгуулийн үеэр ажиглагдаж буй зөрчил бол нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд нь гаргахгүй байгаа явдал.

2004 онд явагдсан хоёр сонгуулийн үед хамгийн их маргаан дэгдээж, нэр дэвшигчдийн нэг нэгнээ буруутган зэмлэх үндэс болсон асуудлын нэг бол сонгогчдын нэрийн жагсаалт гаргах үйл явц байсан.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргахад олон талын хүндрэл, бэрхшээл үүсч иргэдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчиж, хууль ёсыг гажуудуулах явдал байгаа нь судалгаагаар харагдаж байна.

Эдгээр зөрчил нь сум дүүрэг, хороо, багийн засаг дарга нарын, сонгуулийн хэсгийн хороодын, нэр дэвшигчид болон сонгогчдын үйл ажиллагаанаас болж гардаг.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд заасан журмын дагуу үйлдэх үүргийг хүлээсэн холбогдох шатны засаг дарга нар өөрсдийн албан үүрэгтээ хайхрамжгүй ханддагаас нэрийн жагсаалтыг үнэн зөв гаргаж, сонгуулийн хэсгийн хороонд хүргэх хуулийн хугацааг хэтрүүлэх, сонгогчдын нэр овог, хаяг, иргэний үнэмлэх, регистрын дугаарыг буруу бичих, шилжилт хөдөлгөөнийг цаг тухайд нь бүртгэж байгаагүйн улмаас байхгүй хүнийг жагсаалтанд оруулах, орох ёстой хүнийг орхигдуулах зэрэг хууль бус үйлдэл их хэмжээгээр гарч, нэрийн жагсаалтыг тавьж танилцуулах журам, хугацааг зөрчих нь аль ч шатны сонгуулийн үед нийтлэг зөрчил байв.

Багийн засаг дарга нар сонгогчдын нэрийн жагсаалтыг хуулийн дагуу гаргаж өгөөгүй, тойргуудын нэрсийн жагсаалт сонгууль болохоос хоёрхон хоногийн өмнө л хагас дутуу бэлэн болж байв /Төв аймаг, судлаачийн ажиглалтаас/.

Ийм байдал бүх аймаг, Улаанбаатар хотод орон нутгийн сонгуулийн тойрог хэсэг дээр ямар нэг хэлбэрээр давтагдаж байсан.

Түүнчлэн судалгаанаас үзэхэд, бэлэн болсон гэх нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хүмүүсийн 30 хүртэлх хувьд ямар нэг зөрчил илэрч байсан бөгөөд нэр овог, иргэний үнэмлэх, регистрын дугаар буруу бүртгэгдэх, орхигдуулах зэрэг нь тун түгээмэл төдийгүй зориудын шинжтэй байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Нэрийн жагсаалтад байсан 24 оюутны нэгнийх нь нэр буруу, бүгдийнх нь регистр, үнэмлэхний дугаар зөрж байсан /Ховд аймагт хийсэн бичиг баримтын судалгаанаас/.

Сонгуулийн Ерөнхий Хороонд ирсэн УИХ-ын сонгуультай холбоотой өргөдөл гомдлын 7 хувь, орон нутгийн сонгуультай холбоотой өргөдөл гомдлын 25,4 нь сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой байв /СЕХороонд ирсэн өргөдөл гомдолд хийсэн судалгаанаас/.

Судалгааны явцад аймгуудад сонгогчдын нэрийн жагсаалтыг хаягаар тулган шалгаж үзсэн болно. Бараг бүх аймагт сонгогчийн нэрийн жагсаалтыг үнэн зөв гаргахтай холбоотой зөрчлүүд гарсан.

Эдгээрийг нийтэд нь авч үзвэл: нэрийн жагсаалтаас нас барсан, шилжин явагчдыг хасаагүй, байнгын оршин суугчдыг бүртгээгүй байх, нэрийн жагсаалтанд бичигдсэн хаяг оршин суугаа газрын хаяг хоёр зөрөх, нэг гэр бүлийн хүмүүсийг өөр өөр хаягаар бүртгэх нь элбэг тохиолдол байв.

...Бэлэн болгосон нэрийн жагсаалтаас 38 хүнийг сонгож уулзахад 3 нь иргэний үнэмлэхгүй, огт байхгүй 5 хүний нэрийг/ нас барсан болон шилжсэн /сонгогчийн нэрийн жагсаалтанд оруулсан байлаа /Говь-Алтай аймагт хийгдсэн судалгаанаас/.

...Нэрийн жагсаалтаас 100 иргэнийг сонгон авч нэрийн жагсаалттай тулган үзэхэд өөр газар шилжсэн 8, хаяг буруу буюу хаа байгаа нь мэдэгдэхгүй 16, хөдөө байгаа 3, үнэмлэхээ үрэгдүүлсэн 1, нийт 34 хүн зөрчилтэй байв /Говьсүмбэр аймагт хийгдсэн судалгаанаас/.

... 7-р тойргийн 178-р хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтнаас 100 гаруй хүнийг түвэрлэн шалгахад 22 иргэн зөрчилтэйбайв /Баянхонгор аймагт хийгдсэн судалгаанаас/

...Сонгуулийн 48-р хэсгийн нэрийн жагсаалтыг шалгахад байнгын оршин суугч 22 хүн нэрийн жагсаалтанд байхгүй, нас бараад 1 жил болсон хүн нэрийн жагсаалтанд бүртгэгдсэн зэрэг зөрчлүүд илэрсэн /Дундговь аймагт хийгдсэн судалгаанаас/.

Мөн түүнчлэн сонгогчдын нэрийн жагсаалтыг үнэн зөв гаргахад оршин суугчдын зүгээс хаягийн бүртгэлээ цаг хугацаанд хийлгээгүй, засаг захиргаа завсардан амьдрах нь их байгаа нь сөргөөр нөлөөлж буйг тэмдэглэж байна.

1.6. Аль ч сонгуулийн санал авах өдрийг УИХ-аас товлон зарладаг. Санал авах өдрийг зөв сонгож товлон нь сонгогчид сонгуульд нийтээрээ оролцоход чухал ач холбогдолтой. 1992 оноос хойших УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгууль иргэдийн үлэмж хөдөлгөөнтэй үед болж ирсэн. Сонгуулийг 1959-1990-ээд он хүртэл 6-р сарын эхний 10 хоногт багтаан зохион байгуулж байсан. Энэ үед цэрэг халагдаагүй, татагдаагүй, оюутнууд шалгалтаа өгч дуусаагүй хүн ам нэлээд суурьшмал байдаг. Гэтэл сонгуулийг 6-р сарын сүүлээр явуулахад 20-30 мянган хүн сонгуулиас завсардах нөхцөл бий болдог байна. Орон нутгийн сонгууль ихэвчлэн хадлан, тариалан, өвлийн бэлтгэл хийх, отор нүүдэл гэх мэтчилэн манай орны амьдралын онцлог үетэй давхцан зохион байгуулагдаж буй нь төдийлөн тохиромжтой бус юм.

1.7. Санал хураах байранд биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хүрэлцэн ирж чадахгүй, саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй сонгогчдын саналыг авах ажлыг зохион байгуулах нь сонгууль бүх нийтийн байх зарчмын нэг чухал хэсэг юм. Практикт хэвтрийн өвчтэй хүмүүс, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээж баривчлах ял, шийтгэл эдэлж буй хүмүүс, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүмүүсийг санал хураах байранд хүрэлцэн ирж чадахгүй хүмүүс гэсэн ойлголтонд хамаардаг. Сонгуулийн хууль тогтоомжоор эдгээрийн заримынх нь саналыг зөврийн битүүмжилсэн хайрцгаар авах тухай зохицуулалт хийсэн. Зөврийн хайрцгаар санал авах иргэнийг тогтоох, тэдгээр иргэдийн нэрийн жагсаалт гаргах, бүртгэх хугацаа, ийнхүү саналаа өгч байгаа тохиолдолд саналын нууцлалыг хэрхэн хангах, зөврийн хайрцгаар санал авч буй сонгуулийн хорооны ажилтан хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх гэх мэт асуудлуудыг тусгасан зохицуулалт шаардлагатай байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос “Зөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах тухай журам”-ыг тухай бүрд нь баталдаг хэдий ч хэн зөврийн хайрцгаар санал өгөх вэ гэдэг зохицуулалт байхгүй байна. Тус журмаар биеийн эрүүл мэндийн байдлаас болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас санал авах байрт ирж саналаа өгч чадахгүй тухай хүсэлтээ сонгогч санал авах өдрөөс өмнө бичгээр болон амаар сонгуулийн хэсгийн хороонд илэрхийлж бүртгүүлэн хэмээн зохицуулсан. Гэвч зөврийн хайрцгаар санал авах сонгогчидын нэрийн тусгай жагсаалт хэдийд гарсан байх ёстой болох нь тодорхойгүй байгаагаас үүдэж сонгуульд будлиан гарах, улмаар сонгогчид эрхээ эдэлж чадахгүйд хүрдэг. Мөн түүнчлэн хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт юуг хамааруулан үзэх талаар ч тодорхой тайлбар байхгүй байна.

Монгол орны онцлог, монголчуудын амьдралын хэв маягаас шалтгаалан төвлөрсөн суурин газраас алс хол оршин суудаг болон өөр аймаг сумын нутагт отор нүүдэл хийн амьдарч байгаа хөдөө, орон нутгийн иргэдийн сонгуульд оролцох боломжийг хангах талаар эрх зүйн тодорхой зохицуулалтыг шаардаж байна.

Зөврийн битүүмжилсэн хайрцгаар саналыг нь авч байгаа тохиолдолд нэрийн жагсаалтын дагуу бүрэн авах тухай тодорхой зохицуулалт хуульд оруулах шаардлагатай байна. СЕХ-ноос гаргасан журамд зөврийн битүүмжилсэн

хайрцагар санал авах нэрийн жагсаалтад орсон хүмүүсээс саналыг заавал авсан байх, аваагүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх гэсэн зохицуулалт байхгүйгээс шалтгаалж хэсгийн хорооны ажилтнууд хайнга хандах явдал гарсаар байна.

Сонгуулийн хууль тогтоомжид саналын хуудсанд саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй сонгогч өөрийн итгэмжилсэн хүний туслалцаа авч болно хэмээн зохицуулсан. УДШ-ийн 1992 оны 30-р тогтоолд "...саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй сонгогч гэдэг нь бие эрхтэний гажиг, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээсээ шалтгаалан ... сонгуулийн эрх бүхий иргэнийг хамааруулан ойлгоно...", итгэмжлэгдсэн төлөөлөгч нь сонгуулийн эрх бүхий иргэн байна гэж тайлбарласан хэдий ч итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан саналаа өгөх хүмүүс хэзээ бүртгүүлсэн байх, итгэмжлэгдсэн төлөөлөгчтэйгээ ирээгүй тохиолдолд яах ёстой зэрэг асуудлыг хуулиар зохицуулаагүй орхисноос зарим зөрчил гарч байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан санал өгөх нь сонгуулийн саналаа нууцаар өгөх зарчимтай мөн холбоотой.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Тонгорог хэмээх газар мал оторлож буй 28 иргэн зөвөрийн битүүмжилсэн хайрцагар санал өгөхийг хүссэн хэдий ч харьяалах сонгуулийн хэсгийн хороо хүлээн аваагүй байна /Баянхонгор аймагт хийсэн судалгаанаас/.

Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн эмнэлэгт 102 хүн хэвтэж эмчилгээ хийлгэж байснаас 5 хүн нь өөр аймаг, орон нутгаас ирсэн, үлдсэн 97 хүний 23 нь чөлөөгөөр гарч, үлдсэн 74 өвчтөн байсны 42 буюу 56,7 %-иас санал авч, үлдсэн 32 хүний санал аваагүй /Ажиглалтаас/.

Нийслэлийн хавдар судлалын эмнэлэгт 170 орчим хүн хэвтэж эмчлүүлж байснаас 10 орчим хүнээс л зөвөрийн битүүмжилсэн хайрцагар саналыг нь авчээ /Ажиглалтаас/.

Комиссын гишүүд, ажилтнууд нийслэлийн сонгуулийн зарим хэсгүүдэд хийсэн ажиглалтаас харахад саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй сонгогч итгэмжлэгдсэн төлөөлөгчгүйгээр санал өгөхөөр ирэх, энэ тохиолдолд хэсгийн хорооныхон хүмүүсээс туслалцаа хүсэх замаар итгэмжлэгдсэн төлөөлөгчийг зааж өгөх, эсвэл ажиглагч нарын хяналт доор зарим нэг ажилтан нь саналыг нь өгөхөд туслалцаа үзүүлэх зэрэг зөрчил гарч байсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд оролцох эрхийг хангах талаар төрөөс эрх зүй, бодлогын шинж чанартай өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байна. Хараагүй иргэдэд зориулан баррел үсэг бүхий саналын хуудас гаргах боломжийг судлах, санал өгөх тусгай кабин зэргийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шаардлага, хэрэгцээг бодолцон тохирсон стандарттай байлгах асуудал дээр арга хэмжээ авч эхлэх нь бүх нийтийн байх зарчмыг хангаж байгаа зүйтэй алхам болох юм.

1.8. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд санал хураах өдөр эх орондоо байгаа, Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд санал хураах өдөр аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн сонгох эрхтэй гэж холбогдох хуулиудад заасан.

Харин гагцхүү эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой /ухаан солиотой учраас эрх олох, үүрэг бий болгох чадваргүй болох нь ИХШХШ тухай

хуулийн 144-146 дугаар зүйлд заасан журмын дагуу нотлогдсон иргэнийг ойлгоно. УДШ-ийн Бүгд хурлын 1992 оны 30-р тогтоол/, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн /шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолоор хорих газарт ял эдэлж буй хүмүүсийг ойлгох бөгөөд үүнд хорих ял эдлэхээс зайлсхийж яваа, хорих газраас түр чөлөөгөөр гарсан, хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг нь биелүүдэхийг хойшдуулсан хүмүүсийг нэгэн адил хамруулна. УДШ-ийн Бүгд хурлын 1992 оны 30-р тогтоол/ сонгуульд оролцохгүй гэж хуульд заасан.

Гэтэл сонгуулийн практикаас үзэхэд зөвхөн дээрх хоёр хэсэг хүмүүсээс гадна нийгмийн олон, цөөн тооны социаль бүлгүүдийн сонгох эрх хэрэгждэггүй нь тодорхой харагдана.

1.8.1. Гадаад улсад ажиллаж, амьдарч, сурч буй иргэд сонгуульд огт оролцдоггүй.

1.8.2. Хэдийгээр хуулиудад зөвхөн “хорих газар ял эдэлж байгаа хүмүүс” сонгуульд оролцохгүй гэж заасан байгаа боловч гэм буруу нь тогтоогдоогүй, гэмт хэрэгт сэжиглэгдэн гэм буруу нь тогтоогдоогүй, гэмт хэрэгт сэжиглэгдэн урьдчилан хорих, албадан саатуулах байранд хоригдож буй хүмүүсийн сонгох эрхийг эдлүүлэх талаар сонгуулийн хэсэг, тойргийн хороод анхаарч үздэггүй.

2004 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн үеэр нийслэлийн Цагдан хорих төвд хоригдож байсан 800 шахам хүн сонгуульд саналаа өгч чадаагүй /ХЭҮК-ын ажиглалт судалгаанаас/.

1.8.3. Шилжин суурьшигчид болон оюутнуудын хувьд сонгуульд оролцож, саналаа өгөх боломжгүй байгаа нь нэгэнт хэвшсэн зүйл болжээ.

Шилжин суурьшигсад, оюутнуудтай холбоотой асуудал ихэнх тойрог, хэсгийн хороод дээр байсан бөгөөд Дорнод, Баян-Өлгий, Эрдэнэт, Дорноговь, Төв аймагт харьцангуй олон гомдол гарч байлаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд тухайн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа Монгол улсын иргэн сонгох эрхтэй хэмээн заасан. Монгол Улсын ЗГ-ын 214 тоот тогтоолоор батлагдсан “Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын 1.3-д “Бүх шатны сургууль, дамжаанд суралцах болон эмчлүүлж сувилуулахаар шилжигчид хугацаа харгалзалгүйгээр түр шилжсэнд тооцогдоно” хэмээх заалтаас үүдэж их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж буй оюутнууд орон нутгийн сонгуульд оролцох боломжгүй болж байна. Ингэснээр сонгуулийн насны хүн амын 4 орчим хувь /Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2002 он/-ийг эзэлдэг оюутнуудын сонгох эрх хязгаарлагдаж, сонгууль бүх нийтийн байх зарчим алдагдахад хүрч байна

1.9. Саналыг урьдчилан өгүүлэх, сонгогчийг шилжих боломжийг хуулиар зохицуулсан нь бүх нийтийн байх зарчмыг хангахтай холбоотой. Сонгогч санал авах өдрөөс өмнө сонгуулийн өөр хэсэгт шилжих боломжийг УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиуд/УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 18-р зүйл, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19-р зүйл/-д тусгаж өгсөн. Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль /Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 15-р зүйл/-д сонгогч

саналын хуудас хэсгийн хороонд очихоос өмнө аймаг, нийслэл, сум, дүүрэг дотроо нэг хэсгээс, нөгөө хэсэгт шилжиж болох тухай зааж өгсөн. Энэ нь орон нутгийн сонгууль бол байнга оршин суудаг газрынхаа хурлын байгууллагыг байгуулж байгаа онцлогтой холбоотой. Харин УИХ-ын сонгуулийн үед сонгогч санал авах өдрөөс өмнө хэдийд ч шилжих боломжтой байдлаар зохицуулсан нь сонгогчдыг бөөнөөр шилжүүлж, саналыг нь өгүүлдэг сонгуулийн булхай гарах боломжийг нээж өгсөн гэж үзнэ. Ингэснээр сонгогчдын тоо сонгуулийн зарим хэсэгт механикаар өсч, тэгш байх зарчмын чухал хэсэг болох сонгогч бүрийн саналын жин аль болох тэнцүү байх, нэр дэвшигчид өрсөлдөх тэгш боломжтой байх зэрэг зарчим алдагдахад хүрдэг тул саналын хуудас хэсгийн хороонд очихоос өмнө шилжих боломжтой байхаар хуулийн заалтыг өөрчлөн найруулах шаардлагатай.

УИХ /хуулийн 35-р зүйл/, Ерөнхийлөгч /хуулийн 33-р зүйл/, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын /хуулийн 29-р зүйл/ сонгуулийн тухай хуульд саналын хуудсыг хүлээн авснаас хойш санал авах өдөр хүртэлх хугацаанд буюу 5-аас доошгүй хоногийн өмнөөс саналаа урьдчилан өгөх боломжтой. Энэ хугацаа нь төдийлөн хангалттай хугацаа биш тул уртасгах боломжийг цаашдаа хуулийг боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай. Санал урьдчилан өгөх хугацаа сунгах нь бүх нийтийн байх зарчмыг хангахад чухал ач холбогдолтой болно.

1.10. Иргэний үнэмлэхийн хаягийн бүртгэл, хөдөлгөөнийг тойрсон маргаан 2004 оны сонгуулиудын нэг онцлог сэдэв байсан. Хэдийгээр иргэний үнэмлэхдээ шилжилт суурьшилттай холбоотой өөрчлөлтийг тухай бүрт нь хийлгэж байх нь иргэн хүний өөрийн үүрэг, хариуцлагын асуудал мөн боловч энэ ажлыг хариуцсан төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдэл их нөлөөлж байна.

1.11. Өнгөрсөн сонгуулиар шинээр иргэний үнэмлэх авах ёстой байсан зарим залуучууд мөн түүнчлэн иргэний үнэмлэхээ солиулахаар холбогдох байгууллагад нь өгөөд авч чадаагүй байсан хүмүүс сонгох эрхээ эдэлж чадахгүй байгаа талаар олон тооны гомдол санал гарч байв.

Хоёр. ТЭГШ БАЙДЛЫН ЗАРЧИМ

Ардчилсан сонгуулийн суурь зарчмын нэг бол нэг талаас сонгогч бүр адил тооны санал өгөх, санал бүрийн хувийн жин ижил байх, нөгөө талаас сонгогдогч бүр ойролцоогоор адил тооны сонгогчдыг төлөөлөх болон сонгуулийн үйл ажиллагаанд адил тэгш боломжоор хангагдах гэсэн гол агуулга бүхий тэгш байдлын зарчим мөн.

Тэгш эрхийн зарчим нь хүн бүрийн аливаа алагчлалаас ангид байх салшгүй эрхийг сонгуулийн үйл ажиллагааны хүрээнд баталгаажуулж өгдгөөрөө чухал ач холбогдолтой.

2.1. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд “...Ард түмний хүсэл зориг бол засаглалын үндэс мөн. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр ... тогтмол, хуурамч бус сонгууль явуулахад илрэлээ олно” гэж заасан /21 дүгээр зүйл/

ИҮТЭОУП-д иргэн нь тэгш эрхийн үндсэн дээр жинхэнэ ёсоор явагдаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй /25 дугаар зүйл/ байхыг баталгаажуулж өгсөн.

Монгол Улсын Үндсэн хууль болон УИХ-ын Сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хууль, Аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулиудад сонгуулийн тэгш байдлын зарчмыг нэрлэн баталгаажуулаагүй.

2.2. Сонгууль явуулахтай холбогдсон бүхий л үйл ажиллагаанд тэгш байдлын зарчим мөрдөгдөх учиртай. Сонгуулийн тойрог байгуулах, сонгогч бүр тэгш оролцоотой байх, бие даан нэр дэвшихэд шаардагдах сонгогч дэмжигчдийн тоо, нэр дэвшигчдийн сургалчилгаанд тэгш боломж олгох зэрэг нь сонгуулийн тэгш, тэнцвэртэй байдалд чухал нөлөөтэй байдаг.

УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ыг сонгох сонгуульд тойргуудыг байгуулдаг бол улс орон даяар нэг мандаттай явуулдаг Ерөнхийлөгчийн сонгуульд тойргуудыг байгуулдаггүй.

Тойргуудын сонгогчдын тоо ойролцоо байх талаар УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 8-р зүйлд *“Сонгуулийн нэг мандат бүхий тойргийг аймаг, нийслэл, дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө УИХ байгуулна. Аймгийн хүн амын тоо нь УИХ сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно.”* гэж заажээ. Аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 5-р зүйлд *“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгоход хүн амын тоог харгалзан тойрог бүр нэг мандаттай байхаар тооцож тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 18-аас доошгүй хоногийн өмнө сонгуулийн тойрог байгуулна”* гэжээ. Эдгээрээс харахад сонгуулийн тойргуудыг байгуулахад хүн амын тоог заавал харгалзан үзэхийг заасан.

УИХ-ын 1996 оны 4-р сарын 12-ны өдрийн 17-р тогтоолоор батлагдаж, 2000 оны 4-р сарын 20-ны өдрийн 33-р тогтоолоор бага зэрэг өөрчлөгдсөн сонгуулийн тойргийн цэсийг 2004 оны сонгуульд тэр хэвээр нь мөрдсөн. Гэтэл шилжилт хөдөлгөөн их байгаа өнөө үед 8 жилийн өмнө тогтоосон тойргуудын сонгогчдын тоо хоорондоо хол зөрөөтэй болсон нь илэрхий.

УИХ-ын 2004 оны сонгуулийн зарим тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтанд бичигдсэн сонгогчдын тоо

Аймаг, хотын нэр	Тойргийн дугаар	Нэрийн жагсаалтанд бичигдсэн сонгогчийн тоо
Дундговь	20-р тойрог	12 196
Хэнтий	51-р тойрог	11 105
Орхон	55-р тойрог	25 301
Улаанбаатар	58-р тойрог	30 431
	59-р тойрог	33 691
	67-р тойрог	34 199

/СЕХ-ны гаргасан мэдээнээс/

Үүнээс үзэхэд нийслэлийн 67-р тойргийн сонгогчдын тоо /34199/ Хэнтий аймгийн 51-р тойргийн сонгогчдын тооноос /11105/ даруй 3 дахин олон байгаа нь тэгш байдлын зарчимд харшилна.

Тойрог байгуулахад иргэдийн шилжилт хөдөлгөөн, хүн ам зүйн өөрчлөлтөд төдийлөн ач холбогдол өгөлгүй, өмнөх сонгуулийн тойргийн газар зүйг даган дуурайх байдлаар хандаж буй нь ийм тэгш бус байдалд хүргэж байна. Иймээс сонгуулийн тойргуудыг байгуулах, ингэхдээ холбогдох засаг захиргааны болон иргэний бүртгэлийн байгууллагатай хамтарч ажиллах талаар оновчтой, тодорхой журмыг сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд бий болгох шаардлагатай байна.

2.3. Сонгуульд сонгогч бүр харилцан тэгш тоотой санал өгөх буюу нэг сонгогч нэг удаа санал өгөх явдлыг хангах нь тэгш байдлын зарчим хэрэгжих үндсэн нөхцлийн нэг юм.

Сүүлийн үед сонгуулийн үр дүнд нөлөөлөх зорилгоор нэг сонгогч хэд хэдэн удаа санал өгөх оролдлого гарах болсон. Энэ үйлдлээс сэргийлэхийн тулд сонгогчдод үнэмлэх олгох, бэхэн тэмдэглэгээ тавих зэрэг арга хэмжээ авдаг ч төдийлөн үр дүнтэй байж чадахгүй байна.

Сонгуулийн хэсгийн хороод дээр санал авах өдөр сонгогчдын нэрийн жагсаалтанд өмнө нь нэр нь ороогүй хүмүүс санал өгөхтэй холбоотой гомдол санал 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр их гарсан.

2.4. Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд (нэр дэвших, бүртгүүлэх, сонгуулийн кампанит ажил зохион явуулах гэх мэт) тэгш боломжоор хангагдах ёстой.

2.4.1. Сонгуулийн кампанит ажлын үед нэр дэвшигчид тэгш боломжоор хангагдах талаарх эрх зүйн зохицуулалт Монгол улсын хууль тогтоомжид тусгагдсан байна. Тухайлбал, Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хуулийн 28.3-р зүйл, УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 21.3-р зүйл, Аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ийн Сонгуулийн тухай хуулийн 23.2-р зүйлд нэр дэвшигчид хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулахад тэгш боломжоор хангагдах эрхийг баталгаажуулсан.

Гэвч сонгуулийн кампанит ажлын явцад, ялангуяа сурталчилгаа хийхэд өрсөлдөгчдөд тэгш бус байдал үүсэх, эрх барьж буй улс төрийн хүчин эрх мэдлээ ашиглан сурталчилгаанд давуутай байх явдал газар авч байна. Ялангуяа УИХ-ын 2004 оны сонгуулийн үеэр МАХН-аас нэр дэвшигчдын сонгуулийн сурталчилгаа илт давуу, тэнцвэргүй байдалд болсоныг хэвлэл мэдээлэл, олон нийт зүй ёсоор шүүмжилж байв.

2.4.2. Өнгөрсөн сонгуулиудын үеэр эрх барьж байгаа улс төрийн хүчин төрийн албан хаагчид болон төрийн өмчийн хөрөнгийг сонгуулийн сурталчилгаанд ашиглаж байсан тохиолдол их хэмжээгээр гарсан.

Сонгуулийн сурталчилгаанд өрсөлдөгчдийг тэнцвэргүй байдалд хүргэж, улмаар тэгш бус байдлыг бий болгож явдал бол төрийн албан хаагчид сонгуулийн сурталчилгаанд оролцож, төрийн өмч хөрөнгийг сонгуульд ашиглаж буй явдал болно.

Өнгөрсөн сонгуулиудын сургамжаас харахад нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаанд төрийн байгууллагын ажилтнууд оролцож, үндсэндээ зарим байгууллагын үйл ажиллагаа нэр дэвшигчийг сонгуульд ялуулахад чиглэгдэж байсан.

...МАХН-аас нэр дэвшигчид бараг 100 % төрийн болон төсвийн, ААН байгууллагуудын дарга, удирдах ажилтнууд байсан учраас сонгуулийн сурталчилгаанд албан тушаалаа дээд зэргээр ашиглаж, 10-р сарын 1-нээс эхлэн Зуунмод сумын ЗДТГ нь дежур, үйлчлэгчдээс өөр ажилтангүй, бүгд 27 суманд хуваагдан сонгуулийн сурталчилгаанд ажилласан байна/Төв аймагт хийсэн судалгааны тайлангаас/.

Төрийн байгууллагын ажилчдыг дайчлуулан ажиллуулах явдал УИХ-ын сонгуулийн үеэр болон орон нутгийн сонгуулийн аль алинд их байдаг гэж /47,7 ба 41,7 хувь/ иргэд үзсэн. Төрийн байгууллагын ажилчид нэр дэвшигчдийн сурталчилгаанд ажиллах хэлбэр нь янз бүр байна.

Зарим нь өөрийн албан тушаал, эрх мэдлийн хүрээнд зайлшгүй үзүүлэх ёстой төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ дэмжиж буй нэр дэвшигч дээрхийг хийсэн мэтээр олон нийтэд ойлгуулан сурталчилгаандаа ашиглах тохиолдол байдаг / төсвийн мөнгөөр зам тавих, цалин тэтгэврийг олгох, ОУ-ын тусламж дэмжлэгийг өөрийн биеэр сонгогчдод тараах гм/.

Түүнчлэн сүүлийн үед гарч буй сонгуулийн үе дэх нэгэн булхайт үйлдэл бол өөрийн удирдлагад байдаг төрийн байгууллагын албан тушаалтнуудыг нэр дэвшиж буй тойрогтоо ажиллуулах нэрийдлээр санал өгүүлэх явдал юм. Ийм зөрчил өмнөх УИХ-ын сонгуулиар нэлээдгүй тохиолдож байсныг СЕХ-нд ирсэн зөрчил, гомдлын баримтууд нотолдог.

Төрийн албан хаагчдыг сонгуулийн компанид ажилд дараах байдлаар ашигладаг:

- Сонгуулийн ажилд төрийн албан хаагчдыг нам, эвсэл нэр дэвшигчийн сурталчилгааны компанид ажилд дайчлах
- Сонгуулийн штабдаа ажилуулах
- Сонгуулийн сурталчилгааны компанид ажлын үеэр нэр дэвшигчийг дэмжиж үг хэлүүлэх
- Уг төрийн албан хаагч нь сонгогчдын тодорхой нэр дэвшигчийн төлөө санал өгөхийг уриалах
- Уулзалт, арга хэмжээнүүдэд нэр дэвшигчийг дагалдан явах, тэдний өмнөөс асуултанд хариулах гэх мэт.

2.5. Сонгуулийн сурталчилгаанд төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг ашиглах, төрийн албан хаагчид нэр дэвшигчдийн сурталчилгааг хийх бас их түгээмэл байлаа.

Төрийн алба хааж буй нэр дэвшигчид албаны машин, утас, байрыг сурталчилгаа хийхдээ ашиглах, сурталчилгаандаа томилолтын зардал авах, төсвийн мөнгөөр сурталчилгаа хийж буйг судалгааны дүн, сонгогчдын санал, шүүмжлэл харуулж байна.

Нэр дэвшигчдийн сурталчилгаанд төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг зарцуулж буй эсэх тухай санал асуулгаас:

	УИХ		Орон нутгийн сонгууль	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Их гардаг	248	24.8%	177	17.7%
Ер нь гардаг	240	24%	231	23.1%
Хааяа гардаг	182	18.2%	203	20.3%
Гардаггүй	323	32.3%	371	37.1%
Хариулаагүй	7	0.7%	18	1.8%

*“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал”
тоон судалгаа НСХ 2004 он*

Иргэдийн хариултаас харахад төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг сонгуулийн сурталчилгаанд хууль бусаар ашиглах явдал УИХ-ын сонгуулийн үед гардаг гэж иргэдийн бараг тал хувь(48.8%) нь үзжээ. Энэ хувь хэмжээ орон нутгийн сонгуулийн үеэр ч мөн адил (40.8%) байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Төрийн өмч төсвийн хөрөнгөөс сонгуулийн ажилд хамгийн их ашиглагдаг нь төрийн өмчийн байр, албаны унаа, утас, төрийн мэдлийн хэвэл мэдээллийн хэрэгсэл, албан хаагчдын цалин хөлс, томилолтын зардал байдаг.

Нээлттэй нийгэм Форум, Сонгогчдын Боловсрол Төв, Глоб Интернэшнл ТББ-аас хийсэн “2004 оны УИХ-ын сонгуулийн компани ажлын санхүүжилтийн мониторинг” судалгаагаар төрийн албан хаагчид, төсвийн хөрөнгийг сонгуулийн кампанит ажилд ашиглаж буй талаар олон мэдээлэл цуглуулж, томоохон хэмжээний баримтуудыг олон нийтэд хүргэсэн юм.

Судалгаагаар нийтдээ 556 удаагийн арга хэмжээнд ажиглалт хийхэд төрийн 1788 албан хаагч дээрх 556 удаагийн сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд ашиглагдаж, 7798 цагийг зарцуулсан. Энэхүү 1788 албан хаагчийн 1766 нь МАХН-аас нэр дэвшигчдийн сонгуулийн арга хэмжээнд, 22 нь “Эх орон-Ардчилал” эвслээс нэр дэвшигчийн арга хэмжээнд оролцжээ.

Аймгийн Засаг даргын тамгын газрын ажилтнуудыг хөдөө сумдад албан томиллоор сонгуулийн ухуулга, сурталчилгаанд ашиглах нь ихээхэн түгээмэл байна. Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын ажилтнууд, агентлагын мэргэжилтнүүдийг бүх сумдад ажиллуулсан байлаа.

Өмнөговь аймгийн МАХН-ын Хороо сонгуулийн штабаа дөрвөн ажлын хэсэгтэйгээр байгуулахаа:

- Аюулгүй байдал, хууль зүйн хэсэг. Ахлагч нь аймгийн Засаг даргын тамгын газрын дарга
- Санхүү, хандив тусламжийн хэсэг. Ахлагч нь аймгийн Засаг даргын тамгын газрын санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн дарга
- Ухуулга, сурталчилгааны хэсэг. Ахлагч нь Даланзадгад сумын Засаг дарга
- Дэмжигчдийн хэсэг. Энэ хэсэг нь 110 ухуулагчтай бөгөөд тэдний 37 нь ерөнхий боловсролын сургуулийн багш, эмч, сувилагч зэрэг төрийн үйлчилгээний албан хаагчид байв. /Судалгааны тайлангаас/.

Дээрх 556 удаагийн арга хэмжээний 241 удаагийнхад нь төрийн өмчлөлийн 1033 машин тэргийг /51366 км зам туулсан/ ашигласны 1017 машин нь МАХН-ын

нэр дэвшигчдэд хамааралтай байжээ. Хөвсгөл аймгийн зөвхөн нэг суманд хийсэн ажиглалтаар цагдаагийн хэлтсийн машинаас эхлээд аймгийн Засаг даргын машин хүртэл нийтдээ 25 удаа төрийн байгууллагын машин тэргээр сонгуулийн сурталчилгаа хийж байв.

Гурав. ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЗАРЧИМ

Энэхүү зарчмын хүрээнд:

- сонгогч ямар нэг дарамт шахалт, сүрдүүлэг, хууль бус нөлөөлөлгүйгээр хуульд заасан хэлбэрээр сонгуульд оролцох, эс оролцох эсэхээ шийдэх, сонгуулийн үр дүнгээс шалтгаалан шийтгүүлэхээс айж эмээхгүйгээр сонголт хийх
- нэр дэвшигч ямар нэг дарамт шахалт, сүрдүүлгээс ангид байдлаар сонгуульд өрсөлдөх боломжтой байх асуудлууд багтдаг.

3.1. Манай улсын сонгуулийн хуулиудад сонгуульд чөлөөтэй оролцох эрхийг баталгаажуулж өгсөн. Тухайлбал УИХ-ын сонгуулийн хуульд: иргэд чөлөөтэй сонгоно, ...сонгогч саналаа чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахыг хориглоно /1-р зүйл/, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд: ... сонгуульд иргэд чөлөөтэй оролцоно /3-р зүйл/, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд...иргэд чөлөөтэй сонгох эрхтэй /3-р зүйл/ гэж тус тус заасан.

Дарамт шахалт, сүрдүүлгээс ангид, шударга, алагчлалгүй байдлаар сонгуульд өрсөлдөх боломжийг нэр дэвшигчдэд олгох нь сонгогчид жинхэнэ утгаараа сонголт хийхийн үндэс билээ. Сонгууль чөлөөтэй явагдсан эсэх нь эцэстээ сонгогчдын улс төрийн хүсэл зориг бүрэн дүүрэн илэрхийлэгдэж чадсан эсэхээр тодорхойлогдоно. Сонгогчид үнэн зөв, хангалттай мэдээлэл авч чадахгүй бол ард түмний жинхэнэ хүсэл зориг илэрхийлэгдэх боломжгүй.

Сонгуулийн тухай хуулиудад нэр дэвшигчид мөрийн хөтөлбөр, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ухуулга, сурталчилгаа хийх, холбогдох байгууллагаас зохих журмын дагуу мэдээлэл, лавлагаа авах эрхийг баталгаажуулсан. Эдгээр хуулиудаар нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглосон.

3.2. Сонгогчид саналаа гаднын нөлөөгүй, бие дааж, өөрийн дотоод итгэл, үнэмшлээр өгч чадаж буй эсэх нь сонгуулийн ажлын хамгийн чухал хэсэг болно. Сонгуульд санал өгөх үе шатанд иргэдийн сонгох эрхийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж, эрхийг нь зөрчиж буй байдлууд байгааг судалгаа, ажиглалтын дүн харуулж байна.

Сонгууль болох өдөр санал өгөх байранд саналаа өгөхөөр ирсэн зарим сонгогчийн хувьд дараах саад бэрхшээлүүд гардаг. Үүнд:

- Сонгогчдын нэрсийн жагсаалтанд нэр нь байхгүй;
- Сонгогч саналаа өгөөгүй байхад “санал өгсөн байна” -гэдэг үндэслэлээр саналын хуудсыг өгдөггүй;
- Сонгуулийн хэсгийн хорооны ажилтны зүгээс санал өгөхөд нь нөлөөлөхийг оролддог;
- Намуудын ажиглагчдын зүгээс нөлөөлөхийг оролддог;
- Тамга тэмдэггүй, сонгуулийн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн

даргын гарын үсэггүй саналын хуудсаар санал авсан зэргийг дурдаж болно. Ийм зөрчил нь 2004 оны Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн үеэр ихээхэн нийтлэг шинжтэй байсан.

Нийгмийн судалгааны хүрээлэнгээс 1000 хүний дунд хийсэн судалгаагаар судалгаанд оролцогчдын 118 нь /11,8 хувь/ санал өгөхөд нөлөөлөлөхийг оролдсон, 65 нь /6,5 хувь/ нэрийн жагсаалтанд нэр нь байхгүй байсан, 11 нь /1,1 хувь/ тамга тэмдэггүй, хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэггүй хуудсаар санал өгүүлсэн гэж хариулсан нь зүй ёсоор анхаарал татаж байна.

3.3. Иргэд чөлөөтэй сонголт хийхэд сонгуулийн сурталчилгаа, түүнтэй холбоотой мэдээлэл чухал ач холбогдолтой. Нэр дэвшигчид элдэв амлалт өгөх, бэлэн мөнгө архи, эд бараа тараах зэргээр сонгогчдыг өөртөө татаж, олноор нь шилжүүлж, өөрийнхөө тойрогт санал өгүүлэх, эл үйлдэлд нь засаг дарга нар, сонгуулийн хороодын гишүүд хамсан оролцох нь ердийн үзэгдэл болжээ.


УИХ-ын 2004 оны сонгуульд нэр дэвшигчид хүмүүс зөөж, өөрийн төлөө санал өгүүлэх явдал тун нийтлэг байсан бөгөөд орон нутгийн сонгуульд ч ийм зөрчил байсныг судлаачид дурдаж байна.

3.4. Иргэдийн сонгох, сонгогдох эрхээ ухамсартайгаар хэрэгжүүлэхэд олон хүчин зүйл нөлөөлдөг нь мэдээж боловч сонгуулийн сурталчилгаа онцгой байрыг эзэлдэг.

Сонгуулийн сурталчилгааг дотор нь нэр дэвшигчийн тухай мэдээлэл /сурталчилгаа/, сонгуульд оролцогч нам эвсэлийн сурталчилгаа гэж ангилж болох юм.

3.4.1. Сонгогчдод зайлшгүй шаардлагатай мэдээллийн нэг чухал хэсэг нь нэр дэвшигчдийн тухай мэдээлэл байдаг.

УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмж




“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

Сонгогчид УИХ-д нэр дэвшигчийн тухай мэдээллийг орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдээс илүү ихээр хүлээн авдаг байна.

Иргэдийн олонхи нь буюу 63.4 хувь нь тус шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл хангалттай авдаг гэсэн байхад дөнгөж 6 хан хувь нь энэ талын мэдээлэл хангалтгүй гэж үзсэн байна.

Харин орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмж доогуур түвшинд гарч байна.

Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмж



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

Сонгогчдын тал хүрэхгүй хувь нь аймаг, нийслэлийн сонгуульд нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэлтэй байдаг гэж үзсэн байна.

10 сонгогч тутмын нэг нь эл шатны сонгуульд нэр дэвшигчдийн тухай мэдээллийг сонирхон хүлээдэггүй байхад харин түүнээс арай илүү хувь нь сонирхсон ч энэ талаар хангалттай мэдээлэл авч чаддаггүй гэжээ.

Энэ шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг насны бүлгүүд хүлээн авах байдал нь харилцан адилгүй бөгөөд залуучуудын дөнгөж 36 хувь нь хангалттай хүлээн авдаг байхад 15 хувь нь мэдээлэл огт хангалтгүй гэж хариулсан.

Аймаг нийслэлийн ИТХ-д нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр хангагдсан байдал

/орон нутаг хувиар/

Дүүргүүд	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Өөрөө сонирхоогүй	Нийт
Сонгино хайрхан	57.9	21.4	13.5	7.1	100.0
Хан-Уул	42.1	27.8	15.9	14.3	100.0
Баянгол	58.4	28.8	7.2	5.6	100.0
Баянзүрх	32.8	39.2	16.0	12.0	100.0
Аймгууд					
Өмнөговь	59.8	27.4	7.7	5.1	100.0
Ховд	42.7	40.0	12.7	4.5	100.0
Дархан-Уул	45.9	30.8	17.0	6.3	100.0
Дорнод	32.1	34.8	14.3	18.8	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

Орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг УИХ-ын сонгуультай харьцуулахад иргэдэд хүрэх хэмжээний хувьд ч, иргэдийн зүгээс сонирхох хандлага ч харьцангуй бага байна.

Аймгуудын сонгогчдын хувьд зарим газарт 60 орчим хувь нь нэр дэвшигчийн тухай мэдээллээр хангагдсан байхад зарим газар тухайлбал: Дорнодод тун доогуур үзүүлэлттэй, иргэд энэ талын мэдээллийг хүлээн авч чадахгүй байх нь нэлээд өндөр хувьтай байв. Санал асуулгын дүнгээс харахад дүүргүүдэд сонгогчдын 13-16 хүртэл хувь нь нэр дэвшигчдийн талаар огт хангалтгүй мэдээлэлтэй байсан.

Мөн түүнчлэн иргэд орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөх, анхаарлаа хандуулах нь бага байгаа нь харагдаж байна.

Сум, дүүргийн ИТХ-д нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр хангагдсан байдал

Дүүргүүд	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Өөрөө сонирхоогүй	Нийт
Сонгино-хайрхан	51.6	18.3	19.8	10.3	100.0
Хан-Уул	45.2	23.8	12.7	18.3	100.0
Баянгол	56.0	26.4	5.6	12.0	100.0
Баянзүрх	23.2	31.2	24.8	20.8	100.0
Аймгууд					
Өмнөговь	52.1	22.2	18.8	6.8	100.0
Ховд	34.5	30.9	18.2	16.4	100.0
Дархан-Уул	46.5	24.5	18.2	10.7	100.0
Дорнод	25.0	25.0	21.4	28.6	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

3.4.2. Нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл нь хүртээмжтэй, хангалттай байхаас гадна түүний агуулга нь бодитой үнэн байж чадах эсэх нь иргэдийн сонгох эрхээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Нэр дэвшигчийн тухай мэдээллийн агуулгын талаарх иргэдийн үнэлгээ

Мэдээллийн агуулга	Хариултын тоо	Хувь
Нэр дэвшигчийг танилцуулах мэдээлэл байсан	522	52.2
Хов жив гүтгэлгийн шинжтэй зүйл байсан	102	10.2
Ихэвчлэн гутаан доромжлох зүйл байсан	29	2.9
Хэт өрөөсгөл, нэг нам хүчнийг дэмжсэн мэдээлэл байсан	186	18.6
Сонирхолтой олон талыг хамарсан мэдээлэл байсан	123	12.3
Өөр	38	3.8
Нийт	1000	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

Судалгаанд оролцогчдын 30 гаруй хувь нь сурталчилгааны үе дэх нэр дэвшигчдийн тухай мэдээлэл нь ямар нэг байдлаар хууль ёсны дагуу байж чадаагүй гэжээ. Тухайлбал: сонгогчдод ирсэн мэдээлэл хэт өрөөсгөл, нэг нам, хүчнийг дэмжсэн, эсхүл нэр дэвшигчид өрсөлдөгчдөө гүтгэсэн, түүний талаар үндэсгүй яриа, хов живээр хөөцөлдсөн, цаашилбал гутаан доромжилсон, нэр төрд нь халдсан зэргээс харагдаж байна.

Бид хөдөө амьдардаг хүмүүс, хоёр намын сурталчилгаа адилхан бие биеэ муулсан байдлаар явагдсан - Итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь шууд орж ирээд манай намд санал өгнө шүү гээд янз бүрийн юм ярьж ухуулж эхэлдэ /Өмнөговь аймаг. Бүлгийн ярилцлагаас/.

Сонгуулийн үеэр Засгийн эрх барьж буй нам эрх мэдлийн байдлаа ашиглан хэвлэл мэдээллийн хэрэгслийг давуу байдлаар эзэмшдгээс үүдэн нэг нам, хүчний нэр дэвшигчийн тухай мэдээлэл сонгогчдод зонхилон хүрч, сонгуулийн сурталчилгаа хэт өрөөсгөл байдалд явагддагийг олон нийт шүүмжилж байв.

Улс төрийн нам, хүчнүүд болон нэр дэвшигчид сурталчилгааны ажилдаа олон нийттэй харилцах хар ажиллагаа болох хов жив, гүтгэлэг, гутаах зэрэг үйлдлийг эрээ цээргүй, өргөн хүрээгээр хийж буй нь эрхэд туйлын сөргөөр нөлөөлж байна.

Нэр дэвшигчийн талаарх мэдээллийн агуулгад иргэдийн зүгээс өгсөн үнэлгээг тэдний орон нутгийн харьяаллаар харвал доорх байдалтай байна.

Сонгуулийн үеэр нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн агуулга

Дүүргүүд	Танилцуулах	Хов жив гүтгэлэг	Гутаан доромжлох	Хэт өрөөсгөл нэг нам хүчний талд	Сонирхолтой олон талыг хамарсан	Бусад	Нийт
Сонгинохайрхан	59.5	11.1	1.6	19.0	7.9	0.8	100.0
Хан-Уул	54.0	9.5	2.4	17.5	11.9	4.8	100.0
Баянгол	56.8	7.2	4.8	11.2	15.2	4.8	100.0
Баянзүрх	53.6	12.0	3.2	16.8	12.8	1.6	100.0
Аймгууд							
Өмнөговь	65.8	2.6	0	11.1	13.7	6.8	100.0
Ховд	41.8	9.1	1.8	33.6	13.6	0	100.0
Дархан-Уул	42.8	13.8	3.8	20.8	14.5	4.4	100.0
Дорнод	44.6	15.2	5.4	19.6	8.0	7.1	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

Орон нутаг дахь улс төрийн нам хүчнүүдийн хүчний харьцаа, тэнцвэргүй байдал, эрх мэдэл, албан тушаалаас нь хамаараад зарим нэр дэвшигчийн талаарх мэдээлэл нь хэт өрөөсгөл, нэг талыг барьсан шинжтэй байсан талаар иргэд шүүмжилж байна. Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүрэг, Ховд, Дархан-Уул, Дорнод зэрэг аймгуудад ийм зөрчил дутагдал харьцангуй их, нэр дэвшигчдийн талаар хэт өрөөсгөл, нэг талыг барьсан мэдээлэлтэй байсан гэж иргэдийн 16-аас 30 хүртэл хувь нь хариулсан.

3.5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сонгуулийн үеэр цацагдсан нийтлэлийн агуулгад хийсэн судалгааны дүнгээс харахад өрөөсгөл, гуйвуулсан, өрсөлдөгчөө гутаан доромжилсон мэдээлүүд их хэмжээгээр цацагддаг байна. Орон нутгийн сонгуулийн үеэр нийслэлийн телевизүүдээр гарсан сонгуулийн сурталчилгаанд судалгаа хийхэд 66.7 хувь нь энгийн сурталчилгаа, 8.4 хувь нь нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага, 11.1 хувь нь мэдээ, мэдээлэл, 12.0 хувь нь нам хүчний захиалгат нэвтрүүлэг, 0.5 хувь нь мэдэгдэл байсан байна.

Тэдгээр нийтлэлийн төрлүүдээс агуулгын хувьд сонирхвол нэр дэвшигч нам хүчин, бие хүмүүсээс өөрсдийн талаар танилцуулах, мэдээлэх шинжтэй нь олонхи болж байгаа ч гүтгэх, гутаан доромжлох, нэр төрд нь халдах зорилгыг агуулсан тохиолдууд цөөнгүй тааралдсан юм.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийн нийтлэлийн агуулгад хийсэн шинжилгээний үр дүнг харвал дараах байдалтай байна.

ТВ-ийн нэвтрүүлгээр орон нутгийн сонгуулийн үед цаагадсан мэдээллийн агуулга


Нийтлэлийн агуулга	Давтамж	Хувь
Нэр дэвшигч нам хүчнээс танилцуулах	1045	65.1
Нэр дэвшигч нам хүчнээс мэдээлэх	271	16.8
Өрсөлдөгчөө гүтгэх, нэр төрд нь халдах	13	0.8
Өрсөлдөгчөө гутаан доромжлох	43	2.6
Сонгогчдыг уриалах	201	12.5
Өрсөлдөгчөө шүүмжлэх	24	1.4
Хэлэлцүүлэг явуулах	8	0.4
Нийт	1605	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал”

судалгаа НСХ 2004 он

2004 оны сонгуулийн үед нэр дэвшигчид өрсөлдөхдөө бие биенээ гүтгэх, доромжлох нь ердийн үзэгдэл болсон хүний эрхэд шууд халдсан үйлдэл болж байна.

Сонгуулийн сурталчилгааны үед нэг нэгнээ гүтгэн доромжлох байдал



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал”

судалгаа НСХ 2004 он

Графикаас харахад нэг нэгнээ гүтгэн доромжилдог үйлдэл буюу нэр дэвшигчдийн сонгогдох эрхийн зөрчлүүд УИХ-ын сонгуулийн үед ихээхэн гардаг (44.5%) аж.

Харин орон нутгийн сонгуулийн хувьд энэ нь бага хувьтай(18.7%) байгааг харж болно.


Улс төрийн хүрээнд шударга бусаар өрсөлдөж, харилцан бие биенээ үгүйсгэх хийгээд гүтгэн доромжилсон үйлдлүүд нь /хар PR ч гэж ярьдаг/ иргэдийн дунд улс төрд үл итгэх байдлыг бий болгох төдийгүй иргэдийг зөв, бодит сонголт хийх боломжгүй болгох зэрэг сөрөг үр дагаврыг дагуулж байна.

Улс төрийн намуудын хувьд харилцан бие биенээ гүтгэх, доромжлох явдал сонгуулийн явцад цаг үргэлж гарч буй боловч нэр дэвшигчийн эрхийг зөрчсөн,

үндэслэлгүйгээр гүтгэн доромжилсон үйлдлүүдэд хариуцлага хүлээлгэдэггүйн улмаас энэ зөрчил цаашид улам даамжрах төлөвтэй байна.

3.6. Сонгогчдын саналыг авахын тулд худал амлалт өгөх, сонгогчдыг хуурч мэхлэх, хууль бус аргыг их хэрэглэх болсон нь зүй ёсоор анхаарал татаж байна. Ялангуяа ийм хууль бус аргыг УИХ-ын сонгуулийн үеэр нэр дэвшигчид их хийх болсон. Сонгогчдын 34,4 хувь ийм байдал их гардаг гэж үзсэн. Харин орон нутгийн сонгуулийн үеэр худал ойлголт амлалт өгөх явдал УИХ-ын сонгуультай харьцуулахад харьцангуй бага гардаг гэж сонгогчид үздэг боловч ийм явдал 18.9% байгаа нь анхаарал татах зүйл юм.

Сонгогчдын саналыг авахын тулд худал ойлголт амлалт өгөх



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

Иргэдийн зүгээс сонгуульд нэр дэвшигчдийн худал амлалтанд шүүмжлэлтэй хандаж, дургүйцэх болсон нь судалгаанаас харагдаж байна.

Худал, биелэгдээгүй амлалт нь сонгогчдыг төөрөгдүүлж, зарим тохиолдолд итгэл үнэмшлийг бий болгон, тэдний сонголтонд нөлөөлдөг. 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр худал биелэшгүй амлалтууд үнэхээр их гарч, өрсөлдөгч нам, эвсэл, нэр дэвшигчид хэн нь илүү худал амлаж чадахаараа уралдаж байсан гэж хэлэхэд нэг их хилсдүүлсэн болохгүй юм.

Сонгуулийн сурталчилгааны явцад нэр дэвшигчид ажил төрөл бүтээж өгнө, сургуульд хүүхэд оруулж өгнө гэж амлах, буцалтгүй тусламж олгох зэрэг арга хэлбэрүүдийг ашиглаж байв. Тойрогт нь амьжиргааны түвшин тааруу өрхүүд байгаа бол хүнсний зүйл мөнгө тараах, гэр хорооллын айлуудын өрхийн хогийг ачих, оюутан хүүхдийнх нь сургалтын төлбөрийг хөнгөлөх, ажилгүй залуучуудыг мэргэжил курс дамжаанд хөнгөлөлттэй сургах зэрэг зүйлийг хийж байв /Орхон аймагт хийсэн ажиглалтын судалгаанаас/.

Иргэдэд худал мэдээлэл өгөх явдал гарч байсан. Тухайлбал Хөдөөгийн ядуурлыг бууруулж өсөлтийг дэмжих зээлийг нэр дэвшигч өгч байгаа мэтээр харуулах ярих явдал гарч байлаа /Булган аймагт хийсэн ажиглалтын судалгаанаас/.

2004 оны УИХ-ын сонгуульд өрсөлдсөн хоёр гол хүчин болох МАХН ба “Эх орон - Ардчилал” эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс одоо нэгэнт биелэгдэхгүй болсон зарим нэг амлалтыг дурдвал:

МАХН-ын мөрийн хөтөлбөрт:

- Анх удаа гэрлэж буй шинэ гэр бүлд нэг удаа 500.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгоно
- Шинээр мэндэлсэн хүүхэд бүрт нэг удаа 100.000 төгрөгийг тэднийг өсгөж бойжуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олгоно
- 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийг олон хүүхэдтэйд тооцон өргөтгөж, 1 өрхөд жилд 100.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгоно.

“Эх орон-Ардчила” эвслийн мөрийн хөтөлбөрт:

- 18 хүртэлх насны бүх хүүхэд сар бүр 10.000 төгрөгийг олгоно.
- Төрийн албанд танил тал, хамаатан саднаараа нэг удирдлагын дор ажиллаж, хууль завхруулдаг явдлыг таслан зогсооно.

3.7. Сонгогчдын саналыг худалдан авах, сонгогчдыг татах зорилгоор төлбөртэйгээр болон үнэ төлбөргүйгээр бараа тараах, тусламж олгох, урлаг спорт, ахуйн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхийг хориглосон байдаг боловч ийм төрлийн зөрчил аль ч сонгуулийн үеэр хавтгайран гаарч, үнэн хэрэгтээ энэ нь сонгуулийн сурталчилгааны гол арга хэрэгсэл болсон.

Нэр дэвшсэн хүмүүс ихэнх нь бизнесмен хүмүүс байдаг. Тэд дандаа мөнгө төгрөгөөр цохиж ядарсан ард түмний саналыг худалдаж авч байна /Дархан Уул аймагт хийсэн бүлгийн ярилцлагаас/.

Сонгогчдын саналыг худалдан авахыг оролдох байдлыг иргэдийн зүгээс хэрхэн үзэж буйг судалгаагаар харуулбал:

	УИХ		Орон нутгийн сонгууль	
Нэлээд их гардаг	315	31.5	149	14.9
Ер нь гардаг	278	27.8	227	22.7
Хааяа нэг гардаг	149	14.9	203	20.3
Гардаггүй	255	25.5	411	41.1
Хариулаагүй	3	0.3	10	1

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

Хүснэгтээс харахад иргэдийн саналыг худалдан авахыг оролдох нь ихээхэн түгээмэл байдаг гэж 3 сонгогч тутмын нэг нь хариулжээ. Иргэдийн саналыг худалдан авах явдал нь өөрт нь буюу сайн мэдэх хүнээр, эсвэл танил талаар нь дамжуулан мөнгө төгрөг өгөх, бэлэг сэлт, ойр зуурын хэрэгсэл дурсгах, хүнс хувцас тараах, тусламжийн барааг олгох хэлбэрээр ихэвчлэн гарч байлаа.

Сонгуулийн сурталчилгааны үед санал худалдан авахын тулд нэр дэвшигчдийн зүгээс явуулсан үйл ажиллагаа Танд болон танай гэр бүлд тохиолдож байсан уу гэсэн асуултад иргэдийн зүгээс дараах хариулыг өгсөн.

	Надад тохиолдсон		Манай гэр бүлд тохиолдсон		Үгүй		Нийт
Бэлэн мөнгө өгөх	68	6.8%	69	6.9%	863	86.3%	1000
Бэлэг сэлт гардуулах	72	7.2%	130	13.0%	798	79.8%	1000
Албан тушаал амлах	36	3.6%	52	5.2%	912	91.2%	1000
Найр наадам цайллагад урих	90	9.0%	73	7.3%	837	83.7%	1000

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он

Судалгааны дүнгээс харахад нэр дэвшигчийн зүгээс сонгогчдын санал нөлөөлөх буюу худалдан авах зорилгоор хувь хүнийг найр наадам, дайллага, цайллагад урих нь ихээхэн түгээмэл байгаа ба бэлэг сэлт гардуулах (7.2%), бэлэн мөнгө өгөх (6.8%), албан тушаал амлах (3.6%) зэрэг хууль бус үйлдлүүд ч гарсаар байгаа юм.

Дөрөв. САНАЛАА НУУЦААР ГАРГАХ ЗАРЧИМ

Саналаа нууцаар гаргах нь сонгох эрхийн язгуур зарчмын нэг юм. Энэ нь туйлын шинж чанартай бөгөөд ямар ч байдлаар хязгаарлагдах ёсгүй. Саналаа нууцаар гаргах зарчмуудыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, сонгогчид айдас, дарамт шахалтгүйгээр саналаа нууцаар гаргах нөхцлийг бүрдүүлэх нь төрийн үүрэг. Саналаа нууцаар гаргах нь санал өгөх үйл явцыг дарамт, шахалтаас хамгаалах эртнээс хүлээн зөвшөөрөгдсөн арга зам билээ. /НҮБ-ын Хүний эрхийн төвөөс эрхлэн гаргасан “Хүний эрх ба сонгууль” гарын авлага, Нью-Йорк, Женев, 1994 он/

Хуулиар тогтоосон арга замаар саналаа нууцаар гаргах зарчмыг баримтална гэдэг нь сонгогч өөрийн хүсэл зоригийг илэрхийлэхэд ямар нэгэн саад тогтор үзүүлэхгүй байх, нэр дэвшигчид, нэр дэвшиж буй улс төрийн нам, эвслээс чөлөөтэй сонгох боломжийг бүрдүүлсэн эрх зүйн тэгш нөхцлийг хангах явдал юм.

Саналаа нууцаар гаргах эрхийг манай сонгуулийн хуулиудад тодорхой зааж өгсөн байдаг.

Санал өгөх байр, кабины байршил, тоноглол нь сонгогч саналаа нууцаар, бусдын хараа хяналт, нөлөөлөөс ангид гаргах боломжийг тэр бүр олгохгүй байгаа, зарим тохиолдолд сонгогч аль нэр дэвшигчийн төлөө саналаа өгч байгаа нь ил харагдах нөхцөл байдалтай байсныг судлаачид шүүмжилж байна.

Зөврийн хайрцагаар санал авахад ихээхэн хэмжээний зөрчил гарч байсан нь 2004 оны сонгуулиудын нэг онцлог байв.

Сонгуулийн хэсгийн хороод зөврийн хайрцагаар санал авах сонгогчдын нэрсийг урьдчилж гаргадаггүй, зарим тохиолдолд зөврийн хайрцагаар санал авах шаардлагагүй сонгогчдоос зөврийн харцагаар санал авах, эсхүл оролцогч намуудын ажиглагчидгүйгээр, эсхүл аль нэг намын ажиглагчийг оролцуулахгүйгээс болж үлэмж хэмжээний санал, гомдол, зөрчил гарч байв.

УИХ-ийг сонгох сонгуулийн 24 дүгээр тойрогтой холбоотой маргаан нь зөврийн хайрцагаар санал авах журамтай голлон холбоотой байлаа.

ХОЁР. ЗОХИСТОЙ ХООЛ ХҮНСЭЭР ХАНГАГДАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Хүн бүр эсэн мэнд амьдарч, хөдөлмөрлөх, эрүүл бие, саруул оюун ухаантай байхын тулд зохистой, аюулгүй, хүрэлцээтэй хоол хүнсээр жигд хүртээмжтэй хангагдах ёстой бөгөөд үүнийг хүний хүнсний эрх хэмээх ойлголтод хамааруулж байна. Харин хүрэлцээтэй, шимт бодисын зохистой харьцаатай, аюулгүй хоол хүнсийг авбал зохих хамгийн бага хэм хэмжээг зайлшгүй тогтоож өгөх ёстой бөгөөд хүн хоол хүнсээ түүнээс багагүй хэмжээгээр олж авч байж сая хүнсний эрхээ эдэлж байна гэж үзэх үндэстэй.

Манай улсын соёрхон баталсан олон улсын хүний эрхийн хэд хэдэн баримт бичгүүдэд уг эрх тусгагдаад байна.

Хүний эрхийн түгээмэл Тунхагалд (1948) “хүн бүр хоол хүнс . . . оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй” гэж тунхагласан. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын Пактад (1966): “хүн бүр ... зохистой хоол хүнстэй байх эрх” -ийг цохон тэмдэглэсэн.

Зохистой хоол хүнсээр хангагдах эрх гэдэг нь хүн бүр хүрэлцэхүйц хоол хүнсээ олж авах болон түүнд нийцсэн бие бялдар болон эдийн засгийн чадвартай байхыг хэлнэ.

Зохистой хоол хүнсээр хангагдах эрхэд хоол хүнс нь хүрэлцээтэй, аюулгүй, шимт бодисын зохистой хэмжээ, харьцаатай байх гэсэн ойлголтууд багтаж байдаг.

Хоол хүнс нь тоо хэмжээ, чанараараа хувь хүний өдөр тутмын хүнсний хэрэгцээг хангахуйц байхын дээр янз бүрийн хорт бодис агуулаагүй, тухайн соёл, ахуйн хүрээнд нийцсэн байх ёстой.

2.1. Монгол улсын Үндсэн хуульд “зохистой хоол хүнсээр хангагдах эрх” шууд утгаараа тусгагдаагүй боловч энэ нь “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх” болон “эрүүл мэндээ хамгаалуулах . . . эрх”-тэй салшгүй холбоотой юм.

Үндэсний хууль, тогтоомжуудад, тухайлбал Хүнсний тухай, Эрүүл мэндийн тухай, Ариун цэврийн тухай, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай, Стандарчлал, Тохирлын үнэлгээний тухай зэрэг 10 шахам хууль, тогтоомжид энэ эрх нь ямар нэг байдлаар тусгагдсан байдаг. Хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулсан гол хууль болох одоогийн дагаж мөрдөж байгаа Хүнсний тухай (1999 оны) хуулийг өмнөх Хүнсний тухай (1995 оны) хуультай харьцуулахад энэ эрхийг баталгаажуулахад чиглэгдсэн олон заалтыг орхигдуулж, үнэн хэрэгтээ одоогийн хуулинд өмнөхөөсөө ухралт хийснийг харж болно.

Хүнсний тухай анхны хуульд хүний эрхийн олон улсын стандарт, олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмжийг нэлээд дэлгэрэнгүй тусгаж, хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаатай болгож хэрэгжүүлэхэд төрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан байдаг.

Гэтэл 4 жилийн дараа энэхүү хуулийг шинэчлэн найруулж, батлахдаа (1999 он) хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулж, хэрэгжүүлэхтэй холбоотой олон чухал заалт, энэ талаарх төрийн бодлого, зохицуулалтын шинж чанартай зорилт, чиг үүрэг, хүн амд эерэгээр хандсан гол гол заалтуудыг хассан байв.

2.2. Монгол улс хүнсний нөөцийн хувьд өнөө ба ойрын ирээдүйд, тэр ч байтугай нилээд алс хэтдээ хүнснийхээ гол хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бүрэн чадавхитай орон юм. Ийм боломжийг манай орны өргөн уудам нутаг дэвсгэр, мал сүрэг, хүнсэнд ашиглах байгалийн баялаг маань олгодог байв.

Монгол улсын хүнсний нөөц

Мал сүргийн тоо, сая толгой. Үүнээс:	24,0-30,0
эх мал	12,0-14,0
жилд бойжуулах төл	9,0-11,0
Жилд үйлдвэрлэх мах, няд, жин мян.т	230,0-300,0
Жилд үйлдвэрлэх сүү, сая л	500,0-600,0
Хөдөө аж ахуйн эдэлбэр газар, мян. га,	126000,0
Үүнээс:	
Хадлан, бэлчээр талбай	124000,0
Эргэлтийн талбай	1340,0
Жил бүр тариалах боломжтой талбай,	800,0
Үүнээс:	
Үр тарианы	600,0
Төмсний	11,0
Хүнсний ногооны	3,0
Жилд авах ургац, мян. т	
Үр тариа, бүгд	600,0
Буудай	400,0
Төмс	130,0
Хүнсний ногоо	50,0
Ундны ус, км. куб	34000,0

2.3. Манай орон хүнсний нөөцөө хэрхэн ашиглаж байгааг харахад махны нөөцийг бүрэн ашиглаж, хүн амын хэрэгцээг хангаж, улмаар малын махыг экспортолдог. Харин сүүний нөөцийн 50-60 хувийг л ашигладаг ба энэ нь хүн амынхаа хэрэгцээг бараг хангаж байгаа гэдэг боловч зохистой хэрэглээний бүтцээр бодвол сүү, цагаан идээний хэрэглээний жишиг бодит байдлаас доогуур тогтоогдсон байх магадлалтай. Учир нь 1980 оны Монголын хүн амын хоол хүнсний физиологийн нормд сүү, сүүн бүтээгдэхүүний жишсэн нэг хүний дундаж хэрэгцээг 740 мл байхаар тооцож байсан бол 1997 онд шинэчилсэн нормоор энэ хэмжээг 380 мл хүртэл бараг 2 дахин бууруулсан байна. Хүнсний нөөц ашиглалтын байдлаас үзвэл үр тариа, ялангуяа буудай, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлт ихээхэн анхаарал татаж байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлвэрлэлт, хэрэгцээ

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжээ нэгж	Жилийн үйлдвэрлэлт	Жилийн хэрэгцээ	Зөрүү / +; - /
1	Малын мах	нядалгааны жин мян. т	226,4	180,0	+46,4
2	Сүү	сая. л	290,3	297,4	+7,1
3	Үр тариа, бүгд Үүнээс: буудай	мян. т	142,2 138,7	370,0 350,0	-227,8 -211,3
4	Төмс	мян. т	58,0	90,0	-32,0
5	Хүнсний ногоо	мян. т	44,5	150,0	-105,5
6	Өндөг	сая. шир	7,7	25,6	-17,9

Дээрхээс үзэхэд газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх асуудал төрийн бодлогын тулгамдсан зорилт болж байна. Нэгэнт эх орны хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлтээр махнаас бусад хэрэгцээг бараг хангаж чадахгүй байгаа болохоор хэрэгцээний дутууг импортоор нөхөж байна. Манай улс гурилын

хэрэгцээний 80-аад хувь, төмс, хүнсний ногоо, өндөгний дийлэнх хувь, цөцгийн тос, хатаасан болон өтгөрүүлсэн сүү, ургамлын тос, загасан бүтээгдэхүүн, чихрийн зүйл төрөл, будааны хэрэгцээг зөвхөн импортын эх үүсвэрээр хангаж байна. Гурил, төмс, хүнсний ногооны импортын зонхилох хувийг зөвхөн хөрш хоёрхон орон эзэлж байна. Ийнхүү Монгол улс хүнсний тодорхой нөөцтэй боловч хэрэгцээнийхээ зонхилох хэсгийг импортоор хангадаг болж, хангамжийн баталгаа алдагдсан, гурил, төмс, хүнсний ногооны хувьд гадаад орноос хараат байдалтай байгааг тоо баримтууд харуулж байна.

2.4. Хүнсний хангамжийн бодит байдлыг үнэлэх шалгуур нь хүний бие махбодид шаардлагатай хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ болно.

Монгол хүний хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээг судалгааны үндсэн дээр анх 1981 онд тогтоож, 1997 онд шинэчилж, Эрүүл мэндийн сайд баталж байжээ.

**Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний жилийн хэрэглээ
/Жишсэн дундаж хүнд кг-аар/**

№	Бүтээгдэхүүн	Зөвлөмж	1990	1995	1999	2000	2001	2002
1	Мах, махан бүт	84,0	97,0	96,7	112,8	120,0	97,2	120,0
2	Сүү, цагаан идээ	138,7	118,0	125,3	146,4	130,8	100,8	130,8
3	Цөцгийн тос	9,8	3,0	4,2	2,4	2,4	2,4	2,4
4	Гурил, гурилан бүтээгдэхүүн	124,1	97,0	94,3	99,6	108,0	110,4	108,0
5	Будаа	16,4				14,4	15,6	14,4
6	Чихрийн зүйл	21,9	23,0	8,7	8,4	10,8	12,0	10,8
7	Загас, загасан бүт.	3,1	1,0	0,7	0,00	0,00	2,4	0,00
8	Өндөг (ширхэг)	85,0	29,0	2,5	3,6	8,4	14,4	8,4
9	Төмс	43,8	23,0	11,3	16,8	21,6	26,4	21,6
10	Хүнсний ногоо	73,0	20,0	7,9	12,0	12,0	16,8	12,0
11	Жимс, жимсгэнэ	102,2	9,0	0,3	2,4	3,6	3,6	3,6
12	Ургамлын тос	9,1	1,0	0,9	1,2	4,8	6,0	2,4

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний зөвлөмж хэмжээ, бодит хэрэглээний статистикийн судалгааг зэрэгцүүлэн үзэхэд өнөөгийн байдлаар монгол хүний хэрэгцээ зөвхөн мах, махан бүтээгдэхүүнээр бүрэн хангагдаж байна. Харин бусад бүтээгдэхүүн хүн амын хүнсний хэрэгцээний, ялангуяа аминдэм, аминхүчил, эрдэс бодисын гол эх үүсвэр болох төмснийх 49,3%, хүнсний ногооных 16,4%, цөцгийн тосных 24,4%, өндөгнийх 9,8%, жимс, жимсгэнийх дөнгөж 3,1%, ургамлын тосных 26,3%-ийг тус тус хангаж байгаа бөгөөд загасаар бараг хангагдахгүй байна. /Санхүү, ХХААЯ, хүнсний хараат бус байдлын семинарын материалаас, 2004 он/.

Газар тариалан бол хүн амын хүнсний хэрэгцээг хангах гол эх үүсвэрийн нэг яах аргагүй мөн.

Гэтэл сүүлийн жилүүдэд, нийт эргэлтийн талбайн 50 орчим хувь ашиглагдахгүй болж, хүн амын хэрэгцээт гурил, төмс, хүнсний ногооны 50 хүртэл хувийг хангах төдийд хүрлээ. Манай улс 1996 онд үр тариа 225,0 мянган тонн, төмс 47,0 мянган тонн, хүнсний ногоо 22,6 мянган тонныг тус тус хураан авсан нь 1985-1990 оны жилийн дундажтай харьцуулахад үйлдвэрлэсэн үр тариа 3,4 дахин, төмс 2,7 дахин, хүнсний ногоо 2,0 дахин буурчээ. /Өрхийн орлогыг нэмэгдүүлэх “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр/.

2.5. Хоол хүнс хүрэлцээтэй байсан ч хэрэглэх хэмжээ, горим, түүний шимт чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлаас шалтгаалан элдэв өвчин, эмгэгийн гаралтад нөлөөлдөг. Хүн эрүүл байхын үндэс нь чанартай, цэвэр ариун хүнсийг зохистой хэмжээгээр зөв хэрэглэх явдал юм.

2004 онд УМХГ-ын хүнсний хяналт, шинжилгээнд 97451 дээжинд 238073 үзүүлэлт шинжлэгдсэний 16455 буюу 17%, хүнсний түүхий эдийн 463 дээжний 182 буюу 39% нь тус тус бохирдолтой гарсан байна. Үүнээс хүнсний нян судлалын шинжилгээнд хамрагдсан нийт 70926 дээжийн, 9.6% нь нянгийн бохирдолтой гарсан байна. Хүнсний химийн шинжилгээгээр 4.0%, хор судлалын шинжилгээгээр 10%, хүнд металлын шинжилгээгээр 0.9% нь тус тус бохирдолтой гарчээ. Үүнийг өмнөх онуудтай харьцуулахад химийн бохирдол 2002 оныхоос 2 дахин, хор судлалын шинжилгээгээр бохирдолтой дээжийн хувь 2000 оныхоос 0.2%-аар, 2002 оныхоос 0.8%-аар, нянгийн бохирдол 2000 оныхоос 0.2-аар, 2002 оныхоос 8%-аар, хүнд металлын бохирдол 2000 оныхоос 0.5-аар тус тус өссөн байна. /УМХГ-ын Хүнсний хяналтын 2004 оны тайлангаас/.

Хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин

Он	Хими	Хор судлал	Нян	Хүнд металл
2000		0,8 %	9,4 %	0,4 %
2002	2,0 %	0,2 %	1,6 %	
2004	4,0 %	1,0 %	9,6 %	0,9 %

Хүнсний бүтээгдэхүүний хор судлалын шинжилгээгээр ихэвчлэн элэгний хорт хавдрын гол шалтгаан болдог хөгц мөөгөнцрийн хорыг тодорхойлдог бөгөөд энэ үзүүлэлт сүүлийн жилд ихсэх хандлагатай байгаа нь анхаарал татаж байна.

Нэгдсэн төв лабораторийн хөгц мөөгөнцрийн шинжилгээнд 1040 дээж хамрагдсаны 6.8% нь хөгц мөөгөнцрийн бохирдолтой гарсны дотор цай, кофе, какао, үр тариа, улаан буудайн дээж хамгийн их бохирдолтой гарчээ /УМХГ-ын нэгдсэн төв лабораторийн 2004 оны тайлангаас/. Хорт хавдар үүсгэх, үр хөврөл гэмтээх, удамшилд аюул учруулах өвчин үүсгэдэг 150 гаруй хөгц мөөгөнцөр байдгаас өнөөгийн байдлаар лабораторийн шинжилгээгээр зөвхөн 13 төрлийн хөгцийг хоол хүнснээс илрүүлж чадаж байна /Г.Цэндсүрэн, Г.Батмөнх, НМХА, “Монгол улсын хүнсний аюулгүй байдал, хүнсний хяналтын тулмагдсан асуудлууд/.

НМХГ-ын Төв лабораторийн дүнгээр 2004 онд нян судлалын шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний нийт 5609 дээжийн 2059 буюу 36.7% нь нян судлалын үзүүлэлтээр хүнсний аюулгүй байдлын шаарлага хангаагүйн дотор 65.6%-д нь нянгийн ерөнхий тоо зөвшөөрөгдөх дээд хэмжээ(ЗДХ)-ээс хэтэрсэн, 20.9%-д E.coli (гэдэсний савханцар), 3.2%-д бацилус цереус (Bacillus cereus) 1.2%-д стафилококк ауриус(Staphylococcus aureus), махан консервийн 3 дээжинд энтерококк (Enterococcus) нянгийн бохирдол илэрсэн байна /НМХГ-ын төв лабораторийн 2004 оны тайлангаас/.

2.6. Дэлхийн ХХААБ-аас гаргасан мэдээгээр мал амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнээр хүнд дамжин халдварладаг 150 гаруй өвчин тэмдэглэгдсэнээс манай орны малд бруцеллёз, боом, ям сүрьеэ зэрэг өвчин нэлээд байдаг.

Малын халдварт болон шимэгчээр халдварлах өвчлөлийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна. Тухайлбал, мал сүрэгт сүүлийн 10 жилд цусан халдвар, бруцеллёз,

галзуу, сүрьеэ, адууны халдварт цус багасах өвчний гаралт 1.2-19.2 дахин өсч, халдварт өвчнөөр хорогдсон малын тоо нийт хорогдлын 30 хувийг эзэлж байна. Малаас хүнд халдварладаг бруцеллөз, сүрьеэ, ям, лейкоз зэрэг өвчнийг оношлох шинжилгээг зохих ёсоор хийхгүй байгаагаас эдгээр өвчнийг хянаж чадахгүй байна /"Малын эрүүл мэнд хөтөлбөр", 1999 он/.

Худалдан борлуулж байгаа нийт махны 40,0 гаруй хувь нь мал эмнэлгийн шинжилгээнд хамрагдаагүй, мах худалдан борлуулах зах, худалдааны цэг, салбарууд ихэвчлэн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ил задгай хог, шороо тоостой бохир орчинд, хөргөлтийн тоног төхөөрөмжгүй, худалдан борлуулагчид зориулалт-ын хувцас хэрэглэлгүйгээр худалдаалж байна /Ч.Содномцэрэн "Хүнсний аюулгүй байдал, баримтлах бодлого, чиглэл" илтгэл, "Хүнсний аюулгүй байдал" товхимол, 2001 он 17-р тал/.

Мал, амьтны гаралтай мах, сүү, өндөг зэрэг түүхий эдүүдийг мал-эмнэлгийн үзлэг шинжилгээнд тэр бүр бүрэн хамруулж чадахгүй байгаа бөгөөд үзлэг шинжилгээг иж бүрэн хийж чадахгүй зөвхөн мэдрэхүйн эрхтнээр үнэлгээ өгч дүгнэлт гаргаж байгаа дутагдал ажиглагдаж байна. Түүхий сүүг Улаанбаатар хот, хүн ам олноор төвлөрсөн хот, суурин газруудын гудамж талбайд ил задгай ямар ч зориулалтын байр, хөргөлтийн тоног төхөөрөмжгүй нөхцөлд, цэвэрлэгээ ариутгал хийгдээгүй сав суулганд, анхан шатны боловсруулалт хийгдэлгүйгээр, эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдаагүй хүний гар дээрээс худалдаалж байна.

Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 62.7% нь хууль тогтоомж, дүрэм заавар зөрчсөн, үүнээс 28.2% нь ямар нэг байдлаар стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн хэм хэмжээг хангаагүй орчинд үйл ажиллагаа явуулдаг байна. Тэрчлэн тухайн аж ахуйн нэгжүүдийн ажилтан ажилчид, удирдлагууд уг үйлдвэрлэлд тавигдах наад захын дүрэм журам, стандартын үзүүлэлтүүдийн талаар тун хангалтгүй ойлголт мэдлэгтэй байдаг. /Ч.Содномцэрэн "Хүнсний аюулгүй байдал, баримтлах бодлого, чиглэл" илтгэл, "Хүнсний аюулгүй байдал" товхимол, 2001 он 18-р тал/.

2.7. УМХГ-ын Нэгдсэн төв лабораторийн Таримал ургамлын үр, хорио цээрийн хяналтын лабораторийн 2004 оны тайлангийн мэдээгээр 10 аймаг, 86 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн 13103.9тн үр, үрийн материалыг төлөөлөх 592 дээжинд шинжилгээ хийсний дотор тарих үрийн 566, технологийн 3, хүнсний буудайн 11 дээжийг шинжлэхэд 97.8% нь стандарт, чанарын шаардлага хангаагүй байна.

2005 онд тариалах улаан буудайн 3559.7 тоннын 1, арвайн 163, 47.4 тоннын 2, овьёосны 81.4 тоннын 4, хөх тарианы 11.8 тоннын 1, төмсний 203 тоннын 2, хүнсний ногооны 11 төрлийн 2.05 тн 26 дээжний 62% нь стандартын шаардлага хангаагүй байна.

Ургамлын хорио цээрийн шинжилгээг дотоодын үйлдвэрлэлийн 12978.2 тн бүтээгдэхүүнийг төлөөлөх 14 нэрийн 162, импортын 134826.9 тн бүтээгдэхүүнийг төлөөлөх 54 нэрийн 2013, экспортын 17454.3 тн бүтээгдэхүүнийг төлөөлөх 15 нэрийн 225 дээж буюу нийт 2400 дээжинд хог ургамал, хөнөөлт шавьж, ургамлын өвчин, хорт бодисын үлдэцийг илрүүлж, тодорхойлох шинжилгээ хийхэд 1401 дээж буюу 58.3% нь гадаад болон дотоод хорио цээртэй хог ургамлын үр, ногоон, ягаан хөгц, шимэгчдийн үршил, хатуу харуу өвчин, агуулахын хачиг, номын бөөс зэрэг нь амьд, үхсэн хэлбэрээр илэрч стандартын шаардлага хангаагүй байна.

Шинжилгээгээр улсын нөөцийн агуулахад хадгалагдаж байгаа 9750.1 тн үр тариаг төлөөлөх 120 дээжинд 3 төрлийн хог ургамал 2450 ш/кг хүртэл хэмжээгээр, 5 төрлийн ургамлын өвчин 1-49% хувь хүртэл, агуулахын хачиг амьд, үхсэн хэлбэрээр, номын бөөс зэрэг хөнөөлт шавьж илэрчээ /УМХГ-ын Нэгдсэн төв лабораторийн Таримал ургамалын үр, хөрс үндэсний хяналтын лаборатарийн 2004 оны тайлан/.

2.8. 2003 онд 31 улсаас 27 төрлийн 146 нэрийн 81.138.2 тн хүнсний бүтээгдэхүүнийг импортолсны дөнгөж 16.4% нь лабораторийн шинжилгээнд хамрагджээ. Эдгээрээс химийн шинжилгээгээр шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний 31.2%, хор судлалын шинжилгээгээр 0.6%, нян судлалын шинжилгээгээр 5.3% нь хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй байна. Давхардсан тоогоор 64 аж ахуйн нэгжийн 207 импортын согтууруулах ундааг шинжлэхэд 7.0% нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна. /Д.Оюунчимэг, Г.Цэндсүрэн “Хүнсний аюулгүй байдлын тулгамдаж буй асуудлууд”, Зохистой, аюулгүй хоол хүнмээр жигд хүртээмжтэй хангагдах эрхийн төлөв байдал” уулзалт ярилцлагын материал, 2004 он/.

2004 оны эхний хагас жилийн байдлаар УМХГ-ын харьяа 23 лабораторид 53472 хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийсний 18% нь импортын хүнсний бүтээгдэхүүн эзэлж байгаа ба 120741 үзүүлэлтээр шинжилсний 16.7% нь чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй байна. Төрөлжсөн 6 лабораторид хийгдсэн шинжилгээний үзүүлэлтээр хөгц мөөгөнцрийн лабораторийн шинжилсэн сорьцын 18.9% хөгц мөөгөнцөрөөр бохирдсон байсан ба үүнийг хүнсний нэр төрлөөр нь авч үзэхэд цай кофе, какаоны 16.7%, жимс, жимсгэний 11%, бусад бүтээгдэхүүний 38.5%-д нь бохирдол илэрсэн байна /УМХГ-ын 2004 оны тайлангаас/.

2.9. Манай улсын хүн амын дунд хоол тэжээлийн дутал болон илүүдлээс үүдэлтэй эмгэгүүд аль аль нь тохиолдож байна. Хоол тэжээлийн дутал нь ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхний дунд уураг илчлэгийн дутал (УИД), цус багадалт, сульдаа, иод дутлын эмгэг (ИДЭ) зэрэг хэлбэрээр илэрч буй бол илүүдэл нь таргалалт, судасны хатуурал, цусны даралт ихдэх, харвалт, инсулин үл хамааралт чихрийн шижин, хавдар зэрэг хэлбэрээр тохиолдож байна.

Хоол тэжээлийн дутлын улмаас бага насны хүүхдийн оюуны болон биеийн хөгжил хоцорч улмаар тэдний ойлгох, санах, тогтоох чадвар аажим суларч, сурах чадварт сөргөөр нөлөөлдгийг дэлхий дахины олон судлаачид тогтоожээ. Мөн биеийн эсэргүүцэл сулран халдварт амархан өртөж олон дахин өвчлөх ба өвчин нь ужиг явцтай, дахих хандлагатай байдаг.

Хэдийгээр Хүүхдийн эрхийг хамгаалах тухай /1996/ хуулийн 14 дүгээр зүйлийн 4-ийн 3-т: “хүүхдийн өсөлт хөгжилт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн баталгаат хоол хүнс ... зэргээр хангах асуудлыг хүүхдэд үзүүлэх нийгмийн халамжийн арга хэмжээнд тусгасан байгаа боловч Хүнсний тухай хуульд хүүхдийн хоол тэжээлтэй холбоотой нэг ч заалт байхгүй.

Манайд “бичил тэжээлийн өлсгөлөн”, түүний дотор Иод дутлын эмгэг бодитойгоор оршиж буйг төрөөс онцгойлон анхаарч бодлого, хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд “Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай” хуулийг 2003 оны 10 дугаар сарын 10-ны өдөр баталж, иод дутлын эмгэгтэй тэмцэх үйл ажиллагааг хуулиар зохицуулжээ.

2.10. Эхийн сүү нь төгс тэжээллэг чанартай бүтээгдэхүүн бөгөөд эхийн сүүнд хүүхдийн биед шаардлагатай уураг, өөх тос, нүүрс ус, амин дэм, бичил тэжээлийг хамгийн зохистой харьцаагаар агуулсан байдаг тул хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтийг бүрэн хангаж чаддаг.

1995-1999 онуудад хүүхдийн хөхөөр хооллолтын байдлыг судалсан дүнгээс үзэхэд 2000 он хүртэлх 5 жилийн дунджаар нийт судалгаанд хамрагдсан хүүхдийн 92.6% нь төрсний дараа 30 минутын дотор хөхөө амласан байна. Эхний 4 сар хүртлээ дан хөхөөр хооллож байгаа хүүхэд 99.5%, 4-6 сар хүртлээ хөхөө хөхөж байгаа хүүхэд 96.7%, 6-9 сар хүртлээ – 93.1%, 9-12 сар хүртлээ – 92.9%, 2 нас хүртлээ – 75.9%-тай байгаа нь өмнөх онтой харьцуулахад буураагүй байгаа ч ерөнхийдөө хөхөө хөхөх байдал ой хүртлээ бага багаар буурсаар, 2 нас хүртлээ нилээд буурах хандлагатай байна /“Хүн амын хоол тэжээлийн байдал” Үндэсний судалгаа-2, НЭМХ, ХСТ, 2000 он/.

2000 онд хийсэн олон үзүүлэлт судалгаагаар 4 сар хүртэл дан хөхөөр хооллож байгаа хүүхэд 54% болсон байна. мөн 2001 онд зохион явуулсан “Хөхний сүү орлуулагч бүтээгдэхүүний хэрэглээ, маркетинг ба хөхөөр хооллолт” судалгаагаар 6 сар хүртэл дан хөхөөр хооллолт 32.6% болж жил дараалан буурч байгааг үндэслэн 4 сар хүртэл дан эхийн сүүгээр хооллох бодлогыг 6 сар хүртэл болгон өөрчилсөн байна /Н.Удвал “Эх, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн тулмагдсан асуудлууд, цаашид хийх үйл ажиллагаа” илтгэл, Хүүхдийн асуудлаарх үндэсний дээд хэмжээний чуулга уулзалт, УБ 2004 он, 38-р тал/.

2.11. Угжаар хооллож буй хүүхэд, халдварт, ялангуяа суулгалт болон амьсгалын замын өвчинд өртөмтгий, өвчлөмтгий болдог. ЭСОБ нь үнэ өртөг ихтэй, худалдан авах, бэлтгэх, хооллоход цаг хугацаа их шаарддаг зэрэг олон сөрөг үр дагавартай.

Манай оронд сүүлийн 5 жилд 13 орны 543.7 тн эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн импортоор орж ирсэн нь урьдах онуудаас даруй 6.6 дахин ихэсчээ.

2.12. Бага насны хүүхдийн УИД, цус багадалт, сульдаа өвчний тархалт нь тухайн улс орны эхчүүд, жирэмсэн эмэгтэй, бага насны хүүхдийн хооллолтын ёс жаяг, хоол тэжээлийн хангамжийн байдалтай салшгүй холбоотой юм.

Эцэг эхчүүд хүүхдээ хэрхэн хооллож буйг авч үзвэл: 4-12 сартай нийт хүүхдийн 43.3%-д нь тусад нь хоол бэлтгэж өгч харин үлдсэн хувь нь гэр бүлийн хоолонд оруулж байгаа нь хоол тэжээлийн дуталд орох эрсдлийг нэмэгдүүлж байна. Мөн нийт хүүхдийн 54.4% нь нэмэгдэл хоолыг бантан, зутангаар эхэлж, цаашид энэ хоолоороо 1 нас хүртэл дагнан хооллож байна. Харин нэг наснаас хойш гэр бүлийн хоолноос өгдөг байна. Бага насны хүүхдийн хоолонд хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, давтамжийг авч үзвэл: гурил, гурилан бүтээгдэхүүнийг 100%-д нь, мах, махан бүтээгдэхүүнийг 89.8%-д нь сүү, сүүн бүтээгдэхүүнийг 72.4%-д нь өдөрт 1-3 удаа тогтмол нэмэгдэл хоолонд хэрэглэж байна. Хүүхдийн хоол тэжээлд зайлшгүй шаардлагатай жимс, жимсгэнэ, хүнсний ногоог зөвхөн 21.9% нь хэрэглэсэн байна.

Энэ байдлаас харахад өдөрт цөөн удаа хооллож, голлон 2-3 нэр төрлийн илчлэг, тэжээлэг чанар муутай хүнсний бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар тогтмол хэрэглэж байгаа нь хоол тэжээлийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Улмаар энэ нь хоол тэжээлтэй холбоотой бусад өвчлөл, сульдаа, цус багадалт,

улмаар хоол тэжээлийн архаг дуталд орох нэг шалтгаан болж байна /"Хүн амын хоол тэжээлийн байдал" үндэсний судалгаа – 2, НЭМХ-ХСТ, 2000 он/.

2.13. Уураг илчлэг дутлыг тураал (ж/н <-2SD), өсөлтийн хоцрогдол (ө/н <-2SD), туранхай хүүхэд (ж/ө <-2SD) гэсэн үзүүлэлтүүдээр хэмжиж, үнэлдэг байна.

Монгол улсын засгийн газрын "Хүүхэд хөгжил хамгаалал үндэсний хөтөлбөр"-т 2000 он гэхэд 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн хурц дутал буюу тураалыг 1990 оны түвшнээс 50%-аар бууруулах зорилтыг тавьсан билээ.

1999 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн дунд тураал 12.5%, өсөлт хоцролт 24.6%, туранхай хүүхэд 3.7% байгаа нь 1997 оны үзүүлэлтүүдээс өсчээ. Харин 2001 онд хийсэн судалгаагаар тураал 6%, өсөлт хоцролт 22.3%, туранхай хүүхэд 0.9% болж тус тус буурчээ /Д.Эржен, Б.Энхтунгалаг, НЭМХ-ХСТ, "Төсөлд хамрагдах орон нутгийн 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн байдал" суурь судалгааны урьдчилсан дүнгийн илтгэл, "Хоол тэжээл-эрүүл мэнд" онол-практикийн бага хурлын илтгэлийн хураангуй, 2002 он, 44-р тал/.

УИД-ын тархалт төв суурин газраас, хөдөө орон нутагт хоёр дахин их тархалттай байна. УИД хотуудад 7.1% байсан бол аймгийн төвд 15.7%, суманд 19.4% буюу тураалтай хүүхдийн 97% нь аймгийн төв, суманд байдаг. Тураалтай, өсөлт хоцролттой, туранхай хүүхэд нэмэгдэл хоолонд орж, борог хоолонд шилжих шилжилтийн чухал үе болох 7 сартайгаас эхлэн 2-3 дахин өсч, 13-24 сартайд бусад насны бүлгээс хамгийн өндөр тархалттай байна.

Өдөрт 1-2 удаа хооллодог 6-12 сартай хүүхдийн 16.4% тураалтай, 32.8% нь өсөлт хоцорсон байхад 4-5 удаа хооллодог хүүхдийн тураал 4.4 дахин, өсөлт хоцролт 8.7%-аар бага байна.

Ядуу өрхийн хүүхдүүдийн тураалд өртөх магадлал 3 дахин их байна. Тураалд өртөж байгаа ядуу өрхийн 10 хүүхдийн 9 нь хөдөөд байна.

Зуданд нэрвэгдсэн бүс нутагт 5 хүртэлх насны хүүхдийн дунд тураал 15%, өсөлт хоцролт 36.1% байгаа нь зуданд нэрвэгдээгүй бүс нутгийн мөн насны хүүхдүүдийнхээс бага зэрэг их байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд 1999 оны судалгаатай харьцуулахад өссөн байна /Н.Болормаа ба бус НЭМХ-ХСТ "Хоол тэжээл- эрүүл мэнд" онол-практикийн бага хурлын илтгэлийн хураангуй, 2002 он, 31-р тал/.

2.14. Монгол улсын 5 хүртэлх насны хүүхдийн дунд нилээд их тархалттай байгаа рахит өвчин нь хүүхдийн хоол тэжээлийн дуталтай холбоотой өвчнүүдийн дунд гол байр суурийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан 5 хүүхэд тутмын нэгд нь яс зөөлрөх болон ясны хэлбэр алдагдлын аль нэг шинж тэмдэг илэрч байв.

1 хүртэлх насны 4 хүүхэд тутмын нэг нь рахит өвчинд өртөж байна.

Тураалтай хүүхдийн 36.5%, өсөлт хоцорсон хүүхдийн 30.8% нь сульдаа өвчинтэй байхад тураалгүй хүүхдийн уг өвчлөл 14.9%-аар, өсөлт хоцролтгүй хүүхдийн өвчлөл 10.7%-аар бага байна. Мөн 4 сар хүртэл дан хөхөө хөхсөн хүүхдүүдийн 14.4% сульдаа өвчинтэй байсан бол дан хөхөөр хооллоогүй хүүхдүүдийн уг өвчлөл 2.2 дахин их байсан ба харин 6 сар хүртэл дан хөхөө хөхсөн хүүхдийн өвчлөл 2.6%-аар бага байна /Д.Эржен, Б.Энхтунгалаг, НЭМХ-

ХСТ, “Төсөлд хамрагдах орон нутгийн 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн байдал” суурь судалгааны урьдчилсан дүнгийн илтгэл, “Хоол тэжээл-эрүүл мэнд” онол-практикийн бага хурлын илтгэлийн хураангуй, 2002 он, 44-р тал/.

2.15. Зохистой хоол хүнс нь хүний бие махбод, түүний эрхтэн системийн хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай байдаг.

Манай оронд 1960-аад оны сүүлчээс эхлэн хүн амын хоол тэжээлийн бодит байдлыг тодорхой бүлэг хүмүүсийн илч зарцуулалттай холбон судалж иржээ.

ЭМНХЯ-ны сайдын 1997 оны А/318 тоот тушаалаар баталсан “Хүн амын хоол тэжээлийн зөвлөмж хэмжээ”-д заасан “Жишсэн дундаж хүнд хоногт ноогдох хүнсний бүтээгдэхүүний жагсаалт”-аар насанд хүрсэн хүн хоногт дунджаар 230 гр мах, махан, 380 гр гурил, гурилан, 340 гр сүү, сүүн бүтээгдэхүүн, 27 гр цөцгийн тос, 60 гр сахар чихрийн зүйл, 120 гр төмс, 200 гр хүнсний бусад ногоо, 25мл ургамлын тос, 45 гр будаа, 280 гр жимс, 4 гр загас, загасан бүтээгдэхүүн, 7 гр өндөг хэрэглэснээр 104.85 гр уураг, 76.23 гр өөх тос, 406.74 гр нүүрс ус бүхий 2731.18 ккал илчлэгийг хоол хүнсээрээ авч байхыг тогтоосон байна.

Хүнсний бүтээгдэхүүний илчлэг, шимт чанарыг судлахад: хоногийн хэрэгцээт илчлэгийн 86.2%, уургийн 76.0%, өөх тосны 120.8%, нүүрс усны 74.2%, эслэгийн 1.1%, А аминдэмийн 33.5%, С аминдэмийн 83.3%, В1 аминдэмийн 71.1%, В2 аминдэмийн 83.3%, фосфорын 62.2%, төмрийн 70.0%-ийг хангаж байна. Өөрөөр хэлбэл дээр дурьдсан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотойгоор зарим аминдэм, эрдэс бодисын хангамж зөвлөмж хэмжээнээс доогуур байна.

Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ өрхийн орлогоос хамааралтай байсан ба өрхийн нэг гишүүнд оногдох сарын дундаж орлого багасах тутам хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хэрэглэх хэмжээ эрс буурч байна. Тухайлбал: хотын АБТ-ээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүн нь дээгүүр орлоготой өрхийн нэг гишүүнээс төрөл бүрийн хүнсний ногоог 1.9, ургамлын тосыг 3.7, жимс, жимсгэнийг 6.2, сүү, сүүн бүтээгдэхүүнийг 4.7 дахин бага хэрэглэж байна.

Үүнийг илчлэгийн зөвлөмж хэмжээтэй харьцуулахад хотын АБТ-ээс дээгүүр орлоготой өрхийн нэг гишүүний хоногийн хоолны илчлэгийн хангамж 135% буюу ДЭМБ-ын зөвлөмжөөр физиологийн нормоос хэтэрсэн, харин АБТ-ийн өрхийн нэг гишүүний хоногийн хоолны илчлэгийн хангамж 96.2% буюу физиологийн нормыг хангаж байхад АБТ-ээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүний хоногийн хоолны илчлэгийн хангамж дөнгөж 68.5%-тай тэнцүү буюу физиологийн нормоос ихээхэн доогуур байна /“Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний судалгаа – 2, НЭМХ-ХСТ, 2000 он/.

ГУРАВ. АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус Комиссын 2004 оны ээлжит гуравдугаар илтгэлд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг тусгаж байсан учраас энэ удаагийн илтгэлд аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой зарим асуудлыг авч үзэж байна. Аюулгүй орчинд амьдрах эрхэд хүний амьдрал, үйл ажиллагаа,

орчинтой холбоотой олон багц асуудлууд багтах нь мэдээж. Энэ удаад Улаанбаатар хотын барилга байгууламж, шатахуун түгээх станц, зам тээврийн нөхцөл байдал нь хүний аюулгүй орчинд амьдрах эрхэд хэрхэн нөлөөлж буйг гаргаж тавихыг зорьсон болно.

3.1. Улаанбаатарт 1950-1960-аад онуудад баригдсан барилгуудын чанар муудаж, газар доогуурх байгууламжуудын хугацаа дууссаны дээр сүүлийн үед баригдаж байгаа барилга байгууламж, орон сууцыг стандарт зөрчиж, чанар муутай бүтээгдэхүүн, хийцээр барьж буй талаар ихээхэн шүүмжлэл гарах болсон. Зарим барилгын тааз, дээвэр нурсан, шинээр орсон орон сууцны байрны ханын наалт, өнгөлгөө салхи шуурганд хуурсан, орон сууцны дээд давхарт бороо, цасны ус гоождог, ханын өрлөгийн тооцоо буруу хийгдэж, өрлөгийг дахин дахин буулгасан зэрэг барилгын хийц, чанартай холбоотой олон зөрчил гарсаар байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд нийтийн орон сууцны зориулалтаар баригдсан барилгын нэгдүгээр давхрын хана бэхэлгээг нурааж, зориулалтыг өөрчлөн үсчин, хоолны газар, эмийн сан, худалдааны цэгүүд болгох нь олшров. Орон сууцны даацын ханыг дур мэдэн буулгах, цоолох, шинээр хаалга гаргах, цонх, өрөө, тасалгаа үүсгэх нь ердийн үзэгдэл болжээ. Энэ нь тухайн байранд амьдардаг оршин суугчдын сэтгэлийг түгшээж, амар тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг алдагдуулж байна. Зарим барилгад иймэрхүү өөрчлөлтөөс болж ан цав үүссэн тохиолдол ч гарсан байна. Баянзүрх Дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 60 айлын орон сууц (хуучнаар ХААЯамны ажилчдын байр) -ны 1-р давхрын эргэн тойрны даацын хананд шинээр бэхэлж барьсан 16 үйлчилгээний газар ажиллаж, орон сууц руугаа дотогшоо ордог 12 хаалга шинээр гаргасан учир даацын ханын бөх бат чанар үндсэндээ алдагджээ.

Улаанбаатар хот газар хөдлөлийн идэвхитэй бүсэд оршдог учраас барилгын зориулалтыг өөрчилж, даац, бэхэлгээнд нь ийм маягаар нөлөөлөх нь болзошгүй эрсдлийг ихэсгэх нь ойлгомжтой.

Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашиглахаар хана бэхэлгээг нь буулгаж, зориулалтыг нь өөрчилсөн зэрэг ноцтой зөрчил дутагдалтай 40, 50 мянгат болон багатайруу /хуучнаар 40 мянгатын эмийн сангаас Баруун дөрвөн зам хүртэлх/ уртаараа 1.5 км, төв замаасаа урагш, хойш чиглэлд 150-160 м өргөн, 30 гаруй га газар хамарсан/ одоогийн Энхтайвны өргөн чөлөөнд байрлах 2-4 давхар барилгууд мэргэжлийн хүмүүсийн үнэлгээ дүгнэлтээр 4-6 баллын хүчтэй газар хөдлөлт болон ердийн үер ус, хүчтэй салхи зэрэг байгалийн гамшиг тохиолдоход иргэдийн амь насанд аюул учруулахгүй гэхийн баталгаагүй байна.

3.1.1. Техникийн бичиг баримт дутуу, техникийн нөхцөл аваагүй буюу зураг төслийн иж бүрдэл дутуу, зураг төслийн боловсруулалтанд барилгын норм ба дүрэм зөрчсөн, мөн техникийн үндсэн шийдлийн алдаа зөрчил гаргах, улсын экспертизийн албаар хянагдаж баталгаажгаагүй, галын болон эрүүл ахуйн байгууллагаас холбогдох зөвшөөрөл аваагүй зураг төслөөр барилга угсралтын ажил гүйцэтгэсэн зэрэг зөрчлүүд байнга гарч буйг мэргэжлийн байгууллагуудын хийсэн шалгалтаас үзэж болно.

Барилгын тухай хуулийг зөрчин барилга угсралтын ажлыг эхлэх үргэлжлүүлэх, барилга угсралтын ажил гүйцэтгэх явцад зураг төсөл зохиогчийн зөвшөөрөлгүй дураараа зураг төслийг өөрчлөн зөрчих, зураг төсөлгүй байхад барилга барих,

угсралтын ажлын үед техникийн үндсэн шийдлийн алдаа гаргах, инженерийн тооцооны схемыг өөрчлөх зэрэг зөрчлүүд ихсэх хандлагатай болжээ.

Түүнчлэн барилга угсралтын ажлын технологи зөрчин ноштой алдаа гаргах, барилга угсралтын ажлын үе шат тутамд далдлагдсан ажлын актыг бичихгүй байх, ил далд ажлын актыг холбогдох хүмүүсээр баталгаажуулахгүй байх, захиалагчийн хяналтыг барилгын инженерийн мэргэжлийн хүмүүсээр хийлгэдэггүй зэрэг нийтлэг ноштой зөрчил дутагдал ч байсаар байна.

3.1.2. Үүний зэрэгцээ өргөх шатны /лифт/ ашиглалтын талаархи дүрмийн заалтуудыг зөрчсөн нийтлэг эвдрэл, дутагдлууд их байна. Лифтийн хонгилын гэрэлтүүлэг шатсан, бүхээг болон хонгилийн хаалганы босгоны зай зөвшөөрөгдөх хэмжээнээс 50-100 мм-ээр их, башмак элэгдсэн, хаалга цоожлогддоггүй, тросс сунасан байх нь ердийн үзэгдэл бөгөөд энэ лифт ашиглалтын дүрмийг зөрчиж, улмаар аюултай байдлыг бий болгодог.

3.1.3. Барилга байгууламж, түүний дотор орон сууцны стандарт, чанарын шаардлага хангасан хийц, материалаар баригдахгүй байгаа талаар мэргэжлийн байгууллага, оршин суугчдын зүгээс шүүмжлэл, гомдол их гарч байна. Түүнчлэн зарим орон сууцны барилгууд салхивчгүй, чийг цохидог, бохир хаягдлын цэг айлуудын хаалганд хэт ойр байрлалтай, агааржуулагч болон тусгаарлагчгүй байгаа нь иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй. Эдгээр нь нэг талаас барилгын үйлдвэрлэл эрхэлдэг компаниуд нийгмийн эрэлт хэрэгцээг далимдуулан барилгад тавигдах стандарт, норм, үйл ажиллагааны горимыг зөрчин ашгийн хойноос хөөцөлдөж байгаа нөгөө талаас барилгын үйлдвэрлэлд тавих төрийн хяналт илт сул байгаатай холбоотой юм.

3.2. Нефьт болон нефьтийн гаралтай бүтээгдэхүүнийг тогтоосон стандарт, горимд нийцүүлэн хадгалж, түгээж чадаж буй эсэх нь иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхтэй шууд холбоотой асуудал.

Шатахуун түгээх станц нь шатахууныг хүлээн авах, савлах, хадгалах, хэрэглэгчдэд жижиглэн худалдаалах зориулалттай барилга, байгууламжийн цогцолбор юм.

Өнгөрсөн онд Улаанбаатар хотод улсын үзлэг шалгалтад 193 ШТС хамрагдсанаас 124 нь зураг төсөлгүй, аюулгүйн зай, хэмжээний дүрэм зөрчсөн нь шалгалтаар тогтоогдсон.

Нийслэл хотын гурван дүүрэгт ажилладаг 17 шатахуун түгээх станцыг судалж үзэхэд 15 ШТС нь /орон сууц барилга, дэлгүүр, үйлчилгээний газар болон бусад хүн ам олноор төвлөрөх газарт 5-30 метр зайд байрласан байлаа. Зөвхөн 2 станц л үйлчилгээний газраас 50 метр зайд баригджээ /Стандарт МНС 4628-98-д зааснаар ШТС нь үйлчилгээний газраас 50 метрийн зайд баригдсан байх шаардлагатай/.

Санал асуулгад оролцсон иргэдийн дийлэнхи нь буюу 62% нь ШТС-ууд орон сууцны барилгатай хэт ойр /5-40м/ байрлаж буй нь тэдний аюулгүй байдалд сэтгэл түгшээдэг гэж үзсэн байна.

3.3. Монгол улсад 2004 онд нийт 120418 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 67361 тээврийн хэрэгсэл байгаа нь улсын хэмжээний нийт автомашины 55.9 хувийг эзэлж байна.

Автомашины төрөл

№	Автомашины төрөл	2004 он		
		Улс		Улаанбаатар хот
		тоо	тоо	Улсын дүнд эзлэх хувь
1	Суудлын	79691	49123	61.4
2	Нийтийн тээврийн автобус	10645	6553	61.6
3	Ачааны	25430	9658	38.0
4	Тусгай зориулалтын	4652	2027	43.6
Дүн		120418	67361	55.9

(Монгол улсын автотехникийн үзлэг, тооллогын нэгдсэн товчоо, 2004 он)

Улаанбаатар хотод нийт тээврийн хэрэгслийн 79.4% нь 7-оос дээш жил эдлэсэн, хуучирч өвгөрсөн автомашинууд байна. Шинэ буюу 3 жил хүртэл ашиглагдсан автомашин нийт паркийн дөнгөж 7.8% - ийг эзэлж байна.

Автомашины насжилтын судалгаа, 2004 оны байдлаар

№	Насжилт (он)	Улс		Улаанбаатар хот	
		Автомашины тоо	Хувийн жин, %	Автомашины тоо	Хувийн жин, %
1	3 жил хүртэл	16502	13.7	5266	7.8
2	4-6 жил	21632	18.0	8620	12.8
3	7-10 жил	29141	24.2	16547	24.6
4	11-ээс дээш жил	53143	44.1	36928	54.8
Бүгд		120418	100.0	67361	100.0

(Монгол улсын автотехникийн үзлэг, тооллогын нэгдсэн товчоо, 2004 он)

Автомашины тоо огцом өсч, гудамж замын хөдөлгөөний нягтрал үлэмж нэмэгдэж буй нь дараах сөрөг нөхцөл байдлыг бүрдүүлж байна.

- Агаарын бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс үлэмж давсан
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудал хурцаар тавигдаж, улмаар хүний амь нас, эрүүл мэндэд бодит эрсдэл, аюулыг бий болгосон.

Хөдөлгөөнт эх үүсвэр, ялангуяа насжилт өндөртэй автомашинаас ялгаруулах утаанд агуулагдах хорт бодисын хэмжээ Улаанбаатар хотын агаарын бохирдлын 40 орчим хувийг эзэлж байна.

3.4. 2004 оны байдлаар Улаанбаатар хотод 361.1 км хатуу хучилттай авто зам ашиглагдаж байна. Үүнээс асфальтан зам 300.4 км, бетонон зам 60.7 км болно. Мөн дагуул хот, тосгоны шороон хучилттай зам 78.0 км байдаг. Нийт 50 гүүртэйгээс 44 нь төмөр бетонон, 6 нь модон гүүр байна.

Нийслэл хотын авто замын ангилал, урт

№	Ангилал	Урт (км)	Хувийн жин (%)
1	Улсын чанартай авто зам (хатуу хучилттай)	54.45	15.1
2	Хотын чанартай авто зам (хатуу хучилттай)	202.65	56.1
3	Дүүргийн ба тусгай зам (хатуу хучилттай)	104.00	28.8
4	Дүн	361.10	100.0

(Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын газар, 2004 он)

Нийслэлийн гудамж, авто замын сүлжээ, тэдгээрийн техникийн түвшин нь хөдөлгөөнт эх үүсвэрийн тоо хэмжээ, ачаалал, хөдөлгөөний эрчмээс илт хоцорсон, замын эвдрэл их байгаа зэрэг нь байнгын авар ослыг нөхцөлдүүлж байна. Түүнчлэн замын сүлжээг хот байгуулалтын төлөвлөлт, нормативын хэмжээнд зохицуулах бодлого алдагдаж, зарим үед газар олголт, хот төлөвлөлтийн урагшгүй үйл ажиллагаанаас болж зам, гудамж талбай нарийсч, хөдөлгөөний нягтралын улмаас ачааллаа даахгүй болсон нь зам тээврийн осол өсөхөд шууд нөлөөлж байна.

Улаанбаатар хотын замын хөдөлгөөний зохицуулалтыг Замын Цагдаагийн Газраас зохион байгуулж гүйцэтгэж байна. Улаанбаатар хотод гудамж замын хөдөлгөөний хяналт зохицуулалтын байнгын пост 12, нийт замын сүлжээнд 275 зохицуулагч, офицерууд хоёр ээлжээр ажилладаг.

Сүүлийн жилүүдэд замын тэмдэглэгээг элэгдэлд тэсвэртэй, удаан эдэлгээтэй термо будгаар тавьж байгаа боловч замын тэмдэг, тэмдэглэл амархан өнгө үзэмжээ алдаж мууддаг, байнга сэргээх ажил хийгдэхгүй байгаа.

Явган зорчигчдод зориулсан замын зорчих хэсгийн тэмдэглэгээнүүд бүдгэрч арилсан, сэргээн засварлах ажил хийгддэггүй, уулзварууд дээр автомашины жолооч нар замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу хурд сааруулах, явган зорчигчдод давуу эрхийг нь эдлүүлдэггүй зэрэг ноштой зөрчил дутагдал нь зам тээврийн осолд шууд нөлөөлж байна.

Зам тээврийн ослын улмаас учирсан хохирол

№	Үзүүлэлт	ЗТО-ын тоо				
		2000	2001	2002	2003	2004
1	ЗТО-оор нас барсан хүний тоо - Улсын хэмжээнд - УБ хотын хэмжээнд	338	335	327	391	385
		141	97	122	145	102
2	Хүнд, хөнгөн гэмтсэн хүний тоо - Улсын хэмжээнд - УБ хотын хэмжээнд	1616	1812	1636	1224	2312
		940	1078	818	692	1119
3	Материалын хохирол, сая.төгрөг - Улсын хэмжээнд - УБ хотын хэмжээнд	483.2	289.7	658.3	729.9	354.3
		215.6	127.6	384.4	424.4	127.4

(ЗЛГ, О.Батжаргал, 2000 – 2004 он)

Судалгаа, тооцооноос үзэхэд манай улсад, үүний дотор нийслэл Улаанбаатар хотод ЗТО-ын гаралт харьцангуй өндөр, ослын хор уршиг гүнзгийрч байгаа нь анхаарал татсан асуудал юм. Иймд ЗТО-ын эх үүсвэр, шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг нарийвчлан судалж ЗТО-оос урьдчилан сэргийлэх ажлыг байнгын системтэй зохион байгуулах явдал нэн чухал байна.

ЗТО-ын хор уршиггүй ЗТО-ын 100 гэмтэл болон 100 тохиолдол бүрт ногдох нас баралтын тоогоор үнэлдэг байна.

Хүн ам ба автомашины тооны харьцаанаас хамааралтайгаар ЗТО - оос нас барах магадлал манай улсад бусад орнуудаас 14% өндөр байна.

Улаанбаатар хотод ЗТО-д өртөгдөх магадлал ихтэй нийгмийн эмзэг бүлэгт хамаарах хараагүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал онцгой байр эзэлж байна. Иймд хараагүй хүмүүсийн үйлдвэр ба нийтийн байр (Хан-Уул дүүрэг), хараагүй хүүхдийн сургууль (Сүхбаатар дүүрэг)-ийн орчим замын хөдөлгөөний нөхцлийн байрлал зүйн болон зорчих хэсэгт тусгайлан судалгаа явуулав.

Хараагүй хүмүүс ажилдаа ирэхийн тулд 1-2 автобус дамжиж, Үйлдвэр Комбинатын автобусны буудалд буугаад, 5-6 уулзвар гарч нэвтэрч, хөдөлгөөний эрчим ихтэй 2 зам, Дунд голын гүүрийг гатлан үйлдвэр ба байрандаа очдог. Энэ чиглэлд хийсэн судалгаагаар хараагүй бүү хэл хараатай хүн давж, тээглэж ойчихоор 27 саад байв. Хараагүй хүнийг зам, уулзвараар хөтлөөд, гаргаад өгдөг хүнгүй, автомашинууд зам тавьж өгдөггүй зэргээс нэг зам хөндлөн гарахын тулд 2 цаг хүртэл хүлээх тохиолдол гардаг гэж хараагүй хүмүүсийн үйлдвэрийн ажилчин Ж ярьсан юм (ярилцлагаас).

Хараагүй хүмүүсийн зорчих замын дагуу 2004 оны 1-р сарын 12-17-ны өдрүүдэд хийсэн ажиглалтаар үйлдвэрийн гол хаалга, ажилчдын байрны хооронд олон төрлийн хавтан саадтай, урд зам өөд гарах хажуу налуу (10x20м) цул мөстсөн, замын 2 хэсэгт “Хараагүй хүн” гэсэн замын тэмдэгтэй боловч хурдыг хязгаарласан заалт тэмдэггүй, Дунд голын гүүрний чиглүүлэх хашлага, хаалт эвдэрч, тоногдсон учраас хараагүй хүн эрэг, хажуу руу унах боломжтой, гүүрний эцэст барилгын хавтан овоолж, хашаа тулган барьсан, урд зам дээрх “Хараагүй хүн” гэсэн тэмдэгийг авч, тоносон байв. Мөн энэ замын урд “Дугуй засварын газар” ажиллуулж байгаагаас үйлчлүүлэх автомашинууд орж, гарах 3 салаа зам гарсан, замын хаалт, бродюрыг эвдэж, зайлуулж хаяжээ. Тэрчлэн өмнөх орон сууцны хорооллын дундуур хараагүй хүнд зориулсан зам, хаалт байхгүй, эндээс 5-6 уулзвар, гарцыг гатлан замдаа 50-60см өндөртэй траншейны цементэн таг, замын хашлага 12-ыг давж 710 м замыг туулан сая автобусны буудал хүрнэ.

Хараагүй ба сонсгол муутай хүүхдүүдийн сургууль (29 ба 116-р сургууль), Сүхбаатар дүүргийн 100 айл орчимд бий. 116-р сургуульд хараагүй 75 хүүхэд сурдаг. Үүнээс 40 хүүхэд нь тэндээ дотуур байранд амьдардаг. Үлдсэн 35 хүүхэд нь өдөр бүр хотын бүх дүүргээс эцэг эх, хүнээр замчлуулан сургуульдаа ирдэг байна.

100 айлын автобусны буудлын орчимд замын 2 талд “Хараагүй хүн” тэмдэгтэй, явган хүний гарштай, автобусны буудлаас сургууль хүртэл 170м зайтай. Энд уулзварын хойд эхэнд замд тулган хашаа шинээр барьсан, барилгын суурь хавтан буулгасан, замын дагуу контейнер, хашлага саад 16 байгаа бөгөөд хараагүй хүний зориулалтын замгүй тул явах боломжгүй хүндрэлтэй газар юм.

Энэ бүхэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд багачуудын амь нас, эрүүл мэндэд бодитой аюул, эрсдлийг бий болгож байна.

"Хүний Эрхийн Үндэсний Комисс ба Хүний Эрхийн Төрийн Бус Байгууллагуудын хамтын ажиллагаа" сэдэвт Бага хуралд оролцогчдоос Монгол Улсын Засгийн Газарт хандаж гаргасан

ШААРДЛАГА

2005-06-28

Улаанбаатар хот

Улсын Их Хурлаас Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний Хөтөлбөрийг 2003 оны 10-р сарын 24-ний өдөр баталсан явдал бол хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиулэн дэмжих салбарт гарсан онцгой үйл явдал гэдгийг Бага хуралд оролцогч бид онцлон тэмдэглэж байна.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг баталснаас хойш хоёр дахь жилийн нүүрийг үзэх гэж байгаа хэдий ч тус Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэнд нь хяналт тавих, шинжилгээ хийх Үндэсний Хөтөлбөрийн Хороог өнөөг хүртэл байгуулаагүйгээс хүний эрхийг хамгаалах төрийн бодлого хэрэгжихгүйд хүрч буйд Бага хурлын оролцогчдын зүгээс сэтгэл зовинож буйгаа илэрхийлж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулахгүй байгаа, хүний эрхийн ноцтой зөрчлүүд ихээр гарч буйд Монгол Улсын Засгийн газрын зүгээс яаралтай анхаарал хандуулах шаардлагатай болохыг Бага хурлын оролцогчид цохон тэмдэглэж байна.

Хүний эрхийг хангах үндэсний Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөний хамгаалалтыг сайжруулах чиглэлээр нэн даруй арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн Газраас шаардаж байна. Үүнд:

1. Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний Хөтөлбөрийг нэн яаралтай хэрэгжүүлж эхлэх, юуны өмнө Үндэсний Хөтөлбөрийн Хороог төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн өргөн оролцоотойгоор байгуулж, ажилд нь оруулах;
2. Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний Хөтөлбөрийг өргөн олон нийтэд сурталчлах, таниулах чиглэлээр төрийн байгууллагын зүгээс эрчимтэй ажил зохион байгуулж эхлэх;
3. Хөтөлбөрт тусгагдсан ёсоор төрийн төв болон орон нутгийн засаг, захиргааны байгууллагад хүний эрхийн асуудлыг хариуцсан тогтолцоо, бүтцийг бий болгон ажиллуулж эхлүүлэх;
4. Засгийн газрын зүгээс Хүний эрхийг хангах үндэсний Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авсанаа олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх.

БАГА ХУРАЛД ОРОЛЦОГЧИД

**“ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХАМГААЛАХАД ОРОН НУТГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ҮҮРЭГ” СЭДЭВТ СУРГАЛТАД БАЯН-ӨЛГИЙ, ХОВД, УВС
АЙМГУУДЫН СУМДААС ОРОЛЦСОН ОРОЛЦОГЧДЫН УРИАЛГА**

Улаангом

2005- 06-21

НҮБ-ын гишүүн Монгол Улс Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалыг хэрэгжүүлэх үйлсэд амжилт олсоор байна. Тухайлбал, Монгол Улсын Их хурал 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр” баталсан. Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ-тэй хамтран Монгол Улсад хүний эрхийг хангах төсөл хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгч байгааг бид тэмдэглэж байна. Хүний эрхийг хангах, хамгаалахад манай улсын төр, орон нутгийн болон төрийн бус байгууллагууд цаашид ч олон улсын болон гадаадын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллах хэрэгтэй байгааг амьдрал харуулж байна.

Улаангомд энэ 6 дугаар сарын 20–21-ны өдрүүдэд хүний эрхийг хангах төслийн хүрээнд болсон сургалтад оролцогч бид дараах уриалгыг гаргаж байна.

1. Хүний эрхийг хангахтай холбогдуулан гаргаж байгаа хууль, эрх зүйн шийдвэрүүд амьдралд хэрэгжин биелэгддэг, хоорондоо уялдаа холбоотой байхад анхаарах.

2. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, биелэлтэд нь хяналт шинжилгээ хийх Үндэсний хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаа, орон нутаг дахь хүний эрхийн байгууллагуудад түүний үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэгийг идэвхжүүлэх.

3. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дээрээ хүний эрхийг сахин хамгаалах, хангах талаар нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагуудын харилцан ажиллагааг иргэдийн эрх ашигт нийцүүлэн уялдуулан ажиллах, ИТХ-аас хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын туршлагаа солилцох, иргэд байгууллагын санаачлагыг дэмжих үндсэн дээр боловсрол, эрүүл мэнд, соёл, нийгмийн хамгааллын үйлчилгээг сумдад голлон төвлөрүүлж, багийн нийтийн хурлыг бэхжүүлэх.

4. Орон нутагт хүний эрхийг хангах, хамгаалахад гарах зардлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн төсөвт тусгуулж ажиллах.

5. Энэ уриалгыг иргэд, төрийн, орон нутгийн болон төрийн бус байгууллагууд бүх талаар дэмжин хэрэгжүүлэхийг уриалж байна.

СУРГАЛТАД ОРОЛЦОГЧИД



НҮ ХХ нь илүү өндөр амьдрал, нөөцийн хангамж, улс орнуудын өмнөх зорилгыг олон нийтийн хамт олох замаар илүү сайн амьдралыг амьдралын доголлон байгуулахад хүмүүст туслах зорилго бүхий НҮ -ын дэлхий нийтийн хөгжлийн сэлжээ юм.

Эрхэм Уншигчид аа!

Та бүхэн манай сэтгүүлийн талаарх санал, үзэл бодлоо доор хаягаар ирүүлнэ үү.

Хүний Эрхийн Үндэсний Комисс

Хаяг: Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 318082, 262971

Факс: 327136, 320284

Цахим шуудан: nco@mongol.net

Цахим хуудас: <http://www.nhrc-mn.org>